

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2013 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР

Лиахона

Есүс Христ: Гэтэлгэгч
ба Үлгэр жишээ
үзүүлэгч, х. 18, 26

Найз нар бол . . . хүмүүс, х. 52

Та хөрвөсөн уу? Үүнийг
мэдэх 10 арга зам, х. 56

Ариун сүмийн тухай хүүхдүүдтэйгээ
ярилц, х. 62, 64



*“Христийн
Гэрэл бол
Есүс Хрис-
тээр дамжин
Бурханаас
ирдэг тэнгэр-
лэг хүч буюу
нөлөө юм.
Энэ нь бүх
зүйлд гэрэл
ба амьдралыг
өгдөг билээ.”*

Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын Ахлагч Ричард
Г. Скотт “Ухамсрын амар
амгалан ба оюун ухааны
амар амгалан” *Лиэхона*,
2004 оны 11-р сар, 15.



ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас**
бичиг: Тэр Амилсан
Ерөнхийлөгч Хенри Б.Айринг
- 7 Айлчлагч багшийн захиас**
бичиг: Ариун сүмийн
гэрээнүүд

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 12 Үхэл ба амьдрал:**
Амилуулалтын талаарх
анхдагчдын үзэл бодол
Анхдагчид болон эрт үеийн
бошиглогчид амилуулалтанд
найдвар тавих тухай гэр-
чилж байна.

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн дээр: Тим Тагарт © IRI. Ар талд:
Маттью Рейерийн гэрэл зургийн чимэглэл.
Нүүрэн хавтасны дотор талд: Кристин
Самскийн гэрэл зураг.

- 18 Есүс Христийн үүрэг**
зорилго ба үйлчлэл
Ахлагч Рассел М.Нелсон
Бид Аврагчийг дагах болон
Түүний Цагаатгалыг ойл-
гохын тулд Түүний амьдра-
лаас таван зүйлийг даган
дууриаж болно.

- 26 Христийн Амилалтын**
баярын долоо хоног
Аврагч амьдралынхаа сүүл-
чийн долоо хоногт хамгийн
агуу гайхамшигийг үйлдсэн юм.


- 30 Баптисмд бэлтгэхэд**
хүүхдүүдэд туслах нь
Жессика Ларсен,
Марисса Виддисон
Хүүхдүүдийнхээ баптисмыг
улам утга учиртай болгохын
тулд эцэг эхчүүд юу хийж
болох вэ?

- 34 Ариун сүмд ойр бай**
Ахлагч Жейро Мазагарди
Хөрвөлтөд Ариун сүм хэрхэн
тусалж болохыг мэд.

ХЭСГҮҮД

- 8 Дөрөвдүгээр сарын**
Чуулганы тэмдэглэлээс:
Чуулган дээр хэлсэн үгсийг
хамтдаа судлах нь
Грег Батти
- 9 Залуучуудын бат бөх байд-**
лын төлөө товхимлоос заах
нь: Сайн найз нар хэчнээн
чухал болох тухай өгүүлэхүй
- 10 Бид юунд итгэдэг вэ?: Ариун**
Сүнс тайтгаруулж, сүнслэг
нөлөө үзүүлэн, гэрчилдэг
- 36 Хожмын Үеийн Гэгээнтнүү-**
дийн дуу хоолой
- 74 Сүмийн мэдээ**
- 80 Биднийг дахин уулзалт:**
Усан оргилуураас уух нь
Аарон Л.Вест

40



- 40 Илүү сайныг сонгох нь**
Маттью Д.Элиттон
Золтан Есүс Христийн сайн мэдээнд бүрэн итгэлтэй байхын тулд зарим зүйлсийг орхих хэрэгтэй болжээ.

52



- 42 Асуулт, хариултууд**
Ариун явдлын хуулийг зөрчих нь яагаад ноцтой нүгэл болохыг би найздаа яаж тайлбарлах вэ?
- 44 Санваарын дуудлагадаа хэрхэн үйлчлэх вэ?**
Ерөнхийлөгч Томас С.Монсон
Үйлчилдэг хүмүүстээ хэрхэн туслах болон заахыг мөн амьдралд нь хэрхэн нөлөөлөхийг сурч мэд.
- 45 Бидний орон зай**
- 46 Мормоны Ном бидэнд яагаад хэрэгтэй вэ?**
Дөрвөн шалтгааны улмаас Мормоны Ном нэн чухал юм.
- 48 Угандад Сүм эрч хүчээ аван хөгжиж байна: Энэ орны итгэлтэй өсвөр үеийнхэн**
Синди Смит
Эдгээр залуу эрэгтэй, эмэгтэйчүүд сайн мэдээний төлөө хийсэн золиослолуудаараа хүчирхэгжсэн юм.
- 52 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Жинхэнэ анд найз гэж хэн бэ?**
Элайн С.Далтон
- 54 Би хэрхэн мэдсэн бэ?: Авралыг урих миний урилга**
Эмерсон Хосе да Сильва
Эцэстээ би найзынхаа урилгыг хүлээж авснаараа чухал зүйлийг олсноо мэдсэн.
- 56 Хөрвөснөө мэдэх арван арга зам**
Тайлер Ортон
Хөрвөлтийн тухай сурсан зүйл маань надад сайн мэдээнд өсч хөгжихөд тусалсан юм.
- 59 Үзүүлэн: Ажлаа сэтгэл гарган сайн хийвэл ашиг тусыг нь хүртэнэ**



*Энэ дугаарт нуусан
Лиахонаг олоорой.
Сануулга: Супер
баатарын хараагаа
ашиглаарай.*

61



- 60 Дени эмээгийн бяцхан номлогч**
Эмилия Мария Гуймаррес Корреа
Виктор сайн мэдээнд дуртай байсан нь эмээгийнх нь хөрвөлтөд хүчтэй нөлөөлжээ.
- 61 Онцгой гэрч: Сүм яагаад ийм урт нэртэй байдаг вэ?**
Ахлагч М.Рассел Баллард
- 62 Ариун сүм байдагт баярлацгаая!**
Дарси Женсен
Дэлхий даяар хүүхдүүд өөрсдөд нь Ариун сүм ойрхон байдагт баярлан тэмдэглэдэг.
- 64 Ариун сүмийн тухай асуулт, хариултууд**
Бид яагаад Ариун сүмүүдтэй байдаг вэ? Ариун сүмүүдэд юу болдог вэ? гэх мэт асуултуудын хариулт
- 65 Дуу хөгжим: Гэр бүл үүрд хамт байх болно**
Рут Мюур Гарднер,
Ванжа В.Воткинс
- 66 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Есүс Христ Өөрийн Сүмийг хожмын өдрүүдэд сэргээсэн**
- 68 Бошиглогчийн мөрөөр: Сүм хаана зохион байгуулагдсан бэ?**
Жан Пинбороу
- 70 Бага насны хүүхдүүдэд зориулав**
- 81 Бошиглогчийн хөрөг: Вилфорд Вудрафф**

2013 ОНЫ 4-Р САРЫН ДУГААР 14 NO. 2
ЛИАХОНА 10784 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук, Д.Тодд
Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Крейг А.Кардон

Зөвлөхүүд: Шэйн М.Боуэн, Брэдли Д.Фостер,
Бага Кристоффел Гоулдэн, Энтони Д.Пэркинс

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:

Винсент А.Баун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карп,

ЛаРин Портер Гаунт

Хэвлэлийн туслах: Мэлисса Зентено

Редакцийн баг: Сюзан Барретт, Давид Диксон,
Давид А.Эдвардс, Маттью Д.Эллитон, Минди Рая Фриедман,
Гарри Х.Гарфф, Женнифер Грейс Жөүнс, Хайкари Лофтус,
Майкл Р.Моррис, Ричард М.Ромни, Пол ВанденБерг,
Жюлия Вудбери

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсен

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанетт Эндрюс,
Фэй П.Андрус, С.Кимбол Ботт, Томас Чаллд, Керри Линн
С.Херрин, Коллийн Хинкли, Эрик П.Жонсен, Скотт М.Моои,
Брэд Тиаре

Оюуны өмчийн зохицуулагч: Жэйн Анн Петрс

Хэвлэлийн захирал: Жейн Анн Петерс

Хэвлэх баг: Конни Буаторп Бриж, Ховард Г.Браун, Жюли
Бердетт, Браян В.Гиж, Катлин Ховард, Денис Кэрби, Гинни
Х.Нилсон, Тай Пилчер, Гейл Тейт Рафферти

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талаар орон нутгийн Сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернет веб сайт

liahona.lds.org yyy; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”
буюу “заллагч”) албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагало, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстон, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2013 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиалан олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

April 2013 Vol. 14 No. 2. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake Distribution
Center, Church Magazines, PO Box 26368, Salt Lake City, UT
84126-0368.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглах өгүүлэл, үйл ажиллагаануудыг бичсэн
байгаа. Зарим жишээг доор харуулав.



ГЭР БҮЛ БИЙНЭГДЭГЭЙГ КОДИ БЭЛЛЭГ © IRI

Есүс Христийн үүрэг зорилго ба

үйлчлэл, 18-р хуудас: Ахлагч Рассел

М.Нелсон Есүс Христийн амьдралаас

бидний даган дууриаж болох таван

зүйлийг хуваалцаж байна. Эдгээр таван

зүйлийг болон тэдгээрийг амьдралдаа

хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилц. Авраг-

чийн амьдралын тухай судрын түүх унших

буюу (biblevideos.lds.org)-аас эдгээр үйл

явдлуудын нэгнийг нь тухай Библийн

видеог үзүүлж болно. Та бас Түүний

амьдрал үйлчлэлийн тухай гэрчлэлээ

хуваалцаж, “More Holiness Give Me”

(Hymns, no. 131) дууллыг дуулж, хичээлээ

дуусгаж болно.

“Жинхэнэ анд найз гэж хэн бэ?” 52-р

хуудас: Та “Жинхэнэ анд найз гэж хэн

бэ?” гэсэн асуултаар эхэлж болно. Ах-

лагч Роберт Д.Хейлсийн тодорхойлолтыг

уншиж, бид ямар анд найзууд байж

болох тухай ярилц. Өөрт чинь хэн нэгэн

нь жинхэнэ анд найзын ёсоор хандсан

туршлагаас хуваалцаж, сайн найз нөхөд

болоход туслах зан чанаруудын тухай гэр

бүлийнхэндээ ярьж өг.

“Ариун сүм байдагт баярлацгаая!

62-р хуудас: Гэрийнхэнтэйгээ хамт

зургуудыг үзэж, хүүхдүүд нь Ариун сүм

байдагт талархан тэмдэглэж болох

янз бүрийн арга замын тухай ярилц.

Хамгийн ойрхон оршдог Ариун сүмийн

зургийг үзүүлж, Ариун сүмүүд яагаад

онцгой чухал болох тухай ярилц. Гэр бү-

лүүд зөвхөн Ариун сүмүүдэд лацдан хол-

буулж болно гэдгийг онцлон тэмдэглэ.

“Families Can Be Together Forever” [Гэр

бүлүүд үүрд хамт байж чадна] (хуудас 65)

дууг дуулж хичээлээ төгсгөж болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад материалуудыг олон хэлээр

www.languages.lds.org -аас үзэж болно.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Ёслолууд, 18

Амилуулалт, Амилалт,

4, 12, 26

Ариун Сүнс, 10, 36

Ариун сүм, 34, 62

Ариун сүмийн ажил, 7,

64, 38, 65, 80

Ариун явдал, 42

Ариун ёслол, 18

Баптисм, 30

Баяр баясгалан, 37

Вудрафф, Вилфорд, 81

Гэр бүл, 30, 65

Гэрээнууд, 7

Дуулгавартай байдал,

40, 42, 56

Ерөнхий чуулган, 8, 37

Есүс Христ, 4, 18, 26

Жишгүүд, 42, 45

Залбирал, 18, 45

Золиослол, 40

Илчлэлт, 10, 46

Итгэл, 48

Мормоны Ном, 46

Найдвар, 12

Номлолын ажил, 34, 39,

48, 52, 54, 60

Нөхөрлөл, 9, 52, 54

Санваар, 44

Смит, Иосеф, 66

Сургаал, 8, 9, 30

Сэргээлт, 66

Сүмийн зохион

байгуулалт, 61

Сүнслэг нөлөө, 36, 38

Хөрвөлт, хөрвүүлэг, 34,

54, 56, 60

Цагаатгал, 18, 26, 45

Шаргуу тэвчээр, 59

Эн тэргүүнд тавих

зүйлс, 40

Үйлчлэл, 44, 70

Үлгэр дууриал, 48

Үхэл, 4, 12, 39



**Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг**

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх

Тэр Амилсан

Есүс Христийн Амиалт үнэн бодитой тухай гэрчлэл бол итгэл найдвар хийгээд шийдвэр төгс байдлын эх сурвалж мөн. Бурханы хүүхэд бүрт Есүс Христийн Амиалт үнэн гэдэг гэрчлэл байх ёстой. 1969 оны 6-р сард ээж минь өөд болоход энэ гэрчлэл надад байсан, үргэлж байсаар ч ирсэн бөгөөд цаашид ээжтэйгээ дахин учран золгох хүртэл энэхүү гэрчлэл надад байсаар байх болно.

Түр зуурын тусгаарлалтын уйтгар гуниг тэр даруйд баяр баяслаар солигдож билээ. Энэ нь зүгээр нэг эргэн уулзалтаас илүү онцгой найдвар байсан юм. Их Эзэн бошиглогчдоороо дамжуулан маш их зүйл илчилсэн учраас, Ариун Сүнс надад Амиалуулалт үнэн гэдгийг баталсан учраас, ариуссан бөгөөд амилуулагдсан хайртай хүмүүстэйгээ эргэн уулзах нь ямархуу байхыг би оюун ухаандаа төсөөлөн бодож чадна.

“Эдгээр нь шударга хүмүүсийн амилуулалтад урагш гарч ирэх тэд бөлгөө. . . .

“Эдгээр нь Бурхан хийгээд Христ бүхний шүүгч байдаг тэнгэрт нэр нь бичигдсэн тэд буюу.

Эдгээр нь өөрийнхөө цус урсгалтаар энэхүү төгс цагаатгалыг хийсэн, шинэ гэрээний зууч Есүсээр дамжин төгс болгогдсон шударга хүмүүс болох тэд бөлгөө” (С ба Г 76:65, 68–69).

Есүс Христ үхлийг ялсан учраас, дэлхийд төрсөн Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд хэзээ ч дахин үхэхгүй биеийг олж, амилуулагдах болно. Иймээс энэхүү алдар суут үнэний тухай миний болон та нарын гэрчлэл гэр бүлийн хайртай гишүүн буюу найз нөхрөө алдсаны үй гашуут баяртайгаар дахин уулзах найдвар хийгээд амилуулалт үнэн бодитой тухай ойлголтоор солих болно.

Их Эзэн бид бүгдэд амилуулалтын бэлгийг өгсөн юм. Амилуулалтаар бидний сүнс сул дорой байдлаас ангижирсан биетэйгээ дахин нэгдэх болно (Алма 11:42–44-ийг үзнэ үү). Ээж минь залуухан, гэрэл гэгээ цацарсан, эрч хүчтэй байх бөгөөд насны болон бие

махбодын сул дорой байдал нь байхгүй болсон байна. Амилуулалтын бэлэг түүнд бас бидэнд өгөгдөх болно.

Гэвч түүнтэй үүрд хамт байхыг хүсдэг бид бүгд тэрхүү дахин уулзалтад өөрсдийгөө тэнцэхээр болгохын тулд, Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хайртай Амилсан Хүүтэй хамт алдар сууд амьдрахын тулд зөв сонголтууд хийдэг байх ёстой. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын оршихуй бол гэр бүлийн амьдрал үүрд үргэлжилж болох цорын ганц газар мөн. Энэхүү үнэний тухай гэрчлэл нь бидний амьдралд үргэлж нөлөөлж байдаг Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өөрийгөө болон хайртай хүмүүсээ тэнцэхээр болгохын төлөөх миний шийдвэр төгс байдлыг улам нэмэгдүүлсэн билээ (С ба Г 76:70-ыг үзнэ үү).

Их Эзэн ариун ёслолын залбирлаар дамжуулан мөнх амьдралын төлөөх миний болон та нарын эрэл хайгуулд туслах удирдамжийг бидэнд санал болгосон юм.

Ариун ёслолын цуглаан бүрээр баптисмын гэрээгээ шинэчлэхэд биднийг урьдаг билээ.

Бид Аврагчийг үргэлж санана хэмээн амладаг. Тэрбээр үхлийн хүлээсийг тасалж, хэрэв бид бүх нүглээ наманчилбал биднийг уучилж, нигүүлслийг санал болгосон билээ. Бидний өмнөөс хийсэн Түүний хязгааргүй төлөөст талархалтай байхад Түүний золиослолын бэлгэдлүүд бидэнд туслах болно.

Бид Түүний зарлигуудыг сахихаар амладаг.

Судруудыг болон амьд бошиглогчдын үгсийг уншиж, ариун ёслолын цуглаанууд дээр сүнсээр нөлөөлөгдсөн үг хэлэгчдийн үгсийг сонсох нь хийсэн гэрээнүүдийг маань бидэнд сануулдаг. Ариун Сүнс тухайн үед сахих нь бидэнд хамгийн их хэрэгтэй байгаа зарлигуудыг бидний оюун ухаан, зүрх сэтгэлд авчирдаг.

Бурхан Ариун Сүнсийг бидэнтэй хамт байлгахаар ариун ёслолын залбирлуудад амласан билээ (Моронай 4:3; 5:2; С ба Г 20:77, 79-ийг үзнэ үү). Тэр үед би Бурхантай хувийн ярилцлага хийж байгаа юм шиг санагддаг. Тэрбээр энэ үед миний анхаарлыг Түүнийг баярлуулах





ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Бидэнд эрдэм болон тус байж болохын тулд би бүх судрыг өөрсөдтэйгөө адилтгах” (1 Нифай 19:23) ёстой. Сургаал ба Гэрээ 20:76-79 дэх ариун ёслолын залбирлуудыг унш. Ариун ёслолын залбирлуудын тухай Ерөнхийлөгч Айрингийн сургаалыг уншсаны дараа та эдгээр залбирлууд амьдралыг нь удирдан мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй дахин хамт амьдрахаар эргэж очиход нь хэрхэн тусалж болох арга замуудын тухай бодоход заадаг хүмүүсээ урьж болно.

зүйлсийг хийхэд хандуулж, наманчлах болон уучлах хэрэгцээ надад байгааг сануулан, Түүний өмнөөс үйлчлэх хэрэгтэй байгаа хүмүүсийн нэрс ба нүүр царайг надад харуулдаг билээ.

Олон жилийн турш давтагдсан энэхүү туршлага итгэл найдварыг энэрлийн үйлс

болгож, Аврагчийн Цагаатгал болон Амилалт нигүүлслийн үүд хаалгыг нээж өгсөнд итгэх баттай итгэлийг надад төрүүлсэн юм.

Есүс бол дахин амилсан Христ, бидний Аврагч, бидэнд төгс үлгэр жишээ үзүүлэгч бөгөөд мөнх амьдрал өөд удирдах хөтөч гэдгийг би гэрчилж байна. ■

Бурхантай хийх таны хувийн ярилцлага

Бид ариун ёслолын залбирлуудыг сонссоноор Бурхантай хувийн ярилцлага хийж байгаа юм шиг сэтгэгдэл төрдөг хэмээн Ерөнхийлөгч Айринг заажээ. Тэрээр дараах гурван зүйлийг бидэнд зөвлөмж болгосон юм. Эдгээр асуултыг тэмдэглэлдээ бичиж аван, энэ сарын турш ням гараг бүр тунгаан бод. Та нар эдгээр асуултын талаар тунгаан бодож,

Ариун Сүнснээс хүлээн авсан удирдамжаа тэмдэглэлдээ бичиж болно.


- Би Бурханыг баярлуулах юу хийсэн бэ?
- Би юуны төлөө наманчлах буюу уучлал хүсэх хэрэгтэй вэ?
- Бурхан намайг хэнд үйлчлэхийг хүсэх бол?

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Есүсийг ямагт санагтун

Иаков Аврагчийг “үргэлж санахыг” хичээдэг (С ба Г 20:77). Түүний унтлагын өрөөг харна

уу. Есүсийг үргэлж санахад нь түүнд тусалдаг байж болох юуг та нар ажиглаж байна вэ?



Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу. Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Ариун сүмийн гэрээнүүд

Ариун сүмд хүлээн авдаг авралын ёслолууд нь биднийг хэзээ нэгэн цагт Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очин мөнхийн гэр бүл болох боломжийг олгодог бөгөөд тэнгэрээс ирэх адислал, хүч чадлыг хүлээн авахын тулд гаргадаг бүх золиослол, чармайлт нь үнэ цэнэтэй гэдгийг тэд ухаарч ойлгодог”¹ хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлжээ. Хэрэв чи Ариун сүмд ороогүй бол дараах зүйлсийг хийж, Ариун сүмийн эрхэм нандин ёслолуудыг хүлээн авахад бэлтгэж болно:

- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс гуравт итгэдэг байх.
- Есүс Христийн Цагаатгал болон сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлийг хөгжүүлэх.
- Амьд бошиглогчийг дэмжиж, дагадаг байх.
- Аравны нэгээ төлж, ёс суртахууны хувьд цэвэр ариун, шударга байж, Мэргэн Ухааны Үгийг сахин, Сүмийн сургаалуудын дагуу амьдардаг байх.
- Их Эзэний хаант улсыг байгуулахын тулд цаг зав, авьяас чадвар, эд хөрөнгөө зориулдаг байх.
- Гэр бүлийн түүхийн ажилд оролцох.²



Ерөнхийлөгч Монсон цааш нь сургасан нь, “Бид Ариун сүмд хийсэн гэрээнүүдээ сахиснаар тохиолдсон хүнд сорилт болон уруу таталт бүрийг даван туулах хүч чадалтай байх болно.”³

Судруудаас

Сургаал ба Гэрээ 14:7; 25:13; 109:22

Эшлэл

1. Томас С.Монсон “Ариун сүм—Дэлхийн гэрэлт цамхаг” *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 92.
2. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 21-ийг үзнэ үү.
3. Томас С.Монсон *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 93.
4. *Daughters in My Kingdom*, 29–30.
5. Сара Рич, *Daughters in My Kingdom*, 30.

Би юу хийж чадах вэ?

1. Би Ариун сүмд тогтмол ордог уу?

2. Би эгч нараа Ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад нь урамшуулан дэмждэг үү?

Итгэл, Гэр бүл,
Халамж



Бидний түүхээс

“Наувугийн Ариун сүмийг адисалсны дараа Ариун сүмийн гадаа 5000 гаруй Гэгээнтнүүд цугласан ажээ. . . .

“Ариун сүмийн гэрээнүүдээс хүлээн авсан хүч чадал, адислалууд нь өрнөд нутаг руу хийсэн аяных нь үед өвлийн хүйтэн, зуны халуун, өлсгөлөн, ядуу зүдүү байдал, осол эндэгдэл, үхэл хагацлыг даван туулахад Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд тусалсан юм.”⁴

Сара Рич Нийгмийн Халамжийн Бүлгийн олон эгч нарын адил Ариун сүмийн ажилчнаар үйлчилж байжээ. Тэр туршлагын талаар ийн өгүүлжээ: “Хэрэв Ариун сүмд. . . Их Эзэний Сүнсээр бидэнд олгогдсон итгэл хийгээд мэдлэг байгаагүй бол бидний аян, зорилгоо хэрхэн биелүүлэхийг мэдэхгүйгээр харанхуйд тэмтчин бэдрэхтэй адил байх байсан биз ээ. . . . Гэвч бидэнд Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэл, бид бол Түүний сонгогдсон хүмүүс шүү дээ гэсэн мэдрэмж байсан. . . бөгөөд бид уй гашуугийн оронд баяр баясал болон чөлөөлөлтийн өдөр ирэх болно гэсэн бат итгэлтэй байсан.”⁵

Өрнөд нутаг руу хийсэн аян итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүдийн хувьд “зорилгоо хэрхэн биелүүлэхийг мэдэхгүйгээр харанхуйд тэмтчин бэдрэх” явдал байгаагүй юм. Ариун сүмийн гэрээнүүд нь тэднийг зоригжуулж байлаа.

ЧУУЛГАН ДЭЭР ХЭЛСЭН ҮГСИЙГ ХАМТДАА СУДЛАХ НЬ

Чуулган дээр хэлсэн үгсийг судлах арга барилаа өөрчилсөн нь бидэнд сайн мэдээг гэр бүлээрээ ярилцах боломжийг илүү их өгсөн юм.

Грег Батти

Бид олон жилийн турш чуулганы сэтгүүлийн дугаарыг гэр бүлээрээ хамт нэг удаа нэг өгүүлийг уншдаг байлаа. Бид ширээ тойрч суугаад өгүүлийн догол мөрүүдийг ээлжээр чангаар уншдаг байв. Гэвч бид өгүүлийг дуустал нь зүгээр л уншдаг байснаас, захиасуудын тухай тунгаан бодох цаг гаргадаггүй байлаа.

Чуулганы захиасуудаас улам их зүйлийг сурахын тулд эхнэр бид хоёр чуулганы дугаараас гэр бүлийн гишүүн бүрдээ худалдан авдаг байсан бөгөөд дараагийн ерөнхий чуулганаас өмнө сэтгүүлээ уншиж дуусгасан байхын тулд хүн бүр хэчнээн өгүүлэл уншихыг төлөвлөдөг байлаа. Бид зарим долоо хоногт нэг, зарим долоо хоногт хоёр өгүүлэл уншиж, илүү таалагдсан захиасуудыг тэмдэглээд дараа нь тэмдэглэсэн хэсгээ гэр бүлийн үдшээр бие биедээ заадаг байв.

Хүүхдүүд маань бидний ярилцлагын хүрээг тэлсэн асуултуудыг байнга асуудаг байсны зэрэгцээ эхнэр бид хоёр бас судалсан зүйлээсээ асуултууд асуудаг байсан. Эхнэр бид хоёр өөрсдийн асуултуудад хүүхдүүдийнхээ хэрхэн хариулахыг сонсохыг эрхэмлэдэг байлаа. Бид бас семинар, сүм дээр болон хувиараа сурч мэдсэн зүйлээ хуваалцахад

хүүхдүүдээ урамшуулан дэмждэг байв. Энэ нь нэн тааламжтай орчинд бие биеийнхээ энгийн гэрчлэлийг тогтмол сонсох сайхан боломжоор биднийг хангасан юм.

Бид удалгүй өглөө судар судлах үедээ мөн ийм мэдрэмжтэй байдаг болов. Бид зарим өдөр цөөхөн шүлгийг сонгон авч уншаад ярилцлагаа түр зогсоож, эдгээр шүлгийн тухай мөн тэдгээр нь бидний амьдралд хэрхэн холбогдох тухай ярилцдаг болсон.

Одоо бид өглөө тус тусын ажил, сургуульдаа явахаас өмнө ярилцаж, инээд баяслаар дүүрэн байдаг болсон. Гэр бүлээрээ өдөр бүр хамт суралцаж, залбирч байх тухай бошиглогчийн зөвлөгөөний талаар бидэнд бат бөх гэрчлэл бий. Манай гэр бүлийнхэн бие биенээсээ суралцаж, бие биеэ хүчирхэгжүүлдэг болон өөрчлөгдсөн. Энэ бүхэн бол ерөнхий чуулганы захиасаас илүү их зүйлийг сурч мэдэх хүслийн үр дүн юм. ■

Грег Батти АНУ-ын Юта мужид амьдардаг.



ЧУУЛГАНЫ ЗАХИАСУУДЫГ СУДАЛЖ, АМЬДРАЛДАА ХЭРЭГЖҮҮЛ

“Энэ чуулганы үеэр бидний сонссон захиасууд *Ensign*, *Лиахона* сэтгүүлүүдийн тавдугаар сарын дугааруудад нийтлэгдэнэ гэдгийг санаарай. Захиасуудыг судлан, сургаалуудыг нь тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлэхийг би та бүхнээс хичээнгүйлэн хүсч байна.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Хаалтын үг,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 113.



САЙН НАЙЗ НӨХДИЙН АЧ ТУС

Найз нөхөд бидний үйлдэлд, ялангуяа манай өсвөр үеийнхэнд хүчтэй нөлөө үзүүлдэг. “Тэд та нарын бодол санаа, үйлдэлд их нөлөө үзүүлдэг. Тэр ч байтугай та нарыг ямар хүн болох вэ гэдгийг тодорхойлоход тусална.¹ Тэд та нарыг илүү сайн хүн байж, Есүс Христийн сайн мэдээгээр амьдрахад илүү хялбар болгон тусалдаг.²

Энэ дугаарын 52-53-р хуудсанд Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Элайн С.Далтон сайн найзтай болохыг эрэлхийлэх болон түүний ач тусын тухай заажээ. “Нэгнийхээ сайн сайхан зүйлээс суралцахыг эрэлхийлэх нь жинхэнэ нөхөрлөлийн мөн чанар юм” хэмээн тэр хэлжээ.

Эдгээр зарчим дээр үндэслэсэн нөхөрлөл нь интернетээр “найз нөхөд” болохоос огт өөр зүйл бөгөөд урт удаан хугацаанд жинхэнэ анд найзын холбоотой байж, ашиг тусыг нь хүртэхэд өсвөр үеийнхэнд тусална. Эцэг эхчүүд хүүхдүүд нь сайн найз нөхөдтэй байх болон сайн мэдээгээр амьдрахад урамшуулан дэмждэг сайн найз нарыг сонгон нөхөрлөхийн ач холбогдлыг ойлгоход нь хүүхдүүдэд тусалж чадна. Дараах зөвлөмжүүд ашиг тустай байж болно.

Өсвөр үеийнхэнд заах тухай зөвлөмжүүд

- Сайн найз нарын жишээг гэр бүлээрээ судруудаас судал. Зан төлөвийн ямар чанарууд

тэдний нөхөрлөлийг бат бөх болгосныг ярилц. (1 Самуел 18–23), Рут, Наоми хоёр (Рут 1–2-ыг үзнэ үү), Алма болон Мозаягийн хөвгүүдийн тухай ярилц (Мозая 27–28; Алма 17–20-ийг үзнэ үү).³

- *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь найз нарын тухай хэсгийг нэгтгэн дүгнэ. Нөхөрлөл амьдралд чинь хэрхэн нөлөөлснийг өсвөр үеийнхэнтэй хуваалц. Тэд найз нартаа ямар нөлөө үзүүлдэг, найз нар нь тэдэнд ямар нөлөө үзүүлдэг тухай хуваалцахад тэднийг урь.
- Энэ дугаар дахь Далтон эгчийн өгүүллийг унш. Сайн найзуудтай болох гэсэн охин Эмигийнх нь зорилгын тухай ярилц. Сайн найз нөхөдтэй болох зорилго дэвшүүлж, зорилгодоо хүрэхэд нь хүүхдүүдэд тусал.
- Бусдад жинхэнэ анхаарал тавьж, инээмсэглэж мөн тэдний төлөө санаа тавьдаг гэдгээ мэдүүл. Бүх хүнтэй эелдэг, хүндэтгэлтэйгээр харьц. Эргэн тойрны хүмүүсээ шүүмжлэн, буруушаахыг цээрлэ.⁴

Өсвөр үеийнхэнд заах зөвлөмжүүд

- Сайн найз байх нь бусдад туслахаас эхэлдэг. 2009 оны 5-р сарын *Лиакхона*-гийн дугаараас “Калебыг дэмж” өгүүллийг уншиж, уулзсан хүн болгонд



НӨХӨРЛӨЛИЙН ТАЛААРХ СУДРУУД

Сургаалт Үгс 17:17; 18:24

Номлогчийн Үгс 4:9–10

Матай 25:34–40

Лук 22:32

Мозая 18:8–9

найрсаг хандах арга замуудын тухай хүүхдүүдтэйгээ ярилц.

- Бид ямар ч нөхцөл, ямар ч орчинд бусдад найз нөхөр нь байх ёстой. “I’m Trying to Be Like Jesus”⁵ [Би Есүс шиг байхыг хичээдэг] дууллыг хамтдаа дуулж, дараа нь, ямар ч үед Аврагч шиг байх сайн найз нарыг хэрхэн сонгох тухай хүүхдүүдтэйгээ ярилц. ■

ЭШЛЭЛ

1. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 16.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 16.
3. Жеффри Р.Холланд, “Real Friendship,” *New Era*, 1998 оны 6-р сар, 62–66-г үзнэ үү.
4. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 16.
5. “I’m Trying to Be Like Jesus,” *Children’s Songbook*, 78–79.

АРИУН СҮНС ТАЙТГАРУУЛЖ, СҮНСЛЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭН, ГЭРЧИЛДЭГ

Ариун Сүнсний бэлэг бол энэ амьдралд бидний хүлээн авч болох хамгийн агуу адислалуудын нэг юм. Учир нь Ариун Сүнс биднийг тайтгаруулан, сэрэмжлүүлж, ариусган, удирдаж, бидэнд сүнслэг нөлөө үзүүлдэг. Тэр биднийг “найджар хийгээд төгс хайраар” (Моронай 8:26) дүүргэж, “бүх зүйлийн үнэнийг” (Моронай 10:5) заадаг. Бид Ариун Сүнсээр дамжуулан Бурханаас илчлэлт болон сүнсний бэлгүүдийг хүлээн авдаг. Хамгийн чухал нь бид Ариун Сүнсээр дамжуулан Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай гэрчлэлтэй болдог.

Та нар баптисм хүртэхээсээ өмнө Ариун Сүнсийг үе үе мэдэрдэг байсан. Гэвч баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авч, Ариун

Сүнсний байнгын нөхөрлөлтэй болсноор та нарын амьдрал зохистой болдог. Энэ бэлгийг Мелкизедек санваартан гар тавилтаар өгдөг (Үйлс 19:6; С ба Г 33:15). Түүнээс хойш та Хүндэтгэлийн өдөр бүр ариун ёслолоос хүртсэнээрээ баптисмын гэрээгээ шинэчилдэг бөгөөд “Түүний Сүнсийг үргэлж өөртэйгөө хамт байлгах” Их Эзэний адислалыг хүлээн авдаг билээ (С ба Г 20:77).

Сүнс хэмээн олонтоо нэрлэдэг Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн юм. Бошиглогч Иосеф Смит сургасан нь: “Эцэг хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй болой; Хүү ч бас адил бөлгөө; Ийм бус байх аваас, Ариун Сүнс бидэн дотор оршиж чадах нь үгүй бөлгөө (С ба Г 130:22).


“Их Эзэний Сүнс ариун бус дугаонуудад үл оршихын учир” (Хиламан 4:24) бид Түүний нөхөрлөлд тэнцэхээр зохистой байх ёстой. Тиймээс бид цэвэр ариун бодол санаатай байж, зарчимч, зөв шударгаар амьдарч, зарлигуудыг үргэлж сахих хэрэгтэй. ■

Нэмэлт мэдээллийг 2 Нифай 31:13, 17; 32:5; 3 Нифай 27:20; Моронай 10:5–8; Иосеф Смит—Түүх 1:70-аас үзнэ үү.

БИД ЭНЭ БЭЛЭГ АЯНДАА ИРНЭ ГЭЖ ХҮЛЭЭЖ СУУХ ЁСГҮЙ


Бид бусад бүх бэлгийн хамт энэ бэлгийг хүлээн авч, ач тусыг нь үзэх хэрэгтэй. Санваар атгагчид толгой дээр чинь гараа тавьж, өөрийг чинь Сүмийн гишүүнээр баталсан үед та “Ариун Сүнсийг хүлээн авна уу” гэсэн үгсийг сонссон байгаа. Энэ нь Ариун Сүнс аливаа болзолгүйгээр таны байнгын хамтрагч боллоо гэсэн үг биш юм. Их Эзэний Сүнс “хүнтэй үргэлж хамт байдаггүйг” (Эхлэл 6:3) судрууд бидэнд анхааруулдаг билээ. Бид гишүүнээр батлагдах үедээ Ариун Сүнсний нөхөрлөлтэй байх эрхтэй болдог ч, энэхүү эрхээ хадгалахын тулд бид дуулгавартай, зохистой байх ёстой.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлин (1917–2008) “The Abundant Life,” *Лиахона*, 2003 оны 5-р сар, 28.



**Бид Ариун Сүнсний бэлэг
хүлээн авсны дараа амьд-
ралдаа Түүний нөлөөг
урихын тулд олон зүйлийг
хийж болно:**

Залбирах.



Судруудыг судлах.



Ариун ёслолоос зохистойгоор хүртэж байх.



ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЭЛЭЙГ КРИСТИНА СМИТ,
ИВИ ТАФТ, КОДИ БЕЛЛ, МАТТЮ РЕЙЕР НАР



*Ариун сүмд орж, тэнд
шүтэн бишрэх.*



*Зөв зохистой хэвлэл
мэдээллийн хэрэгсэл
үзэж, цэвэр тунгалаг хэл
яриатай байж, бодол
санаагаа хиргүй ариун
байлгах.*

Үхэл БА амьдрал

АМИЛУУЛАЛТЫН ТАЛААРХ АНХДАГЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ

*Сүмийн анхны хөрвөгчид Гэгээнтнүүдтэй нийлэхийн тулд
Нэгдсэн Улсын өрнөд нутаг руу хүнд хүчир аян хийсэн үед үхэл
хагацалтай тулгарч байсан ч сэргээгдсэн сайн мэдээнд итгэх шинэ
итгэл нь тэдэнд хүч чадал өгч байсан юм. Анхдагчдын дараах үгс
болон Сүмийн анхны таван Ерөнхийлөгчийн сургаалаас авсан хэсгүүд
Гэгээнтнүүд Амилуулалтад найдаж байсныг харуулж байна.*

*1866 онд Нью-Йоркоос Юта руу хийсэн аяны
үеэр бага насны хүү нь амь үрэгдсэн, нэр нь
үл мэдэгдэх Скандинавийн нэгэн Хожмын
Үеийн Гэгээнтний тухай Роберт Авесон
ийн өгүүлжээ.*

“Тэр нэг найзынхаа тусламжтайгаар шарилын жижигхэн нүх ухаад, халдварт өвчнөөр нас барсан хүүхдийнхээ цогцсыг тэнд оршуулахад гашуудан цугларагсад байсангүй, ямар нэг ёслол болсонгүй, цэцэг ч байсангүй, салах ёслолын дуу дуулж, гашуудлын үг ч хэлсэнгүй. Харин уй гашуу болсон эцэг нь төрөлх дани хэлээрээ товчхон адислалын залбирал хэлснийг дор өгүүлье: . . .

“Тэнгэрлэг Эцэг минь ээ: Та надад энэ бяцхан үнэт эрдэнэ хонгорхон хөвгүүнийг өгсөн билээ. Одоо та түүнийг Өөртөө дуудан аваачлаа. Та түүний цогцсыг амилуулалтын өглөө хүртэл энд нь амгалан тайван

байлгаарай. Таны хүсэл биелэг. Амен.”

Тэгээд тэр өндийн босч салах ёслолын эдгээр үгсийг хэлсэн ажээ:

“Баяртай, миний бяцхан хонгор хүү Ханс минь.” Тэгээд тэр тэргүүнээ гудайлган, гунигтай ч гэсэн эрс шийдэмгийгээр буудалласан газар руугаа явлаа.”¹

Ерөнхийлөгч Иосеф Смит (1805–44):

“Нөхөр, эхнэр, эцэг эх, хүүхдээ эсвэл хайртай дотны хүнээ алдаад салах ёс гүйцэтгэн гашуудаж байгаа хүмүүст, дэлхийн бие нь оршуулагдан, тоосонд шингэсэн ч, хайртай хүмүүс нь нэгэн цагт үхэшгүй байдлыг олж, түймэрдэгч галын дотор оршин, гай зовлон, уй гашууг мэдэхгүйгээр амилан босч, Есүс Христийн хамт Бурханы өв залгамжлагчид болно гэдгийг мэдэж байгаа нь ямар их тайвшралыг өгч байна вэ.”²





*Жозеф Уотсон Янг (1828–73), Англиас 1853 онд
Нэгдсэн Улсад ирсэн Бригам Янгийн зээ дүү:*

“Шөнийн түнэр харанхуйд хэдүүлхнээ, хорвоог орхисон нэгнээ оршуулах шиг гунигтай юм хаа байхав. . . . Усан онгоцон дээр түүний төлөө гашуудах хүн үйлчлэгч найзаас нь өөр хэн ч байсангүй. Ийм хүнд хоромд хүмүүний итгэл найдвар үгүй болдог. Энэ залуу эр Сионд очихын тулд хамаг юмаа орхиж, зүрх сэтгэл нь агуу итгэл найдвар, хүсэл эрмэлзлээр дүүрэн байсан бөгөөд далайд живж, амиа алдаж болно гэдэг бодол түүнийг огтхон ч зовоогоогүй юм. Гэвч, тэр итгэж найдах юм юу ч үгүйгээр хорвоог орхисон хүмүүстэй огт адилгүй. Учир нь амар амгалан байдлыг түүнд Бурхан өгсөн байлаа. Иймээс тэрээр зөв шударга хүмүүсийн амилуулалтын алдар суут өглөөд бүрэн итгэлтэй байсан юм.”³



Зүүн талд:
Ерөнхийлөгч
Бригам Янг.
Дээд талд:
Жозеф Уатсон
Янг.

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–77):

“Бид үхлийг харанхуй хөндий, хар сүүдэр хэмээн нэрлэдэг! Мөнх бус бие оршихуйн энэ хэлбэрээс оргүй хоосон хэлбэрийг дамжин өнгөрдөг нь юутай хачирхалтай! Энэ нь үнэхээр харанхуй хөндий юм! Энэ зам нууцлаг бөгөөд бид



хараахан үүгээр аялаагүй байна. Найз нар, ах дүүс минь, хэрэв бид юмсыг байгаагаар нь харж чаддагсан бол, тэдгээрийг ухаж ойлгодогсон бол хар сүүдэр, харанхуй хөндий буюу үхэл нь яльгүй зүйл бөгөөд үүнийг тал бүрээс нь бодож үзвэл бид үхлийг үзнэ гэдэг нь хүмүүний оршихуйн үүднээс авч үзвэл уй гашуу, гай зовлон, өвчин

эмгэг, гутрал цөхрөлийн оршихуйгаас махан биегүйгээр амьдралын баяр баясгаланг бүрэн хэмжээгээр нь мэдэрч чадах мөнхийн оршихуйд шилжиж байгаа үнэхээр агуу боломж юм гэдгийг би та нарт хэлэхийг хүсч байна.”⁴





Дан Жөүнс (1811–62), Хатагтай Виллямс болон Сүмийн бусад гишүүдтэй хамт 1849 онд Нэгдсэн Улсад далайгаар ирсэн Уэльсийн хөрөөгч:

“Трегароны (Уэльс) ойролцоох Енисибонтын хатагтай Виллямсийн эрүүл мэндийн байдал түргэн муудаж, амьд явах хоногийнх нь тоо цөөхөн болсон байлаа. . . . Түүнд тохиосон агуу аз завшаан, нэр төрийн хэрэг бол Бурханы Хүүгийн үнэн сүмийн гишүүн болсон явдал нь бөгөөд Түүний сүмийн хүч чадал урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр батлагдаж буй үед энэ амьдралын дараа ирэх амьдралд итгэх итгэл нь түүний айдсыг үргээж байлаа. . . . Амилуулалтын өглөө ээжтэйгээ учран золгохын тулд үхэх хүртлээ итгэлтэй байхыг тэрээр хөвгүүддээ эрхэмлэн захьсан ажээ. . . . Тэрээр шөнөжингөө ухаан санаа сэргэг байж,



Баруун талд:
Ерөнхийлөгч
Жон Тейлор.
Дээд талд:
Дан Жөүнс.



маргааш өглөө үүр цайх үед өглөөний дөрөв арван тавд нүүрэндээ амар амгалан инээмсэглэл үлдээн зовлонг хорвоог орхисон юм.”⁵


Ерөнхийлөгч Жон Тейлор (1808–87):

“Хайртай найз нараа алдан гашуудаж байгаа хүмүүс тэдэнтэй дахин уулзах болно гэдгийг мэдэх нь тэднийг хэчнээн их тайтгаруулдаг билээ! Бид нэгэн цагт үхэшгүй мөнх, амилсан бодгаль болж, булшнаас босч ирэн, итгэл хүлээсэн, үнэнч анд найзуудтайгаа эргэн уулзаж, үхлийн зовлонг дахин үзэхгүй болж, биднээр хийлгэхийг хүссэн Эцэгийн ажлыг дуусгах болно гэдгийг мэдэх нь үнэний зарчмуудаар амьдардаг бүх хүмүүсийг, тэр тусмаа халуунд халж, хүйтэнд хөрч, хүнд ачааг үүрэн, амьдралынхаа бараг төгсгөлд ирсэн хүмүүсийг хэчнээн их тайтгаруулах бол оо!”⁶



Андрю Женсон (1850–1941), АНУ-ын Небраскаас 1866 онд Ютад Андрю Х.Скоттын морин тэрэгтэй бүлэгтэй хамт ирсэн Данийн цагаач:

“Бид хамт аялагч нөхдийнхөө цогцсыг эзгүй зэлүүд газарт оршуулаад, бүгдээрээ цурхиран уйлж, дотроо онгойлгодог байлаа. Найз нар, төрөл төрөгсөд нь хайртай хүмүүсээ ийм байдлаар нутаглуулаад шарилын газар дээр нь эргэж ирэх ямар ч найдваргүйгээр, тэр дороо яаран аяны замаа сэтгэлдээ гуниг тээн хөөдөг байлаа. . . . Гэвч эхний амилуулалтын өглөө Габриел бүрээгээ үлээхэд тэдний булш нээгдэж, оршуулагдсан тэд Сионыг чиглэн алхлах болно. Их Эзэн тэднийг зорьсон газартаа хүрэхээс нь өмнө тэнгэр дэх гэрт нь дуудах болно. Сионыг махан биеэр үзэх нь тэдэнд боломжгүй юм. Харин тэд алдар сууг хүлээн авч баярлах болно. Хэрэв тэд хорвоог орхих хүртлээ Бурханыг



Зүүн талд:
Ерөнхийлөгч
Вилфорд
Вудрафф. Дээд
талд: Андрю
Женсон.

дуулгавартай дагаж, Түүний зарлигуудыг сахихыг хичээсэн бол [Их Эзэн] дотор нас барж адислагдах болно.”⁷

Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф (1807–98):



“Христийн сайн мэдээгүйгээр үхэл хагацал гэдэг бол тунгаан бодох сэдвүүдээс хамгийн гунигтай нь юм. Харин бид сайн мэдээг хүлээн авч, амилуулалтын зарчмуудыг мэдсэнээр үхэл хагацлаас үүдэлтэй уй гашуу, уйтгар гуниг үлэмж хэмжээгээр арилж үгүй болдог. . . . Нас барагсдын амилуулалт гэгээрсэн хүний оюун ухаанд сууриа олоход тэр хүний сүнс амар амгаланг олдог. Энэ бол Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн байр суурь. Бид үүнийг өөрсдөө олж мэдсэн бөгөөд энэ асуудлын талаар мэдлэггүй хүмүүс биш. Бурхан үүнийг бидэнд илчилсэн бөгөөд бид нас барагсдын амилуулалтын зарчмыг ойлгодог. Сайн мэдээ амьдрал, үхэшгүй байдлыг авчирдаг нь бидэнд илчлэгдсэн юм.”⁸



Ойлогход хялбар болгохын тулд зөв бичгийн зарим дүрэм, цэг таслал, том үсгээр бичих дүрмийг стандартын дагуу болголоо.

ЭШЛЭЛ

1. Роберт Авесон, “Leaves from the Journal of a Boy Emigrant,” *Deseret News*, 1921 оны 3-р сарын 12, 4:7; [lds.org/churchhistory/library/pioneercompanysearch-д](https://www.lds.org/churchhistory/library/pioneercompanysearch-д) байгаа.

2. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: *Иосеф Смит* (2007), 52.

3. Жозеф В.Янг, Тэмдэглэлийн дэвтэр, 1853 оны 3-р сарын 6, Юта мужийн Солт Лейк хотын Сүмийн түүхийн номын сан;



Виллям Драйвер (1837–1920), Англияс АНУ-ын Нью-Йоркод 1866 онд ирсэн анхдагч:

“Миний хамгаас хайртай хүү Вилли шөнөжингөө өвдөж, өглөөний 7:30-д хорвоог орхиж, зовлонгоосоо саллаа. Хөөрхий түүнийг минь Бурхан ивээх болтугай. Хүү минь хэчнээн их зовсон гээч. Тэр Английн Сөрвигийн Вондс-ворт дэх Гэгээн Аннын дов дээр Ноён Поултерийн морин тэрэг эвдэрч сүйрэхэд эндсэн юм. Ай, би ямар их гашуудаж байна вэ. Их Эзэн минь Та энэхүү гашуун зовлонг тэсэн өнгөрүүлэхэд хүч чадлыг, Танд улам үнэнч итгэлтэй үйлчлэх хүч чадлыг өгөөч. Би хайртай хүүтэйгээ,



Баруун талд:
Ерөнхийлөгч
Лорензо Снөү.
Дээд талд:
Виллям
Драйвер.



хайрт эгч Элизабет Марианнтай нь хамт илүү сайхан ертөнцөд, шударга хүмүүсийн амилуулалтын үед уулзахын төлөө хүү охин хоёртойгоо тэнд уулзахаар очиход бэлтгэн амьдрахад надад туслаач.”⁹

Ерөнхийлөгч Лорензо Снөү (1814–1901)

“Бид дараагийн амьдралд төгс төгөлдөр бие махбодтой болж, өвчин зовлон, үхэл хагацлаас ангид байх болно. Амилуулагдаж, алдар сууг олсон хүнээс илүү сайхан зүйл гэж юу байх билээ. Ийнхүү төгс төгөлдөр болж, эхнэр, хүүхдүүд, найз нөхөдтэйгээ дахин учран золгохоос илүү сайхан зүйл гэж юу байх билээ.”¹⁰ ■

mormonmigration.lib.byu.edu-д байгаа.

4. *Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 273.

5. “A Letter from Capt. D. Jones to the Editor of *Udgonr Seion*,” Рональд Д.Деннис, *The Call of Zion: The Story of the First Welsh Mormon Emigration*, vol. 2 (1987), 164–65; mormonmigration.lib.byu.edu-д байгаа.

6. *Teachings of Presidents of the Church: John Taylor* (2001), 50–51.

7. Андрию Женсоны хувийн тэмдэглэл, 1866 оны 8-р сарын 20, *Journal History of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 1866 оны 10-р сарын 8, Юта мужийн Солт Лейк хотын Сүмийн Түүхийн номын сан, 6; lds.org/churchhistory/library/

pioneercompanysearch-д байгаа.

8. *Teachings of Presidents of the Church: Wilford Woodruff* (2004), 82–83.

9. Фрэнк Драйвер Рийв, *London to Salt Lake City in 1866: The Diary of William Driver* (1942), 42; mormonmigration.lib.byu.edu-д байгаа.

10. Лорензо Снөү, *Conference Report*, 1900 оны 10-р сар, 63.



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Рассел М.Нелсон

ЕСҮС ХРИСТИЙН үүрэг зорилго ба үйлчлэл

*Бид Есүсийг шүтэн биширдгийн хамгийн сайн
нотолгоо бол Түүнийг даган дууриах явдал мөн.*

Бүх дэлхийд Есүс Христийн нэрийг гэрчлэх онцгой гэрчүүдийн нэг” (С ба Г 107:23) миний бие Түүний тухай зааж, гэрчилснээр хамгийн сайн үйлчилж чадна гэдэгт итгэдэг. Нэгдүгээрт, фарисайчуудаас Аврагчийн нэг удаа асуусан асуултуудыг би асууя: “Та нар Христийн тухай юу гэж боддог вэ? Тэр хэний хүү вэ?” (Матай 22:42).

Төр засгийн болон бусад шашны удирдагчидтай уулзаж ярилцах үед энэ хоёр асуулт миний санаанд олонтоо орж ирдэг. Тэдний зарим нь “Есүс бол агуу багш” гэдэг бол зарим нь “Тэр бол Бошиглогч” гэдэг. Бусад нь Түүний амьдралын тухай юу ч мэддэггүй. Бид үүнд гайхах хэрэггүй. Бидэнд байгаа сэргээгдсэн сайн мэдээний үнэнүүдийн тухай харьцангуй цөөн хүмүүс мэдэж байна. Өөрсдийгөө Христэд итгэгчид хэмээн тунхагладаг хүмүүсийн дунд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд цөөнх нь болдог.

Өнөөгийн бидний нөхцөл байдал олон зуун жилийн тэртээ Нифайн угтан харсантай яг адил байна:

“Мөнхүү улиран тохиох дор би Бурханы Хурганы сүмийг болгоов, мөн энэ нь . . . тоогоороо цөөн байв; хэдий тийм, Бурханы гэгээнтнүүд байсан Хурганы сүмийнхэн түүнчлэн бүх дэлхийн гадаргуугаар оршин байхыг би болгоов; мөн тэдний эзэмшил нь газрын гадаргуугаар бага байв. . . .

“Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Хурганы сүмийн гэгээнтнүүдийн дээр, мөн газрын гадаргуугаар нэг тархсан Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүс дээр буух Бурханы Хурганы хүчийг болгоов; мөн тэд ялгуусан алдар суунд, зөв шударга байдал хийгээд Бурханы хүчээр зэвсэглэсэн байв.” (1 Нифай 14:12, 14).

Энэхүү зөв шударга байдал, хүч чадал хийгээд алдар суу буюу эдгээр бүх адислал нь Их Эзэн Есүс Христийн тухай мэдлэг, Түүнд дуулгавартай байж, талархах болон Түүнийг хайрлах хайраас үүдэлтэй юм.



Аврагч харьцангуй богинохон амьдралынхаа хугацаанд хоёр үндсэн чухал зорилгыг гүйцэлдүүлсэн билээ. Нэгдүгээрт: “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь [Түүний] ажил мөн [Түүний] алдар суу” (Мосе 1:39) байлаа. Хоёрдугаарт Тэрээр: “Миний та нарт юу хийснийг та нар бас хийх хэрэгтэй гэж Би ийм жишээ үзүүлсэн юм” (Иохан 13:15) хэмээн тодорхойлжээ.

Түүний эхний зорилго Цагаатгал гэдгийг бид мэднэ. Энэ бол мөнх бус байдал дахь Түүний хамгийн агуу зорилго байлаа. Амилсан Их Эзэн эртний Америкийн хүмүүст Өөрийн зорилгыг ийнхүү нотолсон юм:

“Эцэг минь намайг илгээсний учир би Эцэгийнхээ тааллыг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн билээ.

Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд, би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд, Эцэг минь намайг илгээсэн бөлгөө” (3 Нифай 27:13–14).

Тэрбээр номлолоо цааш нь үргэлжлүүлэхдээ бидэнд үлгэр жишээ үзүүлэгч байх хоёр дахь зорилгоо илчилсэн юм: “мөн миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ;... учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно” (3 Нифай 27:21).

Эхнийх нь зорилгыг би Түүний *үүрэг зорилго* хэмээн тодорхойллоо. Харин хоёрдахь зорилгыг нь Түүний *үйлчлэл* хэмээн тодорхойлохыг хүсч байна. Түүний амьдралын энэхүү хоёр тал Түүний үүрэг зорилго ба үйлчлэлийг товч нэгтгэн дүгнэцгээе.

Есүс Христийн үүрэг зорилго бол Цагаатгалыг үйлдэх байв

Түүний үүрэг зорилго бол Цагаатгал байлаа. Цагаатгалыг зөвхөн Тэр л гүйцэтгэж чадах байв. Тэр мөнх бус эх, үхэшгүй мөнх Эцэг хоёроос төрсөн учраас амиа сайн дураараа өгөөд, буцааж авах хүчтэй байсан юм (Иохан 10:14–18-ыг үзнэ үү). Түүний Цагаатгалын гайхамшигтай үр дагаврууд хэмжээ хязгааргүй бөгөөд үүрд мөнхийн юм. Тэрбээр үхлийн зовлонг зайлуулж, үүнээс үүдэлтэй уй гашууг


түр зуурын болгосон билээ (1 Коринт 15:54–55-ыг үзнэ үү). Цагаатгалыг гүйцэтгэх Түүний үүрэг хариуцлага Бүтээлт ба Уналтаас өмнө тогтоогдсон юм. Энэ нь бүх хүн төрөлхтөнд амилуулалт ба үхэшгүй байдлыг боломжтой болгосон төдийгүй, Түүний тогтоосон нөхцөлийн дагуу нүглээ уучлуулах боломжийг бас бидэнд олгосон билээ. Тийнхүү Цагаатгал нь Түүнтэй болон гэр бүлтэйгээ үүрд нэгдэх үүд хаалгыг бидэнд нээж өгсөн юм. Энэхүү хэтийн төлөвийг бид мөнх амьдрал буюу хүмүүнд соёрхсон Бурханы бэлгүүдээс хамгийн агуу нь хэмээн үздэг билээ (С ба Г 14:7-г үзнэ үү).

Өөр ямар ч хүн Цагаатгалыг үйлдэж чадахгүй байсан. Түүнээс өөр ямар ч хүн хэчнээн агуу хүч чадалтай, хамгаас илүү баян байгаад ч, ганц ч хүнийг, бүр өөрийгөө ч аварч чадахгүй (Матай 19:24–26-г үзнэ үү). Түүнчлэн өөр ямар ч хүнээс өөр хэн нэгнийг үүрд мөнхөд аврахын тулд цусаа урсгахыг шаардахгүй, түүнд үүнийг зөвшөөрөхгүй. Харин Есүс үүнийг “нэг удаа бүгдийн төлөө” (Еврей 10:10) хийсэн юм.

Хуучин Гэрээний утган хэлэгдсэн олон чухал үйл явдал Шинэ Гэрээний үед Цагаатгалаар дамжин хэрэгжсэн билээ. Адам, Ева хоёрт “Эцэгийн Төрсөн Ганцын золиослолтой төстэй” (Мосе 5:7) өргөл өргөхийг зарлиг болгосон юм. Чухам яаж? Цус урсгах замаар. Тэд “махан биеийн амь нь цусанд байдаг” (Левит 17:11) гэсэн судрыг өөрсдийн туршлагаар баталсан юм.

Биеийн аль нэг эрхтэнд цус очихгүй бол асуудал үүсдэгийг эмч нар мэднэ. Хэрэв хөлөнд цус очихгүй бол, үхжил явагдаж болно. Хэрэв тархинд цус очихгүй бол харвалт болж мэднэ. Хэрэв артерийн судсанд цус хэвийн байдлаар очихгүй бол зүрхний шигдээсээр өвчилж мэднэ. Цус алдалтыг тэр дор нь зогсоохгүй бол үхэлд хүргэж болно.

Мал, амьтны цусыг урсгах нь түүнийг үхэлд хүргэдгийг Адам Ева хоёр болон тэдний дараах үеийнхэн мэдсэн юм. Тэд тахил өргөх ёслолдоо *ямар ч* хамаагүй амьтныг хэрэглэдэггүй байв. Ямар ч өөсэвгүй, сүргийнхээ ууган төлийг тахилд



ЭМЭГТЭЙ, ЭНЭ БОЛГАНЫ ХҮҮ (СТАБАТ МАТЕР) © БРУКЛИН МУЗЕЙ, БРУКЛИН, НЬЮ-ЙОРК; ОРУУЛ А. ГЕТСЕМАНИЙ ЦЭЦЭРЛЭГТ, КАРЛ ХЕЙНРИХ БЛОК

Аврагчийн цус бүх хүн төрөлхтний төлөө зөвхөн Цагаатгалын зовлон тарчлал болсон загалмай дээр төдийгүй бас Гетсеманий Цэцэрлэгт асгарсан юм.



өргөдөг байв (жишээ нь Египетээс Гарсан нь 12:5-ыг үзнэ үү). Эдгээр шаардлагууд Бурханы төгс Хурганы золиослолын бэлгэдэл байлаа.

Адам, Ева хоёрт “Иймийн тул, чи өөрийн хийх бүхнийг Хүүгийнхээ нэрээр хийх ёстой, мөн чи наманчилж, үүрд мөнхөд Хүүгийн нэрээр Бурханыг дуудах ёстой” (Моисе 5:8) гэж зарлиг өгсөн. Малаар тахил өргөх нь цаг хугацааны голчоос эхлэн Бурханы Хүүгийн эцсийн Цагаатгалын хэв шинж болон сүүдэр байсаар байв.

Цагаатгал хийгдсэнээр сүүлчийн агуу золиослол Мосегийн хуулийг гүйцэлдүүлж Алма 34:13–14), “махан биеийн амь нь цусанд байдаг” (Левит 17:11) хэмээн заадаг байсан малаар тахил өргөх нь дуусгавар болсон юм. Цагаатгалын улмаас малаар тахил өргөх эртний ёслол цаашид мөрдөгдөхгүй болж, үүнийг ариун ёслолоор дамжуулан хийх болсныг Есүс тайлбарласан. Амьдрал мах, цус гэсэн хоёр элементээс тогтдогийг дараах судраас харна уу:

“Есүс тэдэнд, Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй.

“Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна” (Иохан 6:53–54) гэж хэлжээ.

Есүс Христийн Цагаатгалын ачаар бүх хүн төрөлхтөн, бүр хүссэн болгон гэтэлгэгдэх болно. Аврагчийн цус бүх хүн төрөлхтний төлөө зөвхөн загалмайд дээр төдийгүй бас Гетсеманий Цэцэрлэгт асгарсан юм. Тэр тэнд дэлхий дээр амьдарч байсан болон амьдрах бүх хүмүүсийн нүглийн хүндийг Өөр дээрээ үүрсэн юм. Тэрхүү хүнд ачаа дарамтын дор Түүний сүв бүрээс цус шүүрч байлаа (С ба Г 19:18-ыг үзнэ үү). Цагаатгалын тарчлал Калварийн толгой дээр дууссан юм.

Бошиглогч Иосеф Смит “Манай шашны тулгуур зарчим бол Есүс Христ егүүтгэлээр наснаас хальж, оршуулагдаад, гурав дахь өдрөө амилж, тэнгэрт дээш одсон тухай Бошиглогчид, Төлөөлөгчдийн гэрчлэл юм. Ийнхүү манай шашинд холбогдолтой бусад бүх зүйл нь ердөө л энэ гэрчлэлийн хавсралтууд юм” хэмээн заасан билээ.¹

Би энэхүү эрх мэдэл хийгээд онцгой талархалтайгаар Түүний тухай зааж, гэрчилж байна.

Үлгэр жишээ үзүүлэгч, Есүс Христийн үйлчлэл

Мөнх бус амьдралд Их Эзэний гүйцэлдүүлсэн мөнхийн үр дагавартай хоёр дахь зорилго бол бидэнд үлгэр дууриал болохоор үйлчилсэн явдал мөн. Мөнх бус байдал дахь Түүний амьдрал үлгэр жишээч үйлчлэлээр

дүүрэн бөгөөд үүнд Түүний сургаалууд, сургаалт зүйрлэлүүд болон номлолууд, Түүний үйлдсэн гайхамшгууд, хайрын нигүүлсэнгүй сэтгэл, хүмүүний үрсийн төлөө эдэлсэн зовлон шаналал орно (1 Нифай 19:9-ийг үзнэ үү). Тэр бас санваарын эрх мэдлийг өрөвч нигүүлсэнгүй сэтгэлээр ашиглаж байлаа. Мөн Тэрээр бас нүглийг зэмлэхэд эгдүүцлээ илэрхийлдэг байсан нь зүй ёсны юм (Ром 8:3-ыг үзнэ үү). Жишээ нь, Тэр зоос солигчдын ширээг хөмрөн унагасан билээ (Матай 21:12-ыг үзнэ үү). Түүнийг дооглон тохуурхаж, ташуурдан, Өөрийнх нь хүмүүс Түүнийг хүлээж авсан-гүйгээр (Мозая 15:5-ыг үзнэ үү) барахгүй шавь нарынх нь нэг нь түүнээс урваж, нөгөө нь түүнийг үгүйсгэсэн билээ (Иохан 18:2–3, 25–27-г үзнэ үү).

Үйлчлэлийнхээ үед Түүний үйлдсэн гайхамшгууд Өөрт нь бол ердийн зүйл байлаа. Есүсийн үлгэр жишээг дагасан хүмүүсийн тоо хязгааргүй олон байлаа. Түүний үйлдсэнтэй адил төстэй гайхамшгуудыг бошиглогчид, төлөөлөгчид болон эрх мэдэл олгогдсон Түүний бусад үйлчлэгчид үйлдэж байлаа. Түүний улмаас тэдний олон нь хавчлагад өртөж байв (Матай 5:10; 3 Нифай 12:10-ыг үзнэ үү). Өнөө үед Их Эзэний үлгэр жишээг дагахын төлөө хичээн чармайж буй, тэр ч бүү хэл үүнийхээ төлөө аймшигтай төлөөс төлж буй олон ах, эгч нарыг та нар мэддэг байх аа.

Энэ бол байх ёстой зүйл. Энэ бол бидэнд хүлээлгэсэн Түүний найдвар. Их Эзэн биднээс Өөрийн үлгэр жишээг дагахыг хүсдэг. Тэр үүнийг маш тодорхой заасан юм:

- “Тиймийн тул, та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? . . . Бүр миний адил буюу” (3 Нифай 27:27; мөн 3 Нифай 12:48-ыг үзнэ үү).
- “Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно” (Матай 4:19).
- “Миний та нарт юу хийснийг та нар бас хийх хэрэгтэй гэж Би ийм жишээ үзүүлсэн юм” (Иохан 13:15; мөн Иохан 14:6-г үзнэ үү).

Эдгээр болон эдгээртэй төстэй бусад судруудыг зөвлөмж болгож бичээгүй юм. Эдгээр зарлигууд бол Бурханы зарлиг мөн! Бид Түүний жишээг дагах ёстой!

Бид Түүнийг дагах чин хүсэл эрмэлзэлтэй байхын тулд Түүний амьдралаас дараах таван зүйлийг амьдралдаа хэвшүүлж болно.

Хайр

Хэрэв надаас Түүний ямар зан чанарыг хамгийн чухал гэж үздэг вэ? гэж асуувал би Түүний хайр гэж хариулна. Түүний хайранд өрөвч нинжин сэтгэл, энэрэл, чин шударга зан, уучлал, нигүүлсэл гээд зан төлөвийн олон эрхэм чанар багтана. Есүс эцэг эх хоёртоо хайртай байсан (Иохан 19:25–27-г үзнэ үү). Тэр гэр бүлээ болон Гэгээнтнүүдийг хайрладаг байлаа (Иохан 13:1; 2 Тесалоник 2:16-г үзнэ үү). Тэр нүглийг нь санахгүйгээр нүгэлтнийг хайрладаг байв (Матай 9:2; С ба Г 24:2-ыг үзнэ үү). Мөн Тэр Өөрийг нь хайрлах хайраа бид хэрхэн харуулахыг заадаг байв. “Хэрэв та нар намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” (Иохан 14:15) хэмээн хэлсэн билээ. Түүний хайр аливаа *болзол шаарддаггүйг* онцлон тэмдэглэхийн тулд Тэрээр, “Би Эцэгийнхээ тушаалыг сахьж, Түүний хайр дотор байдгийн адил та нар миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно” (Иохан 15:10; мөн С ба Г 95:12; 124:87-г үзнэ үү) хэмээн нэмж хэлжээ.

Аврагчийн хайрын өөр нэг илрэл бол Түүний үйлчлэл юм. Тэр Эцэгтээ бас хамт амьдарч, ажилладаг байсан хүмүүстээ үйлчилдэг байлаа. Бид энэ хоёр төрлийн үйлчлэлийн аль алинаар нь Түүний үлгэр жишээг дагах ёстой. Бид “түүний бүх замаар явж, түүнийг хайрласнаараа” (Дэд Хууль 10:12; мөн 11:13; Иошуа 22:5; С ба Г 20:31; 59:5-ыг үзнэ үү) Бурханд үйлчилдэг. Бид бас хөршүүдээ хайрлаж, тэдэнд үйлчлэх ёстой (Галат 5:13; Мозая 4:15–16-г үзнэ үү). Үүнийг бид гэр бүлээсээ эхлэх хэрэгтэй. Эцэг эхчүүдийг хүүхдүүдтэй нь холбодог гүнзгий хайр тэднийг эцэг эхээсээ бүрэн хамааралтай байх үед нь тэдэнд



Бусад бүх багш нарынхаас Түүний сургаалын онцгой ялгаа нь мөнхийн ач холбогдолтой үнэнүүдийг заадаг байсанд оршино. Зөвхөн Тэр л бидний амьдралын зорилгыг илчилсэн билээ.

УУЛАН ДЭЭРХ НОМИЛ, ЖЕЙМС ТИССОТ, ОРУУТА, ХРИСТ БА БАВН ЗАЛУУ ЗАВИАРАГЧ, ХЕЙНРИХ ХОФМАНН, С. HARRISON CONROY СО-ИЙН ЗӨВШӨӨРТӨӨР НҮЙТГЭВ.





ханддаг хайр, халамжаар дамжин бий болдог. Үүргээ мэдэрдэг хүүхдүүд хожим нь эцэг эхээ өндөр настай болсон үед нь үйлчлэн туслах боломжтой байдаг. Мөн бид хөршүүддээ үйлчилж, тэднийг хайрлах ёстой.

Ёслолууд

Аврагчийн үлгэр жишээч амьдралын хоёр дахь хүчин зүйл нь ариун ёслолуудад онцгой анхаарал хандуулдаг явдал байлаа. Тэрээр мөнх бус үйлчлэлийнхээ үед авралын ёслолуудад онцгой ач холбогдол өгдөг байлаа. Түүнд Иохан Баптист Иордан гол дээр баптисм хүртгэсэн билээ. Иохан Баптист “Яагаад?” гэж асуухад,

Есүс ийн хариулжээ “Ингэснээрээ аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэх нь *бидэнд* зохицож байна” (Матай 3:15; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) гэж тайлбарлажээ. Зөвхөн баптисмын ёслол төдийгүй бас Есүс, Иохан хоёрын үлгэр жишээ нэн чухал байлаа.

Их Эзэн дараа нь ариун ёслолыг үндэслэн бий болгосон юм. Тэр ариун ёслолын бэлгэдлүүдийг тайлбарлаж, тэрхүү бэлгэдлүүдийг шавь нартаа гүйцэтгэсэн билээ (Матай 26:26–28; Марк 14:22–24; Лук 24:30-ийг үзнэ үү).

Бидний Тэнгэрлэг Эцэг бас ёслолуудын талаар бидэнд дараах зааврыг өгсөн юм: “Та нар цэвэршигдэж тэнгэрийн хаант улсад усаар мөн Сүнсээр дахин төрж мөн цусаар бүр миний Төрсөн Ганцын цусаар бүх нүглээс ариусгагдах ёстой, мөн энэ дэлхийд мөнх амьдралын үгсийг мөн ирэх дэлхийд бүр үхэшгүй байдлын алдар сууд мөнх амьдралыг та нар эдэлж болно” (Мосе 6:59).

Их Эзэний мөнх бус үйлчлэлийн дараа өргөмжлөлийн эдгээр онцгой чухал ёслолууд илчлэгдсэн юм (С ба Г 124:40–42). Тэр эдгээр ёслолуудыг гүйцэтгэхийн тулд Өөрийн ариун сүмүүдээр хангасан билээ. Өнөө үед зохих ёсоор бэлтгэлээ хангасан хүмүүст угаалга, тослолтын ёслолууд болон ариун сүмийн хувийн хишиг хүртэх онцгой боломж нээлттэй байдаг (С ба Г 105:12, 18, 33; 110:9; 124:39-ийг үзнэ үү) бөгөөд гишүүд эхнэр буюу нөхөр, өвөг дээдэс болон хойч үеийнхэнтэйгээ лацдан холбуулж болно (С ба Г 132:19). Бидний Их Эзэн бол хууль хийгээд дэг журмын Бурхан юм (С ба Г 132:18-ыг үзнэ үү). Тэрбээр ёслолууд дээр анхаарал төвлөрүүлдэг нь бидний дагавал зохих Түүний үлгэр жишээний онцгой чухал хэсэг мөн.

Залбирал

Их Эзэний үлгэр жишээч үйлчлэлийн гурав дахь хүчин зүйл бол залбирал юм. Есүс Тэнгэр дэх Эцэгтээ хандаж залбирдаг байсан бөгөөд бидэнд хэрхэн залбирахыг заасан юм. Бид Ариун Сүнсний залбирлын хүчээр дамжуулан Мөнхийн Эцэг Бурханд хандан Түүний

Хүү Есүс Христийн нэрээр залбирч байх ёстой (Матай 6:9–13; 3 Нифай 13:9–13; Иосеф Смитийн Орчуулга, Матай 6:9–15-ыг үзнэ үү). Би Иоханы 17-р бүлэгт цэдэглэсэн, бусдын төлөө Их Эзэний хийсэн агуу залбиралд дуртай. Үг залбиралд Хүү хайртай шавь нарынхаа төлөө Эцэгээсээ гуйн залбирсан юм. Энэ бол үр ашигтай бөгөөд өрөвч энэрэнгүй сэтгэлийн залбирал мөн.

Мэдлэг

Их Эзэний үлгэр жишээний дөрөв дэх хүчин зүйл бол бурханлаг мэдлэгээ ашигладаг явдал мөн. Христэд итгэгч бус хүмүүс Есүсийг агуу багш гэж үздэгийг өмнө дурдсан билээ. Тэр үнэхээр агуу багш байсан юм. Харин Түүний сургаал юугаараа онцгой ялгардаг байсан бэ? Тэр инженерийн ухаан, математик, шинжлэх ухаанаар гаргуун мэргэшсэн багш байсан уу? Манай дэлхий болон бусад үй олон гарагийг (Мосе 1:33-ыг үзнэ үү). Бүтээгчийн хувьд Тэрбээр үнэхээр ийм гаргуун мэргэжилтэн байсан уу? Мэдээж Тэр тийм байж чадах байсан. Эсвээс судруудын Зохиогчийн хувьд Тэрбээр бичгийн яруу сайхан хэлээр хэрхэн бичих ухааныг бидэнд зааж чадах байсан.

Бусад бүх багш нарынхаас Түүний сургаалын онцгой ялгаа нь *мөнхийн* ач холбогдолтой үнэнүүдийг заадаг байсанд оршино. Зөвхөн Тэр л бидний амьдралын зорилгыг илчилсэн юм. Бид гагцхүү Түүгээр дамжуулан *мөнх бус амьдралын өмнөх* оршихуйнхаа тухай, *мөнх бус амьдралын дараах* хэтийн төлөв хийгээд чадах хийнхаа тухай мэдэж чадна.

Гарамгай Багш Тэрбээр нэг үйл явдлаар үл итгэгч сонсогчдооо хандан тэдэнд Түүнийг гэрчлэгч дараах гурван гэрч байдгийг хэлсэн ажээ:

- Иохан Баптист.
- Есүсийн гүйцэлдүүлсэн үйл хэргүүд.
- Мөнхийн Эцэг Бурханы үг (Иохан 5:33–37-г үзнэ үү).

Дараа нь Тэр дөрөв дэх гэрчээр хангасан юм: “Та нар Судруудыг судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ” (Иохан 5:39).

Дээрх өгүүлбэр дэх *боддог* гэдэг үгийг анх уншихад тохирохгүй байгаа мэт та нарт санагдаж болно. Гэвч энэ нь Есүсийн дамжуулахыг хүссэн утгыг илэрхийлэхэд чухал үг юм. Түүний сонсогчдын олонх нь судруудад мөнх амьдрал байдаг гэж *боддогийг* Тэр мэдэж байжээ. Гэвч тэдний бодол буруу байв. Судрууд дангаараа мөнх амьдралыг өгч *чадахгүй*. Сударт хүч байдаг нь үнэн ч, уг хүч Есүсээс Өөрөөс нь ирдэг. Тэр

бол: Бэлэг тэмдэг буюу Үг юм. Мөнх амийн хүч нь “эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан” (Иохан 1:1; мөн 2 Нифай 31:20; 32:3-ыг үзнэ үү) Түүнд байдаг билээ. Есүс сонсогчдынхоо гөжүүд зангийн улмаас тэднийг зэмлэн: “Та нар [мөнх] амьтай болохын тулд Над уруу ирэхийг хүсдэггүй” (Иохан 5:40) гэжээ.

Их Эзэн бурханлаг мэдлэгээрээ биднийг бишрүүлэн дагуулж чадах ч, Тэрээр тэгдэггүй. Тэр бидний сонгох эрхийг хүндэтгэдэг. Үнэнийг нээхийн баяр баяслыг өөрсдөө нээж олох боломжийг Тэр бидэнд олгодог бөгөөд нүглийнхээ алдаа дутагдлаас наманчлахад биднийг урамшуулан дэмждэг. Түүний бурханлаг хуулинд дуулгавартай байх хүслээс ирдэг эрх чөлөөг биеэрээ эдлэх боломжийг Тэр бидэнд олгосон юм. Тийм ээ, мэдлэгээ ашигладаг Түүний арга зам бидэнд агуу үлгэр жишээ болдог билээ.

Тэвчээр хатуужил

Их Эзэний үлгэр жишээч үйлчлэлийн тав дахь хүчин зүйл бол эцсээ хүртэл тэвчих Түүний тэвчээр хатуужил юм. Тэр хийх ёстой зүйлээсээ хэзээ ч ухарч няцдаггүй байлаа. Хэдийгээр Тэр бидний ойлголтоос хэтэрсэн зовлон тарчлалыг биеэр туулсан ч, үүнээс ухарч няцаагүй юм. Хүнд сорилтууд Түүнд шил дараалан ирж байсан ч, Тэр бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгах үүрэг зорилгодоо эцсээ хүртэл тэвчээртэй байсан юм. Тэрбээр загалмай дээрээс, “Гүйцэлдлээ” (Иохан 19:30) хэмээн сүүлчийн үгээ хэлсэн билээ.

Бид эдгээр таван хүчин зүйлийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Түүний үйлчлэлийн дээрх таван хүчин зүйлийг бид амьдралдаа хэрэгжүүлж болно. Бид Есүсийг бишрэн шүтдэгийн хамгийн сайн нотолгоо бол Түүнийг дагах явдал мөн.

Бид Есүс гэж хэн бэ? гэдгийг, Тэр бидний төлөө юу хийснийг ойлгосон үед: “Чи өөрийн Бурхан Эзэнийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчээрээ хайрлагтун” (Марк 12:30) гэсэн эхний бөгөөд хамгийн агуу зарлигийг тодорхой хэмжээгээр ойлгож чадна. Өөрөөр хэлбэл, бидний боддог, хийдэг, хэлдэг бүх зүйл Түүнийг болон Түүний Эцэгийг хайрлах бидний хайрын үр дүн байх ёстой.

“Их Эзэнээс илүү хайрладаг ямар нэгэн хүн надад байдаг уу?” гэж өөрөөсөө асуу. Тэгээд өөрийнхөө хариулыг Их Эзэний тогтоосон дараах жишгүүдтэй харьцуул:



Мөнх бус байдал дахь Түүний амьдрал үлгэр жишээч үйлчлэлээр дүүрэн бөгөөд үүнд Түүний сургаалууд, сургаалт зүйрлэлүүд болон номлолууд ордог. Тэр бас санваарын эрх мэдлийг өрөвч нигүүлсэнгүй сэтгэлээр хэрэглэдэг байлаа.

- “Эцэгийгээ, эсвэл эхийгээ Надаас илүү хайрладаг хүн Миний хувьд зохистой нэгэн биш юм.”
- Хүүгээ эсвэл охиноо Надаас илүү хайрладаг хүн ч Миний хувьд зохистой нэгэн биш юм” (Матай 10:37).

Гэрийнхнээ болон найз нөхдөө хайрлах *хайр* чухал ч гэсэн, хэрэв энэ нь Есүс Христийг хайрлах хайр дээр үндэслэсэн бол бүр онцгой чухал юм. Үр хүүхдээ хайрлах эцэг эхийн хайр Түүний улмаас энэ амьдралд ч, ирэх амьдралд ч чухал. Хайрын аливаа харилцаа Түүний дотор улам бэхжин өсдөг. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайр нь гэрэл гэгээ, сүнслэг нөлөө, бусдыг илүү сайн арга замаар хайрлах хүсэл эрмэлзлийг бий болгодог билээ.

Ёслолууд мөнхийн үнэ цэнэтэй үйлчлэл үзүүлэхэд анхаарал төвлөрүүлдэг. Эцэг эхчүүд хүүхэд бүрдээ ямар ёслол хэрэгтэй байгааг анхааралдаа байлгах хэрэгтэй. Гэрийн багш нар үйлчилдэг гэр бүл болгондоо ямар ёслол хэрэгтэй байгааг анхаардаг байх ёстой.

Залбирлын талаарх Аврагчийн үлгэр жишээ нь хувийн болон гэр бүлийн залбирал, Сүм дээр хийдэг бүх төрлийн залбирал нь бидний амьдралын салшгүй хэсэг байх ёстойг бидэнд сануулдаг. Тэнгэрлэг Эцэгийн хүслийг мэдэж, биелүүлэх нь бидэнд сүнсний хүч чадал өгч, өөртөө итгэх итгэлийг төрүүлдэг (С ба Г 121:45-ыг үзнэ үү). Бид ямагт Их Эзэний талд байдаг.

“Юмсыг байгаагаар нь мөн тэдгээр зүйлүүдийг үнэхээр байхаар нь” (Иаков 4:13) *мэдэх нь* үнэн зарчмууд хийгээд сургаал дээр үйлдэх боломжийг бидэнд олгодог. Энэхүү мэдлэг бидний зан төлөвийг улам сайжруулдаг. Ийм мэдлэггүй бол, зөв учир шалтгаан хийгээд зөв үйлдлийг амин хувиа хичээсэн бодол санаа давамгайлах болно.

Эцсээ хуртэл тууштай тэвчих гэдэг нь бид үйлчлэх дуудлагаасаа чөлөөлж өгөхийг хүсэхгүй байх явдал мөн. Энэ бол бид зөв зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө тууштай тэмцэж, зөв замаасаа гажсан хайртай хүмүүстээ туслахыг хэзээ ч орхих ёсгүй гэсэн үг юм. Энэ нь бас өвчин зовлон, хөгжлийн бэрхшээл, үхэл хагацал тохиолдсон хүнд үед бид гэр бүлийн харилцаагаа үргэлж бэхжүүлж байх ёстой гэсэн үг.

Их Эзэний өөрчлөгч нөлөө та нарын амьдралыг өөрчлөхийн төлөө би бүх зүрх сэтгэлээрээ залбирч байна. Түүний зорилго, Түүний үйлчлэл бид бүгдийг энэ үед болон үүрд мөнхөд адисалж чадна. ■

БЯИС дээр 1998 оны 8-р сарын 18-нд болсон онцгой цугларалт дээр хэлсэн үгнээс. Англи хэл дээрх бүрэн текстийг speeches.byu.edu -д орж үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 49

Христийн Амилалтын баярын долоо хоног

Бидний Аврагч Есүс Христийн гүйцэлдүүлсэн Цагаатгалд Гетсемани дахь Түүний зовлон шаналал, Голгота дээрх Цовдлолт, амьдралынхаа сүүлчийн долоо хоногт булшнаас Амилан боссон зэрэг үйл явдлууд ордог.

Дэлхий бүтээгдэхээс өмнө Тэнгэрт болсон зөвлөгөөн дээр Бурхан Эцэг Өөрийн хүүхдүүд бидний авралын төлөвлөгөөг танилцуулсан билээ. Тэнгэрлэг Эцэг авралын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Есүс Христийг сонгосон учир бид баярлан уухай хашгирсан ажээ (Иов 38:7, Абрахам 3:27-г үзнэ үү). Бетлехемийн Мариагаас төрсөн Есүс гэм нүгэлгүй амьдарч байлаа. Бид Түүний Цагаатгалын ачаар Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахаар буцаж очин, мөнх амьдралтай болно. Есүс Христ Мянган жилийн үед дэлхий дээр амьдрахаар сүр хүч, алдар суундаа дахин ирж, эцсийн өдөр бүх хүмүүсийн Шүүгч болон зогсох болно.

Дараах зургуудыг Аврагчийн амьдралын сүүлчийн долоо хоногийн үйл явдлуудыг харуулсан Библийн видеонуудаас авсан болно. Зураг бүрийн талаар жагсаасан судрын шүлгүүдийг уншаарай. Үйл явдлуудын бүрэн он дарааллыг Гурамсан судар дахь Дөрвөн Сайн мэдээний зохицол юм уу Судруудын Удирдамжаас үзнэ үү. Библийн видеонууд biblevideos.lds.org-т байгаа.

IMAGES © IRI



Дээгүүр Өнгөрсний
Баяр болохоос тав
хоногийн өмнө Есүс
өмнө нь бошиглогсны
дагуу илжиг унан
Иерусалимд ирлээ.
Хүмүүс Түүнийг
Өөрсдийн хаан
болохыг таньж,
"Хосанна" хэмээн
хашгирч, Түүнд
нөмрөг өмсүүлж,
инжрийн модны
мөчрийг илжигнийх
нь өмнө дэвсэж байв
(Матай 21:1-11; Марк
11:1-11; Зехариа
9:9-ийг үзнэ үү.)



Есүс мөнх бус үйлчлэлийнхээ үед сүмийг хоёр дахь удаагаа цэвэршүүлсэн ажээ. "Миний гэр бол залбирлын гэр гэж нэрлэгдэх болно гэж бичигдсэн байдаг. Гэтэл та нар үүнийг дээрэмчдийн үүр болгож байна" Матай 21:13 гэж Тэр зоос солигчдод хэлсэн билээ. Сүмд байхад нь Түүн рүү сохор, доголлон олон хүмүүс ирэхэд Тэр тэднийг эдгээжээ. Харин ахлах тахилч нар, хуулийн багш нар Түүний үйлдсэн гайхамшигт зүйлсийг хараад ихэд дургүйцэн, Түүнийг хөнөөх арга замыг сүвэгчилж эхэлжээ. Матай 21:12-17; Марк 11:15-19-ийг үзнэ үү.)

Эцэгийн Төрсөн Ганц Хүү Есүс Христ
хүмүүсийг Уналтаас гэтэлгэхийн тулд
дэлхийд бууж ирсэн юм. (1 Нифай
11:16-22, 26-33; Алма 7:10-13.)



Аврагч сүүлчийн долоо хоногийн турш
Өөрийн хамгийн гайхамшигтай зарим
сургаалыг, түүний дотор бэлэвсэн эмэгтэйн
зэс зоосны тухай сургаалыг айлдсан ажээ.
(Марк 12:41-44; Лук 21:1-4-ийг үзнэ үү.)

Аврагч Гетсеманий Цэцэр-
лэгт өвдөг сөгдөн залби-
рахад дэлхийн нүглүүдийн
төлөө Түүнийг "өвдөхийн
улмаас дагжин чичрэх,
сүв бүрээс цус шүүрэх, бие
хийгээд сүнс аль алиныг нь
зовоход" (С ба Г 19:18) хүр-
гэсэн юм. Удалгүй Искар-
иотын Иудас болон зэвсэглэсэн
олон хүмүүс Есүсийг баривч-
лахад бүх шавь нар нь Их
Эзэнийг орхин зугтжээ. (Ма-
тай 26:36-56; Марк 14:32-50;
Лук 22:39-53-ыг үзнэ үү.)




Есүс сүүлчийн зоогийн үеэр төлөө-
лөгчдөдөө Түүнийг явсан хойно тэд
Тайтгаруулагч Ариун Сүнсийг хү-
лээн авах болно хэмээн тэдэнд ам-
ласан билээ. Тэд ариун ёслолоос
хүртсэнээр Түүнийг хэрхэн санан
дурсахыг Тэр заажээ. Есүс тэр
үдэш төлөөлөгчид нь нэг
хүн шиг нэгдмэл бай-
хын төлөө залбирсан
юм. (Матай 26:17-30;
Марк 14:12-26; Лук
22:14-32; Иохан
13-17-г үзнэ үү.)





Түүнийг хууль бус шүүх хурлаар оруулж, харгис хэрцгийгээр ташуурдсаны дараа Есүс Христ Өөрийгөө цовдлолтонд тушааж, Бурханы бүх хүүхдүүдэд авралыг боломжтой болгохын тулд “агуу болоод эцсийн” (Алма 34:14–15-ыг үзнэ үү) золиослолыг гүйцээсэн билээ. Есүсийн дагалдагчид шөнө болохоос өмнө Түүний цогцсыг загалмай дээрээс авч даавуунд ороож, бунхан дотор тавьжээ. (Матай 27; Лук 23; Марк 15; Иохан 19-ийг үзнэ үү.)



Ням гарагийн өглөө Магдалын Мариа болон итгэлтэй бусад эмэгтэйчүүд Есүсийн цогцост тос түрхэхийн тулд бунхан дээр ирээд бунхныг тагласан чулууг хажуу тийш нь авч тавьсныг харав. Хоёр тэнгэр элч: “Тэр энд байхгүй. Тэр амилсан” (Матай 28:6) хэмээн баярт мэдээг дуулгажээ. Амилсан Аврагч биеийн үхлийг ялж, дахин амьдрах боломжийг бид бүгдэд олгосон юм: “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно” (1 Коринт 15:22). (Матай 28; Марк 16; Лук 24; Иохан 20-ийг үзнэ үү). ■

БАПТИСМД БЭЛТГЭХЭД ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАХ НЬ

Жессика Ларсен, Марисса Виддисон нар

Сүмийн сэтгүүлчид

Хүүхэд ахуй насанд анхны туршлагууд үргэлж баяр баясгаланг авчирдаг. Анх удаа дугуй унах, сургуульд орох, шинэ хоол идэж үзэх гээд энэ бүхэн хүүхдийн амьдралд нөлөөлөх сэтгэл догдлом үйл явдал байдаг. Насанд хүрэгчид бид юм бүхнийг шинээр нээх хүүхдийн энэхүү хүсэл эрмэлзэлд туслах үүрэгтэй, бас ийм боломжтой юм. Сүм дэх насанд хүрэгчид бид бас тэдэнд сайн мэдээгээр өсч хөгжихөд нь туслах боломж бий (С ба Г 68:25-ыг үзнэ үү). Хүүхдийн баптисм буюу хайр энэрлээр дүүрэн Тэнгэрлэг Эцэгтэйгээ түүний хийдэг анхны гэрээг сэтгэл догдлом, үр өгөөжтэй үйл явдал болгохын тулд бид юу хийж болох вэ?

“Өсвөр үеийнхэнд эхлээд гэр оронд нь, дараа нь сүм дээр заадаг байх нь энэ Сүмийн үндсэн зорилго мөн” гэж Ерөнхийлөгч Бойд К.Пакер сургажээ.¹

Дараах жишээнүүдэд эцэг эхчүүд хүүхдүүдээ баптисм ба гишүүний баталгааны ёслолуудад хэрхэн бэлтгэсэн тухай туршлагаа хуваалцаж байна.

Бид бүр эртнээс эхэлдэг

“Хүүхдийн долоон нас бол тусгайлан тэмдэглэвэл зохих нас юм” гэж дөрвөн хүүхдийн эх Лори хэллээ. Лори нөхрийнхөө хамт хүүхдүүдээ баптисмын тухай бүр мэдээ орсон цагаас нь эхлэн заадаг ажээ. Гэвч хүүхэд бүрээ долоо хүрэхэд нь тэднийх бүр илүү ихээр тусгайлан бэлтгэдэг байна. Тэд сар бүр гэр бүлийн үдшээ баптисмын гэрээ, Есүсийн үлгэр жишээ гэх мэт баптисмтай холбоотой сэдвүүдээр хийдэг.

Хүүхэд найман нас хүрсэн сарын хичээлүүдэд бүр ч онцгой анхаарал тавих хэрэгтэй гэж Лори ярилаа. Тэр хүүхдүүдээ баптисмын үед өмсдөг хувцсуудыг үзүүлж, баптисмын ёслол гүйцэтгэх үед хүлээн авдаг нэр болон адислалын тухай ярьдаг ажээ.

“Энэ үе бол ариун сүмийн адислалууд дээр анхаарал төвлөрүүлэх хамгийн тохиромжтой цаг юм. Баптисм хүртэх сонголт нь ариун сүмийн адислалуудыг хүлээж авахад бэлтгэх анхны алхам мөн



гэдгийг заахад бид үргэлж анхаардаг” гэж Лори онцлон тэмдэглэлээ.

Бид үүнийг гэр бүлийнхээ үйл хэрэг болгодог

Дөрвөн хүүхдийн эх Моника боломжтой бүх тохиолдолд ах эгч нарыг нь дүү нартаа баптисмд бэлтгэхэд нь туслахад оролцуулахыг зөвлөж байна. “Өсвөр насны дүүгийнхээ гэрчлэлийг сонсож, туршлагаа хуваалцах нь ах эгч нарынх нь итгэлийг нэмэгдүүлдэг” гэж тэр хэллээ. Заримдаа тэд сурсан зүйлээ дүү нартаа зааж өгөхийг ах эгч нараас нь хүсдэг гэж Лори хэллээ.



Бид үүнийг номлолын арга хэрэгсэл болгон ашигладаг

Охиноо найм хүрэхэд охин нь баптисм дээрээ Сүмийн гишүүн бус найз нараа урихыг хүсч байгаа гэдгийг Даниел мэдэж байлаа. Тиймээс тэднийхэн Аллисоны баптисмд ирэх урилгыг сургуулийн болон хөршийн найзуудад нь өгөхөөр шийджээ. Тэд найз нараас нь Аллисоны баптисмд ирэхдээ Библиес өөрсдийн дуртай шүлгүүдээ авчрахыг хүсчээ. Аллисон баптисмын дараа шинэ судрууд дээрээ тэдгээр шүлгийн доогуур зурж, хажууд нь найз нарынхаа нэрийг бичжээ.

“Мэдээж тэр өдөр бид гэр бүлээрээ охиныхоо баптисмд оролцсон. Гэхдээ бид баптисмын дараа найз нартайгаа хамт байж, баптисмын талаарх сэтгэгдлээсээ хуваалцах боломжийг охиндоо олгосон. Охин минь бусдад үлгэр жишээ үзүүлж байгааг харах нь үнэхээр сэтгэл догдлом байсан шүү” гэж Даниел ярилаа.

Бид бишопын ярилцлагыг хийх дадлага хийсэн

Баптисмын насанд ойртож байгаа хүүхдүүдийн эх Кимберли өөрөө найман настай байхдаа баптисмын ярилцлага хийхээр бишопын өрөөнд орсон тухайгаа санадаг ажээ. “Би их сандарч билээ!” гэж Кимберли ярилаа.

Одоо хүүхдүүд нь өөр шиг нь тэгж сандрахгүй гэдэгт тэр итгэлтэй байна. Тэр нөхрийнхөө хамт бишопын ярилцлагатай адил төстэй байдлаар, уг ярилцлагын тухай хүүхдүүддээ ярьж, тэднээс баптисмын тухай асуултуудыг асуудаг гэнэ. Ийм ярилцлага баптисмын тухай бишопын ярилцлагатай хүүхдүүдийг урьдчилан танилцуулж, баптисмын гэрээ тэдэнд хэчнээн чухал болохыг тунгаан бодоход тэднийг урамшуулан дэмждэг ажээ.

Бидэнд гайхалтай сайхан боломж бий

Эдгээр эцэг эхчүүд хүүхдүүдээ баптисм ба гишүүний баталгаанд бэлтгэхдээ тэдэнд дэндүү их ачаалал өгөөгүй гэдгийг хэлж байгаа ч, хэдэн жилийн турш заасан хичээлүүдийнхээ тухай ярихдаа “бүх талаар” “байнга” гэдэг үгсийг ашигласан байна. “Баптисм бол тэдний амьдралд чухал алхам, өөрчлөлт авчрах том үйл хэрэг гэдгийг хүүхдүүд маань ойлгосон гэдэгт бид итгэлтэй байдаг. Хүүхдүүдэд баптисм болон гишүүний баталгааны тухай Хүүхдийн Хэсгийн багш нар заах ёстой гэдэгт найдалгүйгээр, бид өөрсдөө тэднийг дээрх ёслолуудад бэлтгэхэд гол үүрэг гүйцэтгэх хэрэгтэй гэдэгт үргэлж итгэлтэй байдаг” гэж Кимберли ярилаа.

Хайртай хүүхдүүдээ баптисм ба гишүүний баталгаанд бэлтгэхэд туслах гайхамшигтай боломж бидэнд байдаг билээ! Бид үүнийг залбирч хийх юм бол гэрээ хийх энэхүү анхны туршлагыг ирээдүйн сүнслэг өсөлтийн бат бөх үндэс суурь болгоход Их Эзэн бидэнтэй хамт байх болно. ■


Дараагийн хоёр хуудсанд баптисм ба гишүүний баталгааны талаар хүүхдүүдийн асуудаг зарим асуултын хариулт байгаа.

ЭШЛЭЛ

1. Бонд К.Пакер, “Teach the Children,” *Лиакхона*, 2000 оны 5-р сар, 16.

Баптисмыг ойлгох нь

Марисса Виддисон
Сүмийн сэтгүүлүүд



Надад хэн баптисм хүртээх вэ?

Баптисм хүртээх хэн боловч санваар буюу Бурханы нэрээр үйлдэх хүчтэй байх ёстой. Есүс баптисм хүртэхийн тулд санваар атгагч Иохан Баптист дээр очсон билээ (Матай 3:13-ыг үзнэ үү).

Өөрт чинь баптисм хүртээх хүн бишоп буюу салбарын ерөнхийлөгчөөс чинь зөвшөөрөл авах ёстой.



Би баптисм хүртэхийн тулд усан дотор орох шаардлагатай юу?

Есүс усанд умбуулалтаар баптисм хүртсэн юм. Энэ нь Тэр усан дор бүрэн орж, тэр дороо уснаас гарч ирсэн гэсэн үг юм (Матай 3:16-г үзнэ үү). Чи ч гэсэн ийм байдлаар баптисм хүртэх болно. Бид ийм байдлаар баптисм хүртсэнээр хуучин амьдралаа орхиж, Бурхан болон Түүний хүүхдүүдэд үйлчлэхэд зориулах шинэ амьдралаа эхэлдэг.



Би баптисм хүртэхдээ юу амладаг вэ?

Чи баптисм хүртсэнээр Тэнгэрлэг Эцэгтэй гэрээ байгуулах буюу хоёр талын амлалт хийдэг. Чи Түүнд тодорхой зүйлс хийхээр амладаг харин Тэнгэрлэг Эцэг хариуд нь чамайг адислахаар амладаг. Энэ гэрээг ням гараг бүр хэлдэг ариун ёслолын залбирлуудад дүрсэлсэн байдаг (С ба Г 20:77–79-ийг үзнэ үү). Чиний хийдэг амлалт:

- Есүс Христийг санах.
- Түүний зарлигуудыг сахих.
- Христийн нэрийг өөр дээрээ авах гэдэг нь Түүний ажлыг амьдралдаа нэгдүгээрт тавьж дэлхий чамаас хүсдэг зүйлийг биш харин Их Эзэн чамаас хүсдэг зүйлийг хийдэг байх ёстой гэсэн үг юм.

Чи энэ амлалтаа биелүүлэх юм бол Тэнгэрлэг Эцэг Ариун Сүнсийг чамтай хамт байлгаж, нүглийг чинь уучлах болно гэж амладаг.



Ариун Сүнс гэж юу вэ?

Ариун Сүнсний бэлэг бол Тэнгэрлэг Эцэгийн хамгийн үнэтэй бэлгүүдийн нэг мөн. Мелкизедек санваартай эрэгтэйчүүд чиний толгой дээр гараа тавьж, Ариун Сүнсний бэлэг өгснөөр усанд умбуулалтаар хийсэн баптисм чинь бүрэн хүчин төгөлдөр болдог (Иохан 3:5-ыг үзнэ үү).

Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтэний нэг гишүүн юм. Тэр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг гэрчилж, үнэнийг мэдэхэд бидэнд тусалдаг. Ариун Сүнс сүнслэг байдлын хувьд хүчтэй байхад бидэнд тусалдаг. Тэр биднийг аюулаас сэ-рэмжлүүлдэг. Тэр бидэнд суралцахад тусалдаг. Ариун Сүнс бидэнд Бурханы хайрыг мэдрэхэд тусалдаг.

Чамайг Сүмийн гишүүнээр батлагд-санаас хойш хэрэв чи зөв зүйлийг хийх юм бол Ариун Сүнс үргэлж чамтай хамт байх болно.



Би баптисм хүртэхийн тулд яагаад заавал найман нас хүрсэн байх ёстой вэ?

Хүүхдүүд буруу зүйлийг зөв зүйлээс ялгаж ойлгох насанд хүртэл баптисм хүртэх ёсгүй гэж Их Эзэн заасан юм. Судруудад энэ насыг найман нас гэсэн байдаг (Моронай 8:11-12; С ба Г 29:46-47; 68:27-г үзнэ үү).



Ахлагч
Жейро Мазагарди
Далын

Ариун сүмд ойр бай

*Ариун сүм олон сайн хүмүүсийн зүрх сэтгэлд
нөлөөлж, тэдэнд сайхан мэдрэмж төрүүлдэг.*

Намайг Далын Хоёрдугаар Чуулгын гишүүнээр дуудагдахаас өмнө эхнэр бид хоёр Бразилын Кампинас, Сан Паулогийн Ариун ариун сүмүүдэд хэдэн жил үйлчилсэн. Хоёр Ариун сүмийн аль алиных нь дэргэдүүр өнгөрсөн хүмүүс зогсож, дотогшоо орж ирэн, Ариун сүмийн талаар асуултууд асуудаг байсанд би их гайхдаг байлаа.

Тэднийг Ариун сүмд орж ирэхэд, зохих бэлтгэлгүйгээр тэд цаашаа явж болохгүйг бид тэдэнд тайлбарладаг байв. Дараа нь бид Ариун сүмийн зорилгыг тайлбарлаж, сайн мэдээний гол сургаалуудаас хуваалцан, тэднийг номлогчидтой уулзахад урьдаг байлаа. Ариун сүм олон сайн хүмүүсийн зүрх сэтгэлд нөлөөлж, тэдэнд сайхан мэдрэмж төрүүлдэг учраас Ариун сүм өөрөө агуу номлогч болдог.

Манай эхнэр Элизабет бид хоёр ийм мэдрэмжийн хүчийг өөрсдийн туршлагаасаа мэддэг билээ. Бараг 40 жилийн тэртээ Сүмийн гишүүн, бидний нэг сайн найз маань ердийн нэг ярианыхаа далимд бидэнд сайн мэдээний тухай ярьсан билээ. Нэлээд хэдэн удаа тэр бидэнтэй уулзуулахаар номлогчдыг бидэн рүү илгээсэн юм. Номлогчид бидэнд таалагдсан болохоор бид ярилцлага авахыг зөвшөөрсөн ч, үнэнээ хэлэхэд тэдний заасан зүйл бидний сонирхлыг татаагүй.

1978 оны аравдугаар сард найз маань нэлээд хэдэн найзаа, түүний дотор биднийг Бразилын Сан Паулогийн Ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаанд урьсан нь энэ байдлыг



өөрчилсөн юм. Тэрээр хувийнхаа зардлаар нэлээд хэдэн автобус түрээслэн 80 км-ийн зайтай орших Ариун сүм рүү найз нараа авч очсон юм.

Элизабет баптисмын өрөөнд орох үедээ урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй ямар нэг онцгой мэдрэмжийг мэдэрчээ. Хожим нь энэ нь Ариун Сүнс байсныг тэр мэдсэн. Тэр мэдрэмж түүний зүрх сэтгэлд агуу баяр баяслыг авчирсан юм. Элизабет яг тэр агшинд Сүм үнэн гэдгийг бас энэ Сүм бол түүний элсэх ёстой сүм мөн гэдгийг мэджээ.

Нээлтийн үйл ажиллагааны төгсгөлд биднийг лацдалтын өрөөнд орох үед мөн мөнхийн гэр бүлүүдийн сургаалыг бидэнд заах үед яг дээрхтэй адил мэдрэмж надад төрж билээ. Уг сургаал миний сэтгэлийг ихэд хөдөлгөв. Би мэргэжлээрээ амжилттай ажиллаж байсан ч оюун санаандаа урт удаан хугацааны туршид хоосон орон зайг мэдэрдэг байлаа. Энэ хоосон зайг юугаар дүүргэхийг би мэддэггүй байв. Гэр бүлийнхээ талаар ямар нэг зүйл хийх ёстой юм шиг санагддаг байлаа. Лацдалтын өрөөнд ормогц онцгой сонин мэдрэмж, оюун ухаан, зүрх сэтгэлийг минь зэрэг эзэмдэв.

Хэд хоногийн дараа номлогчид бидэнтэй дахин холбоо барив. Энэ удаад бид тэдний захиасыг сонсохыг үнэхээр их сонирхож байлаа.

Ахлагч нар биднээс үнэний тухай чин сэтгэлээсээ залбирахыг хүслээ. Энэ бол миний хувьд залбирч болох цорын ганц зам байлаа. Гэрчлэлгүй байж Сүмд элсэх шийдвэр гаргаж болохгүй гэдгийг би мэдэж байв. Би Тэнгэрлэг Эцэгт хандан баталгаа хүсч залбирах хэрэгтэйгээ мэдэж байлаа. Бас Тэр миний залбиралд хариулна гэдэгт ч итгэлтэй байлаа. Би зүрх сэтгэлийнхээ чин хүслийг Түүнтэй хуваалцаж, Сүмд элсэх нь миний хувьд зөв зам мөн үү гэдэгт хариу өгнө үү гэж Тэнгэрлэг Эцэгээсээ гуйлаа.

Дараагийн долоо хоногт биднийг Ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаанд урьсан манай найз ням гарагийн хичээл дээр миний хажууд сууж байлаа. Тэр бөхийж

надтай ярьж эхэллээ. Түүний хэлсэн үгс миний мэдэхийг хүсч залбирсан тэдгээр зүйлсийн тухай байлаа. Тэнгэрлэг Эцэг түүгээр дамжуулан надтай ярьж байгаад би эргэлзээгүй. Би тэр үед хатуу сэтгэлтэй, хахир хүн байсан. Гэвч зүрх сэтгэл маань уяран хайлж би уйлж эхэллээ. Найз маань ярьж дуусаад эхнэр бид хоёрыг баптисм хийлгэнэ үү гэж урилаа. Бид түүний урилыг хүлээн авсан.

Бид Сан Паулогийн Ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаанд оролцсоноос хойш бүтэн сар бололгүй, 1978 оны 10-р сарын 31-нд баптисм хүртэж, гишүүнээр батлагдлаа. Маргааш нь бид Бразилын Сан Пауло Ариун сүмийг адислах хоёрдахь ёслолд оролцов. Жилийн дараа бид хоёр хүүтэйгээ лацдан холбуулахаар Ариун сүмд буцаж очив. Эдгээр гурван үйл явдал бүгд бидний сэтгэлд хоногшин үлдсэн, маш сайхан туршлага болсон юм. Бид түүнээс хойш олон жилийн туршид Ариун сүмд тогтмол орж, энэхүү сайхан мэдрэмжийг хөгжүүлсээр ирсэн билээ.

Эхнэр бид хоёр баптисм хийлгэснээсээ хойш хорин найман жилийн дараа Бразилын Сан Пауло Ариун сүмд дахин ирсэн. Би энэ Ариун сүмийн ерөнхийлөгчөөр дөнгөж дуудагдаад байлаа. Их Эзэний өргөөн дотор явж үзэхэд бидэнд онцгой сайхан мэдрэмж төрлөө. Энэхүү онцгой сайхан мэдрэмжийг бид дахин мэдэрсэн бөгөөд энэ нь бидний хөрвөлтөд шийдвэрлэгч нөлөө үзүүлсэн юм.

Ариун сүм эхнэр бид хоёрт аз жаргалын ширгэшгүй ундарга болсоор байна. Мөнхийн гэр бүл болж лацдан холбуулахаар Ариун сүмд ирж байгаа залуу хосуудыг харахад бидэнд агуу найдвар төрдөг билээ.

Дэлхий даяар үй олон хүмүүс сайн мэдээний захиасыг сонсохын тулд бэлтгэгдэж байна. Тэд 30 жилийн тэртээ миний мэдэрсэнтэй адил зүйлийг мэдрэхийг эгээрэн хүсч байна. Ариун сүм болон тэнд гүйцэтгэдэг ёслолууд нь тэдний энэхүү хүслийг хангаж, оюун санаан дахь хоосон зайг нь бөглөх хүчтэй юм. ■

ОНГОЦОНД НЭГ Л ЮМ БОЛОХГҮЙ БАЙЛАА

Нэг орой би зорчигч дүүрэн суулгасан онгоцоо газар дээгүүр гүйлгэж байх үед онгоцны жолооны системд ямар нэг зүйл болохгүй болсныг мэдэрлээ. Би сүнсээр мэдэрсэн зүйлээ батлахын тулд замаас гарч 360 градус эргэлээ. Бүх зүйл хэвийн байх шиг санагдав.

“Газраас хөөрч, зорчигчдоо хүрэх газарт нь цагт нь хүргэх үү эсвэл онгоцны буудал руу буцаж очих уу?” хэмээн би гайхширлаа. Буцна гэдэг нислэгийг олон цагаар хойшлуулна гэсэн үг. Онгоцны зам ганцхан чиглэлтэй. Тиймээс би газар дээрх хяналтын алба надад зам гаргаж өгөхийг хүлээн, замаар эсрэг талаас нь онгоцоо газар дээгүүр гүйлгэх болно. Тэгээд засварын баг ирж

онгоцонд үзлэг хийхийг хүлээнэ. Нислэг хойшлох нь нислэгийн алба, зорчигчид аль алинд нь төвөг удаж, зорчигчдыг өөр онгоцонд суулгах гэх мэт олон асуудал үүсгэх болно. Засварын алба миний совинд юу гэж хариулахыг бас мэдэхгүй байлаа. Онгоцонд ямар нэг зүйл болохгүй болсныг би сүнсний өдөөлтөөс өөр юугаар ч нотолж чадахгүй шүү дээ гэж бодлоо.

Би онгоцны ахмадын хувьд онгоцны баг болон зорчигчдын аюулгүй байдлын төлөө хариуцлага хүлээх учраас сүнсний мэдрэмжээ дагаж, буцахаар шийдэв.

Хаалган дээр хүрч ирээд онгоцонд ямар нэг зүйл болохгүй байгааг мэдэрсэн ч чухам юу вэ гэдгийг

мэдэхгүй байна гэдгээ механикчид хэлэв. Онгоцонд ямар нэг зүйл болохгүй байгаа гэдэгт тэр итгэхгүй байв.

“Зам нойтон байгаагаас танд тэгж санагдсан байх. Нойтон засмал дээр халтирсан юм болов уу” гэж механикч хэлсэн ч, дугуйны хамардахь жолоодлогын төхөөрөмжийг шалгаж үзэхийг зөвшөөрлөө. Тэгээд туршиж үзэхийн тулд зорчигчдоо буулгахыг тэр надаас хүсэв.

Механикч 30 минутын дараа эргэж ирэхдээ санаа нь их зовсон харагдлаа. Туршилтын үед тэр үе үе ямар нэгэн юм хавирах чимээ гарч байхыг сонсчээ. Тэгээд хаалга руу эргэх үед тоормосоо таттал онгоц хяналтаас гарч замаасаа золтой л гарчихсангүй гэнэ.

Нарийн шалгаж үзэхэд урьд орой нь тоормосны системд хийсэн засварыг зохих ёсоор хийгээгүй нь илрэв. Хэрэв би тэр чигээрээ ниссэн бол буух үед тоормос гацаж, онгоц хяналтаас гарах байжээ.

Тэгээд би өөр онгоцоор гурван цагийн дараа зорчигчдоо хүрэх газарт нь аюулгүй хүргэж билээ.

Би Сүнсний шивнээг сонсож, дагасандаа баяртай байлаа. Хэрэв бид Их Эзэний удирдамжийг сонсож, Сүнсний өдөөлтийг дагавал Сүнс биднийг удирдах болно гэдгийг би мэднэ. ■

Крейг Вилли, Юта, АНУ

Засварын алба миний совинд юу гэж хариулахыг бас мэдэхгүй байлаа. Онгоцонд ямар нэг зүйл болохгүй болсныг би сүнсний өдөөлтөөс өөр юугаар ч нотолж чадахгүй шүү дээ гэж би бодлоо.



АМЬДРАЛААС БАЯР БАЯСГАЛАНГ ОЛОХУЙ

Би нэг удаа Арванхоёр Төлөө-лөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скоттын ерөнхий чуулган дээр хэлсэн үгийг уншиж байлаа. Би энэ үгийг өмнө нь уншиж, сонссон ч нэг өгүүлбэр миний анхаарлыг онцгой татсан учир бодол минь түүн дээр тогтлоо.

Хэдэн цагийн дараа найз нартайгаа хамт амьдардаг хүү маань айлчлан ирэв. Тэр бүрэн цагийн номлолд үйлчилсний дараа коллежид ороод ганц хоёр улирал явсан ч, ямар сургуульд орж, ямар мэргэжилтэй болохоо хараахан шийдээгүй байв. Тэр коллежид сэтгэл дундуур байсан учраас цаг хугацаа, мөнгөө дэмий үрж байна гэж бодоод сурахаа хойш тавин, сургуулиасаа гараад ажил хийж байгаа билээ.

Найз нарынх нь нэг нь хоёулаа Багамын арлууд юм уу Карибын тэнгисийн нэг арал дээр очоод тэндээ ажил хийж, хэдэн сарыг хөгжилтэй өнгөрүүлэе гэж санал болгосон тухай хүү маань надад ярих. Найзынхаа энэ саналд манай хүү сэтгэл нь хөдөлсөн ажээ. Иймэрхүү зугаалгын шинжтэй аялал залуу хүнд хэрхэн муугаар нөлөөлж болохыг ойлгоход ядаж цөхөх юмгүй байлаа.

Энэ үед Ахлагч Скоттын сэтгэлд хоногшим захиас миний санаанд орж ирлээ. Тэгээд би *Ensign* сэтгүүлийг авч дараах үгсийг хүүдээ уншиж өгөв: “Та нар энд дэлхий дээр бурханлаг зорилгын төлөө байгаа билээ. Эцэс төгсгөлгүй зугаа цэнгэл хөөцөлдөх нь та нарын зорилго биш. Та нар соригдохын тулд Бурхан та нарт бэлтгэсэн олон адислалыг хүлээн авч чадахаа нотлон харуулахын тулд дэлхий дээр байгаа билээ. Үүнд тэвчээр

шаардагдана” (“Finding Joy in Life,” *Ensign*, 1996 оны 5-р сар, 25).

Хүү маань ганц ч үг хэлсэнгүй, сэтгүүлийг авч яваад түүний хэлсэн үгийг бүхэлд нь уншсан. Дараа нь тэр арал руу адал явдал хайж явахгүй гэдгээ хэлж билээ.

Хүү минь цагдаагийн академид орж, ирээдүйн эхнэртэйгээ тэнд танилцсан юм. Тэр хоёр Аризоны Меса Ариун сүмд гэрлэж одоо гурван сайхан хүүхэдтэй гэр бүл болсон. Хүү минь 2010 онд сургуулиа бакалаврын зэрэгтэй дүүргэж “амьдралаас үнэхээр баяр баясгаланг олсон юм.”

Хүүд минь санал болгосон адал явдлын аялал түүнд аятайхан

туршлага болж мэдэх байсан биз ээ. Гэвч энэ нь сүнслэг байдлын хувьд эрсдэлтэй, аюултай байж болох байсан. Энэ явдлын тухай бодох бүрд Сүнс миний зүрх сэтгэлд нөлөөлдөг билээ.

Бошиглогчийн үгс болон Ахлагч Скоттын хэлсэн үгийг цагаа олж санасандаа би талархалтай байдаг. Бас хүү минь Их Эзэний элчийн үгийг уншиж, өөртөө нөлөөлөх боломжийг Сүнсэнд олгосонд баяртай байдаг. Бид Аврагчийн сургаалуудыг болон Түүний үйлчлэгчдийг дагасан үед олон адислал, ивээл нигүүлсэл бидэнд ирэх болно гэдгийг би мэднэ. ■

Карен Роквуд, Айдахо, АНУ



Найз нарынх нь нэг нь Багамын арлууд юм уу Карибын тэнгист хамт очиж хэдэн сарыг хөгжилтэй өнгөрүүлэе гэж санал болголоо хэмээн хүүгээ хэлэх үед Ахлагч Скоттын захиас миний санаанд орж билээ.

УТСЫГ САЛГАСАН БАЙЛАА

Нөхөр бид хоёр 1997 оны 3-р сард Оросын Ростов-на-Дону хотод амьдарч байхдаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртсэн.

Сүмийн сургаалуудыг судлах явцад миний олон асуулт хариулагдсан. Авралын төлөвлөгөөний тухай түүний дотор нас барагсдын өмнөөс баптисм хүртдэг явдал нь миний сонирхлыг их татаж билээ. Бид нас барсан өвөг дээдсийнхээ өмнөөс баптисм хүртэж болдгийг сонсоод би их гайхсан.

Биднийг баптисм хүртсэнээс хойш жилийн дараа номлолын ерөнхийлөгч биднийг Ариун сүмд явахаар бэлтгэхийг урив. Бид бэлтгэлийнхээ нэг хэсэг болгон гэр бүлийн түүхээ судалж эхэллээ. Нэг өдөр энэ ажлаа хэрхэн хийх тухай бодож байтал утас дуугарав. Хадам ээж утасдсан байлаа. Би түүнээс нөхрийнхөө талын нас барсан өвөг дээдсийн нэрсийн жагсаалт ирүүлэхийг хүслээ. Хадам ээж их гайхаж, нас барагсдын өмнөөс хийх баптисм бол Христийн сургаал

биш, энэ бол Мормончуудын санаанаасаа зохиосон зүйл гэх нь тэр. Би энэ сургаалын тухай өгүүлдэг судрын ямар нэг эшлэлийг мэдэхгүй учраас юу гэж хариулахаа мэдсэнгүй.

Намайг юу гэж хариулахаа бодож байх үед утас салсан байлаа. Би юу болсон юм бол гэж гайхан утсаа тавиад унтлагын өрөө рүүгээ явлаа. Би Шинэ Гэрээг гартаа бариад өвдөг сөгдөн залбирч, асуултын хариут хаанаас олохыг хэлж өгнө үү гэж Тэнгэрлэг Эцэгээс гуйлаа.

Би залбирч дуусаад Библи нээтэл хэн нэгэн нь нээсэн хуудасныхаа 29-р шүлгийг унш гэж надад хэлэх шиг санагдав. Энэ бол нас барагсдын баптисмын сургаалын тухай өгүүлдэг 1 Коринтын 15-р бүлэг байлаа.

Тэнгэрлэг Эцэг миний залбиралд яг цагийг нь олж хариулсанд миний сэтгэл их хөдөлж, бас их гайхлаа. Энэ бол маш сайхан мэдрэмж байлаа.

Би энэ явдлын тухай гүн бодолд автан байтал гэнэт утас дахин дуугарав. Хадам ээж яагаад утас тасарчихав гэж асуухад би мэдэхгүй гэж хариулаад түүнээс Библиэ гаргаж, 1 Коринт 15:29-ийг уншихыг хүслээ.

Хэд хоногийн дараа нас барсан төрөл төрөгсдийн нэрсийн жагсаалт миний ширээн дээр байлаа. Хадам ээж нөгөөх судрыг уншиж, Төлөөлөгч Паулаар дамжуулан Аврагч нас барагсдын баптисмын тухай сургаалыг заасанд итгэдэг болсон билээ.

Гэтэлгэлийн энэхүү ажлыг хийдэг хүмүүст Бурхан агуу адислалууд амласан билээ. Би үүнийг үнэн гэдгийг мэднэ. ■

Седа Мелисетян, Армени



Хадам ээж надад нас барагсдын өмнөөс хийдэг баптисм бол Христийн сургаал биш Мормончуудын санаанаасаа зохиосон зүйл гэж хэлэв.

БИ ИЙМ СЭТГҮҮЛИЙГ ХААНААС АВЧ БОЛОХ ВЭ?

Би гэр бүлийнхээ хамт АНУ-ын Невадагаас Аляск руу аяллаар явах үедээ өөдөөс минь харж суусан өндөр нуруутай, нүдэнд дулаан, ялдамхан эмэгтэйтэй удаан ярилцлаа.

Тэр надаас хаашаа явж байгааг асуухад би Аляскийн Жунеау руу хүүгийн дээ зочлохоор явж байгаагаа хэллээ. Тэр эмэгтэй Лас Вегасаас явж байгаагаа хэлэв. Дараа нь түүний сэтгэл хөдөлж, 20 жил ханилсан талийгаач нөхрийнхөө гэгээн дурсгалыг тэмдэглэх үйл ажиллагаанд оролцохоор Жунеау руу хадмууд дээрээ очихоор явж байгаагаа ярилаа. Нөхөр нь саяхан хавдраар нас барсан ажээ.

Би түүнийг хараад авралын төлөвлөгөөг мэддэг бөгөөд Лас Вегасын Ариун сүмд ажилладаг нь миний хувьд ямар азтай тохиолдол вэ? хэмээн бодлоо. Энэ эмэгтэйн сэтгэл санааг өргөхийн тулд би юу хийж болохоо бас бодлоо.

Тэгтэл би Нийгмийн Халамжийн Бүлэгт Бошиглогч Иосеф Смитийн нэгэн эшлэлийг тарааж өгч байснаа гэнэт тодхон саналаа. Тэрбээр Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулахдаа эгч нар “ядарсан нэгэнд туслахдаа шуурхай байж, зовж зүдрэгсдийн шархалсан зүрхэнд тос, дарс асгаж, өнчрөгсдийн нулимсыг хатааж, бэлэвсэн эмэгтэйчүүдийг баярлуулж байх ёстой” гэжээ. (Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит [2007], 452).

Би түүн рүү дахин харлаа. Зовж шаналсан танихгүй нэгэн, зүрх сэтгэл нь шархалсан бэлэвсэн эмэгтэй



Нөхөр нь саяхан нас барсан энэ эмэгтэйн сэтгэл санааг өргөх юуг би хийж болох билээ? хэмээн би бодлоо.

миний нүдэнд харагдав. Урьд өдөр нь би 2011 оны *Ensign* сэтгүүлийг уншиж байснаа бас тэр сэтгүүлд энэ эмэгтэйд урам хайрлаж, тайтгаруулан, сэтгэл санааг нь өргөж болох өгүүлүүд байсныг саналаа.

Тэгээд би зориглон, сэтгүүлийн нэг өгүүлэлийг нээн, уг өгүүллийг уншина уу гэж түүнээс хүслээ. Тэр өгүүллийг үт үсэг гээлгүй анхааралтай уншиж байв. Тэр уншиж дуусаад өөр нэг өгүүлэл уншиж эхэллээ.

Уншсан зүйл нь түүний зүрх сэтгэлд нөлөөлсөн нь илт байлаа. Тэр сэтгүүлийг цээжиндээ тэврээд нүдэн дэх цийлэгнэсэн нулимсаа арчлаа.

“Би ийм сэтгүүлийг хаанаас авч болох вэ?” гэж тэр надаас асуув. Энэ сэтгүүлийг авч болно гэж би түүнд хэллээ. Дараа нь тэр дахиад уншиж эхэлсэн.

Биднийг Жунеауд ирэхэд тэр эмэгтэй гараас минь барьж, миний нүд рүү эгцлэн ширтсэнээ “Их баярлалаа!” гэж хэлэв.

Би энэ явдлаас их сургамж авсан. Урам хайрласан найрсаг үг сонсох хэрэгтэй байгаа мөн Хожмын Үеийн Гэгээнтнүүд бидний мэддэг зүйлийг мэдэх хэрэгтэй байгаа зүрх сэтгэл нь шархалсан танихгүй хүмүүс бидний эргэн тойронд үргэлж байдаг. ■ Шарон Ратер, Невада, АНУ

Та зарим үед ямар нэг сайн зүйлийг
бүр илүү сайн зүйлийн төлөө орхих
хэрэгтэй байж болно.

Илүү сайныг сонгох нь

Маттью Д.Элиттон

Сүмийн сэтгүүлүүд

Унгарын Сегедийн Золтан Германд болох ганц хүний сэлүүрт завийн тэмцээнд явахгүй гэж дасгалжуулагчдаа хэлэхэд дасгалжуулагч нь их гайхжээ.

“Тэр өдөр миний баптисмын өдөр учраас би явахгүй гэж хэлсэн юм” гэж Золтан ярих.

Золтан 17-той бөгөөд ганц хүний сэлүүрт завины олон тэмцээнд түрүүлжээ. Энэ бол Унгарт их дэлгэрсэн спорт юм. Золтан спортын энэ төрлөөр сайн тамирчин байсан төдийгүй бүр мэргэжлийн тамирчин болох найдвар ч түүний хувьд бодит зүйл байв. Золтан нэг тэмцээнд явахгүй байхаар шийдсэнээсээ хойш удалгүй сэлүүрт завины спортыг бүрмөсөн орхисон ажээ. Үүнээс илүү сайн ямар нэг зүйлийг хийх хэрэгтэй байжээ.

Ганц хүний сэлүүрт завийн спорт Золтанд ашиг тусаа өгчээ. Тэр олон жилийн турш дасгалжуулагчтайгаа ажиллахдаа өөртөө хяналт тавьж, дуулгавартай байж, шаргуу ажиллаж сурсан гэнэ. Золтан бас амжилтад нь муугаар нөлөөлж болох бодисууд болон дадал зуршлаас зайлсхийж сурсан ажээ. Ганц хүний сэлүүрт завиар хичээллэх нь тун амаргүйгээс гадна үргэлж ганцаараа зүтгэнэ. Мэргэжлийн тамирчин больё гэвэл бүр их цаг шаардана.

Мэргэжлийн тамирчид өдөрт 12 цаг сургуулилт хийж, ням гарагт тэмцээнд оролцох ёстой.

“Ганц хүний сэлүүрт завины спорт миний хамаг цагийг авдаг байсан. Би энэ спортод үнэхээр их дуртай байлаа. Үүнээс болж би амьдралдаа олон зүйлийг орхигдуулсан” гэж Золтан ярилаа.

Чухамдаа иймээс Золтан өөрийгөө сайн мэдээ болон ганц хүний сэлүүрт завианд нэгэн зэрэг зориулж чадахгүйгээ ойлгосон ажээ. Тэр 2004 онд ганц хүний сэлүүрт завиар цаашид хичээллэхгүй гэдгээ дасгалжуулагчдаа хэлжээ.

Тэр жилийн эхээр номлогчид Золтанийн ээжид зааж эхэлсэн байна. Золтан хичээлд суудаггүй байв. Ээж нь баптисмдаа урихад тэрээр урилыг дурамжхан хүлээн авсан гэнэ. Гэвч нэг удаа сүмийн байранд орж үзтэл зүрх сэтгэлд нь нэгэн онцгой мэдрэмж төржээ. Золтан номлогчидтой уулзахыг зөвшөөрөв. Учир нь тэр тэднийг таньдаг байлаа.

“Номлогчид жирийн хүмүүс боловч өндөр жишгээр амьдардаг учраас миний сонирхлыг татсан юм” гэж тэр хэллээ.

Золтан ганц хүний сэлүүрт завиар хичээллэдэг байхдаа өндөр жишгээр амьдардаг байсан учраас сайн мэдээний сургаалуудыг үнэ цэнэтэй

зүйл хэмээн хүлээн авчээ. Тэр хоёр сарын дараа баптисм хүртэв.

Эхлээд тэр сэлүүрт завиар хичээллэхээ үргэлжлүүлж болох юм, харин ням гарагт тэмцээнд оролцохгүй гэж бодож байжээ. Гэвч тэрээр ямар нэг зүйлийг оролдвол түүндээ өөрийгөө тэр чигээр нь зориулдаг тул завиар хичээллэхээ бүрмөсөн орхихоор шийджээ.

Баптисмынхаа дараа тэр ганц хүний сэлүүрт завиар хичээллэх явдлаа өөрийн хобби болгохоор шийджээ. Тэр үед дасгалжуулагч нь бусдыг дасгалжуулж, аялал зохион байгуулахад туслахыг түүнээс хүссэн аж. Гэвч тэр дуулгавартай байхад нь саад болох юуг ч хийхийг тэр байтугай завиар сэлэхийг ч хүсээгүй байна.

Гэвч Золтан сэлүүрт завиа бүрмөсөн орхиж, гэрлээд Ерөнхийлөгч Ховард В.Хантертай (1907–95) адил арга замаар Сүмд үйлчлэхэд өөрийгөө зориулахаар шийджээ. Ерөнхийлөгч Ховард В.Хантер арав гаруй хөгжмийн зэмсгээр гарамгай тоглодог сайн хөгжимчин байсан юм. Тэр оройн цагаар найрал хөгжим тоглодог байсан ч хамтран тоглодог хүмүүсийн амьдралын хэв маяг сайн мэдээний жишгүүдтэй харшилдаг байв. Тиймээс Ерөнхийлөгч Хантер хөгжмөө орхиж, зөвхөн



*Золтан сайн
мэдээнд илүү их
цагийг зориулахын
тулд сэлүүрт завийн
спортоо орхижээ.*



гэр бүлийн үйл ажиллагааны үеэр л хөгжимддөг болжээ.¹

Золтан сэлүүрт завийн спортоо санадаг ч, хэрэв энэ спортод хэт их дурлавал, Их Эзэнийг хайрлах хайр нь тэр хэмжээгээр суларч болно гэдгийг ойлгосон байна.

Энэ зарчим нь биднийг Бурханаас холдуулах бүхий л үйл ажиллагаанд мөн адил хамаарна. Бид бүгд насан туршдаа зарим нэг зүйлийг, тэдгээр нь зарим талаараа сайн зүйлс ч байсан гэсэн бидний мөнх амьдралд эрсдэл учруулж болзошгүй бол тэдгээрийг орхих нь зүйтэй.

“Сүм миний амьдрал болсон. Хэрэв би сэлүүрт завины спортоор хичээллэхээ үргэлжлүүлж, амжилт олохыг хүсвэл энэ нь хобби л байхаас биш, үүгээр амьжиргаагаа залгуулж чадахгүй шүү дээ. Ийм болохоор үүнийг хаяхад амархан юм. Сэлүүрт завины оронд би хамаг анхаарлаа Тэнгэрлэг Эцэг дээр төвлөрүүлэхийг хүсдэг болсон” гэж Золтан ярилаа.

Золтан ямар ч зүйлд тууштай ханддаг шигээ тийм л эрч хүчээр сайн мэдээг судалж, номлолд үйлчлэх зорилго тавьжээ. Тэр эх орондоо байж, бусдад заахыг хүсч байлаа.

Тэр Унгарт үйлчилснийхээ дараа ахлах сургуульд англи хэлний багшаар ажиллаж байгаа бөгөөд сайн мэдээг амьдралдаа нэгдүгээрт тавьсан хэвээр байна. “Бурханы зам дээр гарахын тулд хаях хэрэгтэй зүйлс бидэнд байдаг. Муу зүйл гэдгийг нь бид мэддэг бол тэдгээрийг хаяхад амархан. Бид ямар нэг сайн зүйлийг бүр илүү сайн зүйлээр солихын тулд хэзээ зогсох ёстойгоо ихэвчлэн мэддэггүй. Тухайн зүйл нь муу биш учраас бид үүнийгээ хадгалахын зэрэгцээгээр Бурханы төлөвлөгөөг дагаж болно гэж боддог” тухайгаа тэр ярилаа. Гэвч тэрхүү сайн зүйл нь Бурханы төлөвлөгөөг дагахад саад учруулбал бид түүнийг хаях ёстойг Золтан мэддэг ажээ. ■

ЭШЛЭЛ

1. Эленор Нөүвлес, *Ховард В.Хантер* (1994), 81-ийг үзнэ үү.

“Ариун явдлын хуулийг зөрчих нь яагаад ноцтой нүгэл болохыг би найздаа яаж тайлбарлах вэ?”

Тэнгэрлэг Эцэг биднийг аз жаргалтай, Түүний Сүнсний хүлээн авахаар зохистой байхыг хүсдэг. Тиймээс тэр бидэнд бодол санаа, хэл яриа, үйл хэрэг, үйлдлээ зохих хязгаарын дотор барьдаг байхад туслахын тулд бидэнд зарлигуудыг өгдөг

билээ. Ариун явдлын хууль нь нөхөн үржихүйн хүчийг гэрлэлтийн хүрээнд хадгалахад тусалдаг. “Хүүхдүүд албан ёсоор хуримласан гэр бүлд төрж өсөх эрхтэй” учраас нөхөн үржихүйн хүч зөвхөн нөхөр, эхнэр хоёрын хооронд байх ёстой хэмээн Тэрбээр зарлиг болгосон юм.”¹

Та *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг найзтайгаа хуваалцаж болно. Энэ товхимол ариун явдлын хуулийг сахих нь яагаад чухал болох тухай хэдэн шалтгааныг тайлбарлажээ: “Та нар бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун байснаар Ариун сүмд эрхэм нандин гэрээнүүд хийж, сахихад өөрийгөө бэлтгэдэг билээ. Та нар хайр халамжаар дүүрэн мөнхийн гэр бүлийн нэг хэсэг болох хүүхдүүдийг энэ дэлхийд авчрах бат бөх гэрлэлтэнд өөрсдийгөө бэлтгэдэг. Та нар гэрлэлтээс гадуур бэлгийн харьцаанаас үүдэлтэй сэтгэл санаа болон сүнслэг байдлын уналтаас өөрсдийгөө хамгаалах болно. Мөн та нар хор хөнөөлтэй өвчнүүдээс өөрсдийгөө хамгаалдаг. Бэлгийн харьцаандаа цэвэр ариун байх нь та нарыг өөртөө итгэлтэй, жинхэнэ аз жаргалтай мөн одоо болон ирээдүйд зөв сайн шийдвэрүүдийг гаргах чадвараа сайжруулахад тань туслах болно.”²

Ариун сүм



Бидний хүн нэг бүрийн талаар бурханлаг зорилго Тэнгэрлэг Эцэгт байдаг бөгөөд уг зорилго нь Ариун сүмд хэрэгждэг. Бид гэр бүлээрээ үүрд мөнхөд лацдан холбуулахын тулд Ариун сүмд орохоор зохистой байх ёстой. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт амьдрах болно. Хамгийн чухал нь зохисгүй хүмүүсийн хүлээн авч чадахгүй үүрдийн баяр баясгаланг бид хүлээн авах боломжтой.

Алофа М., 18 настай, Самоа

Гэрлэлт ба гэр бүл



Биднийг бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун байх юм бол, Ариун сүмд орж, ариун нандин гэрээнүүдийг сахихаар зохистой

байхыг дэмждэг. Хэрэв бид ариун явдлын хуулийг дагавал ирээдүйд бид бат бөх гэрлэлт ба гэр бүлтэй болж чадна. Сатан биднийг уруу татахаар үргэлж бэлэн байдаг боловч залбирал, судар ба сайн найз нарынхаа тусламжтайгаар бид уруу таталтыг давж чадна.

Рести М., 16 настай, Филиппин

Цэвэр ариун байдал ба хүндэтгэл

Бид ариун явдлын хуулийг сахиснаараа Бурханы мэлмийд цэвэр ариун харагдаж, өөртөө хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ бусдыг бидэнд хүндэтгэлтэй хандахад нь тусалдаг. Хэрэв бид ариун явдлын хуулийг дуулгавартай сахьвал Бурханы хүүхдүүд гэдгээ харуулж, өндөр жишгүүдээ чанд баримталж чадна. Бидэнд харамсах зүйл байхгүй болно. Бид ялангуяа энэ хуулийг сахих талаар Тэнгэрлэг Эцэгийнхээ хүслийг биелүүлбэл, бидний амьдрал энэ дэлхий дээр ч, ирэх дэлхийд ч аз жаргалаар дүүрэн байх болно.

Альяна Ж., 19 настай, Филиппин

Ариун журам ба Ариун явдал



Их Эзэн ариун журам ба ариун явдалд баярладаг бөгөөд юм бүхэн өөрийн цаг хугацаанд болж өнгөрдөг. Ариун явдлын хууль бол Их

Эзэнээс бидэнд өгсөн зарлиг юм. Залбирал ба Ариун Сүнсний нөхөрлөл бол ариун явдалтай байх нь адислал мөн гэдгийг ойлгоход туслах маш чухал хоёр зүйл мөн.

Селин Р., 18 настай, Никарагуа

Хариултууд нь туслах болон ирээдүйг харахад зориулагдсан бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

Ариун бэлэг

Хэрэв бид нөхөн үржихүйн бэлэгт хөнгөн хуумгай хандвал Бурханы энэхүү үнэт бэлгийг ердийн зүйл мэт үзсэнтэй адил юм. Таныг бэлэг өгөхөд бэлэг авч байгаа хүн үүнийг онцгой үнэ цэнэтэй зүйл гэж үзэхгүй бол танд сайхан санагдахгүй. Нөхөн үржихүйн хүчийг хүн ариун зүйл гэж үзэн, үүнд үргэлж хүндэтгэлтэй хандаг байх ёстой. Учир нь бид бүгд Бурханы Ариун сүм учраас Ариун сүм шиг цэвэрхэн, ариун байх ёстой. *Жарон 3., 15 настай, Айдахо, АНУ*

Сүнс бидэнтэй хамт



Та гэм нүгэлгүй цэвэр ариун байснаараа, улам аз жаргалтай амьдарч, илүү ихээр адислагдах болно.

Бидний бие махбод Ариун сүмтэй адилхан бөгөөд Тэнгэрлэг Эцэг “ариун бус сүмд оршдоггүй билээ” (Алма 7:21). Иймээс бид гэм нүгэлгүй цэвэр ариун байх юм бол, Сүнс бидэнд орших болно. *Марианн Р., 14 настай, Арканзас, АНУ*

Чухал асуултууд

“Ирээдүйн эхнэр буюу нөхөр чинь одоо чамайг харж байвал чи биеэ хэрхэн авч явах вэ?” гэх мэтийн асуулт асууж, найзынхаа асуултад хариул. Ариун явдлын хуулийг зөрчсөн бүх хүмүүс үүнийхээ төлөө их харамссан гэж би дуулсан. “Хэрэв ирээдүйн хүүхэд чинь чамаас ариун явдлын хуулийг зөрчсөн үү? гэж асуувал чи юу гэж хариулах вэ?” Найзаас чинь хүүхэд нь энэ асуултыг асуухаас өмнө ариун явдлын хуулийг одооноос эхлэн сахих нь хэчнээн чухал болохыг найз чинь ойлгосон байх хэрэгтэй. Та энэ ариун хуулийг зөрчихгүй байснаар өөрийгөө цэвэр ариун байлгаж, эрүүл саруул, аз жаргалтай амьдарч чадна.

Робин К., 13 настай, Юта, АНУ

Сөрөг үр дагавар

Ариун явдлын хуулийг зөрчсөний сөрөг үр дагавар олон боловч тэдгээрийг бүгдийг нь эрүүл мэндийн хичээлээс мэдэх боломжгүй байдаг. Ариун явдлын хуулийг зөрчихөд Сүнс амьдралаас чинь холдон зайлж, ойр дотны хүмүүсээ гомдоохын хамт таны сэтгэл санаа ч таатай бус болно. Би танд Мормон захиас дахь “Chastity: What Are the Limits?” видео [at youth.lds.org англи, португаль, испани хэлээр] үзэхийг зөвлөж байна. *Маттью Т., 17 настай, Юта, АНУ*

Гэрлэлтийн хүрээнд

Ариун явдлын хуулийг зөрчих нь хор уршигтайг би найздаа тайлбарласан. Учир нь нөхөн үржихүйн хүч зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр, нөхөр хоёрын хооронд байдаг. Бид ариун явдлын хуулийг зөрчвөл Ариун Сүнсийг амьдралаасаа алдана. *Августина А., 15 настай, Гана*

Эшлэл

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 35.



АРИУН ЯВДЛЫН ХУУЛИЙГ ЗӨРЧИХ НЬ НОЦТОЙ ХОР УРШИГТ ХҮРГЭДЭГ

“Их Эзэн Өөрийн

тогтоосон хязгаарын дотор нөхөр, эхнэр хоёр нөхөн үржихүйн ариун хүчийг хайр ба сайн сайхан байдлаар илэрхийлэхийг зөвшөөрдөг билээ. . .

Гэвч хайрын энэхүү дотно үйлдлийг гэрлэлтээс гадуур ашиглахыг Их Эзэн хориглодог. Учир нь энэ нь Түүний зорилгод харшилдаг. Гэрлэлтийн хүрээнд хийм харилцааг Түүний төлөвлөгөөнд хүлээн зөвшөөрдөг. Үүнээс өөр байдлаар ашиглах нь Түүний хүслийн эсрэг юм. Гэрлэлтээс гадуур харилцаанд оролцогчид үйлдлийнхээ үр дагаврыг тухайн үед мэддэггүй, харин хожим нь ухаардаг. Бэлгийн харилцааны ёс суртахуунгүй явдал нь Ариун Сүнсийн нөлөөнд саад учруулдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт “Making the Right Choices,” *Ensign*, 1994 оны 11-р сар, 38.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Үр хөндөх мэтийн сайн мэдээний сургаалуудад харшилдаг сэдвээр сургууль дээр ярьвал би юу гэж хэлэх хэрэгтэй вэ?”

Хариултаа 5-р сарын 15-ны дотор дараах э-мэйл хаягаар liahona@ldschurch.org эсвэл:

Liahona, Questions & Answers 5/13

50 E. North Temple St., Rm. 2420

Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар шуудангаар ирүүлнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).



Ерөнхийлөгч
Томас С.Монсон

САНВААРЫН ДУУДЛАГАДАА ХЭРХЭН ҮЙЛЧЛЭХ ВЭ?

Та хүмүүний бодгалийн үнэ цэнийн тухай тунгаан бодож үзсэн үү? Бид бүгдэд байдаг **чадавхийн** талаар та бодож үзсэн үү?

Нэг удаа намайг гадасны чуулганд оролцож байхад манай гадасны ерөнхийлөгч байсан Пол К.Чайльд Сургаал ба Гэрээ 18-ыг гаргаж: **“Бодгалийн үнэ цэнэ** Бурханы мэлмийд агуу гэдгийг санагтун” (10-р шүлэг) хэмээн уншиж билээ.

Ерөнхийлөгч Чайльд тэгээд “Хүмүүний бодгаль хэр зэрэг их үнэ цэнэтэй вэ?” гэж асуув. Тэр асуулынхаа хариултыг бишоп, гадасны ерөнхийлөгч, дээд зөвлөхөөс авахыг хүссэнгүй харин ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийг сонгожээ.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч цочсоноо, түр зуур дуугүй болсон нь их л удах шиг санагдаж билээ. Тэгээд “Хүмүүний бодгалийн үнэ цэнэ бол **Бурхантай адилхан болох хүч чадал мөн**” гэж тэр хариулав.

Чуулганд оролцогч бүр энэ хариултыг тунгаан бодож байлаа. Ерөнхийлөгч Чайльд ах захиасаа

цааш үргэлжлүүлэхдээ энэхүү сүнсээр нөлөөлөгдсөн хариуны талаар ярьсан юм.

Тэнгэрлэг Эцэг Өөрийн захиасыг заахаар бэлтгэсэн үнэ цэнэтэй бодгалиудад **тусалж, заан, сүнслэгээр нөлөөлөх нь** маш өргөн цар хүрээтэй ажил юм. Амжилт амар хялбар ирдэггүй. Амжилтын өмнө **нулимс, хүнд сорилт бэрхшээл, итгэлийн сорилт, гэрчлэл** ирдэг.

“Би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:20) гэсэн Их Эзэний амлалт Бурханы үйлчлэгчдэд тайтгарлыг авчирдаг билээ. Энэхүү агуу амлалт дикон, багш нар, пристүүдийн чуулгын удирдах албан тушаалуудад дуудагдсан Аароны санваартан ах нар та нарыг урамшуулан дэмждэг. Энэ амлалт та нарыг номлолын талбарт үйлчлэхэд бэлтгэхэд тань урам хайрлах болно. Энэ урам хугарсан үед та нарыг тайтгаруулах болно.

“Иймийн тул, **сайныг үйлдэхэд шантрамтгай бүү бай**”, учир нь та нар агуу ажлын суурийг тавьж байна. Мөн агуу болох тэрхүү зүйл жижиг зүйлүүдээс гарч ирдэг.

Болгоогтун, Их Эзэн зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуныг шаарддаг билээ;” (С ба Г 64:33–34). Их Эзэнд бүх зүрх сэтгэлээрээ үйлчилдэг хүмүүст **гуйвшгүй бат бөх итгэл, байнгын оргилуун хүсэл эрмэлзэлтэй байдаг.**

Миний үгийг унших ах нар номлолд үйлчлэх,

золиослол хийх болон бусдын амьдралыг адислахад бэлтгэгдээгүй, бүр энэ дуудлагад хариулах боломжгүй байлаа ч гэсэн: **“Бурхан дуудсан хүнээ дуудлагад нь тэнцэхээр болгодог”** гэсэн үнэнийг санагтун. ■

1987 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганд дээр хэлсэн үгнээс.

ТА ҮҮНИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БЭ?

“Их Эзэн намайг дэмждэгийг мэдэх нь юуны учир номлолд явж байгаагаа:

Их Эзэнд үйлчилж, бусдыг бидний Аврагч Есүс Христэд авчрахаар явж байгааг санахад надад тусалдаг. Их Эзэн намайг номлолд байх үеэр дааж давшгүй ахадсан ажлыг хийхийг надаас шаардахгүйг би мэднэ.”

**Дайлан М.,
Юта, АНУ**



ИХ ЭЗЭНТЭЙ ЗӨВЛӨ

Намайг 15-тай байхад ангийн маань нэг охин надад их таалагддаг байсан учир түүнтэй болзохсон гэж хүсдэг байлаа. Тэр үнэхээр сайхан охин байсан ч би 16 хүрэхээсээ өмнө түүнтэй болзохыг асууж болох эсэхдээ эргэлзэж байв. Тэгээд би Алма 37:37-д, “Бүх үйлүүдээ Их Эзэнтэй зөвлөгтүн, мөн тэрээр чамайг сайны төлөө чиглүүлэх болно,” гэж байдгийг саналаа. Тиймээс би залбирч, шийдвэр гаргахаасаа өмнө Их Эзэний хариут хэд хоног хүлээлээ.

Нэг өдөр сүм дээр бишоп намайг дараагийн ням гарагт үг хэлнэ үү гэж урив. Ямар сэдвээр үг хэлэхийг хүссэн гээч? Наад зах нь 16 нас хүртлээ болзоонд бүү яв! Энэ бол надад Их Эзэний өгсөн хариу байлаа өөрөөр хэлбэл, 16 нас хүрэхээс өмнө болзоонд явж болохгүй гэжээ. Би хэн нэгэнтэй болзож үзээгүй байж, юу заах болж байна аа?

Би Их Эзэнтэй зөвлөсөн учраас миний амьдралын талаар Их Эзэн ямар хүсэлтэй байдгийг мэдэж, үүнийхээ ачаар уруу таталтаас ангид байж чадсан юм. Хэрэв бид Их Эзэнтэй зөвлөх юм бол Тэр бидэнд Өөрийн хүслийг хэлж өгөх бөгөөд үүгээр дамжуулан бид агуу ихээр адислагддагийг би мэднэ.

Эдуардо Оливериа,
Сеара, Бразил

МИНИЙ ДУРТАЙ СУДАР

СУРГААЛ БА ГЭРЭЭ 24:8

“Би чамтай, бүр чиний өдрүүдийн төгсгөл хүртэл хамт байх болно” хэмээн энэ сударт өгүүлдэг учраас сорилт бэрхшээл тулгарсан үед энэ нь надад урам хайрладаг билээ. Хэрэв би Түүнийг эрэлхийлбэл Тэнгэрлэг Эцэг миний амьдралын төгсгөл хүртэл надтай үргэлж хамт байх болно гэдгийг энэ судар амладаг.

Алекс Ортиз, Ниево Касас Грандес,
Мексик



ЦАГААТГАЛЫН ХҮЧ

Номлогчид надад Есүс Христ болон Түүний Цагаатгалын тухай чухалчлан зааж байлаа. Цагаатгал бол бид бүгдэд Есүс Христээс өгсөн бэлэг хэмээн тэд тайлбарлав. Энэ бол бидэнд сорилт бэрхшээл тулгарах буюу бид нүгэл үйлдсэн үед өдөр тутмын амьдралдаа ашиглаж болох бэлэг юм. Цагаатгалын хүч бидний сүнсэлэг байдлыг нэмэгдүүлж, биднийг мөнх амьдрал руу хөтөлдөг нарийн бөгөөд давчуу зам дээр ирэхэд тусалдаг юм.


Номлогчид Цагаатгалын тухай сургаалыг

хуваалцахад энэ бол үнэн гэсэн хүчтэй мэдрэмж надад төрсөн учраас би Сүмд элсэхээр шийдсэн.

Би энэхүү гайхамшигтай бэлгийг мэдэхэд нь бусдад туслахын тулд хожим нь номлолд үйлчлэхээр шийдсэн юм. Цагаатгалын тухай тэдэнд зааж, хуваалцсанаар бусад хүмүүсийн амьдрал өөрчлөгддөгийг би харсан.


Цагаатгал үнэн бодитойг би мэднэ. Бидний нөхцөл байдал ямар ч байлаа гэсэн Цагаатгалын нөлөөг амьдралдаа урьснаар бүх зүйл сайжирч, бид баяр баясгаланг мэдрэх болно.

Иорити Табуруеа, Кирибати





Ариун Библи



Мормоны Ном

МОРМОНЫ НОМ

БИДЭНД ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Зарим хүмүүс Библи байхад Мормоны Ном бидэнд юунд хэрэгтэй юм бэ? гэж асуудаг. Хүмүүс үнэхээр ингэж асуух болно гэдгийг Есүс Христ гэрчилсэн юм (2 Нифай 29:3-г үзнэ үү). Олон шалтгааны улмаас өнөө үед Мормоны Ном бидэнд чухал хэрэгтэй байдаг (жишээ нь 2 Нифай 29:7-г үзнэ үү). Энэ ном яагаад хэрэгтэй тухай ганц хоёрхон шалтгааныг энд авч үзье.

Есүс Христийн бас нэгэн гэрч

Христийн Сүмд үнэнийг гэрчлэхийн тулд олон гэрч ашигладаг загварыг судрууд бидэнд харуулж байна. Мормоны Ном нь Христийн хоёр дахь гэрч болж нэмэгдсэн юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Марк Э.Петерсон (1900–84) ийн хэлжээ: “Бид Мормоны Номтой байдгийн үндсэн шалтгаан нь бүх



ХОЁР ГЭРЧ

“Библи бол Есүс Христийн тухай нэг дэх гэрч; харин Мормоны Ном бол хоёр дахь гэрч. Яагаад хоёр дахь гэрч онцгой чухал байдаг вэ? Энэ асуултад хариулахад дараах жишээ тусалж болох юм: Цаасан дээрх нэг цэгийг дайруулан хэчнээн шугам татаж болох вэ? Хязгааргүй олныг. Цаасан дээрх цэгийг Библи гэж бодвол түүнийг дайруулан татаж болох хэдэн зуун шугам нь Библийн тухай янз бүрийн тайлбар бөгөөд тайлбар бүр нь өөр өөр сүмийг төлөөлж байгаатай адил юм.


Гэтэл Мормоны Номыг төлөөлсөн хоёр дахь цэг цаасан дээр гарч ирвэл юу болох вэ? Библи, Мормоны Ном хоёрын хооронд хэчнээн шугам татаж болох вэ? Ердөө ганцхан. Христийн сургаалуудын тухай ердөө ганцхан тайлбар л энэ хоёр гэрчийн тухай гэрчлэл болж чадна.

Мормоны Ном Библид заадаг сургаалуудыг дахин дахин нотолж, тодруулан гэрчилдэг.

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Ахлагч Тад Р.Каллистер “Мормоны Ном—Бурханаас ирсэн ном” *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 75.



ХАМТРАН ЯРИЛЦАЦГААЯ



Та нар санваартны чуулгууд болон Залуу Эмэгтэйчүүдийн ням гарагийн хичээлээр дөрөвдүгээр сарын туршид Урвалт ба Сэргээлтийн тухай судлах болно (хэрэв танай тойрог буюу салбар эдгээр шинэ хичээлүүдийг төрөлх хэлээр тань заадаг бол). Мормоны Ном гарсан нь Сэргээлтийн чухал хэсэг болсон юм. Энэ өгүүллийг уншсаны дараа Мормоны Номтой байгаагийн ачаар амьдрал тань хэрхэн өөр болсон тухай эргэцүүлэн бодоорой. Та сэтгэгдлээ тэмдэглэлдээ бичих буюу гэртээ, сүм дээр эсвэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гэрчилж, бусадтай хуваалцаж болно.

зүйл хоёр буюу гурван гэрчийн амаар нотлогдох ёстой гэсэн зарчим юм (2 Коринт 13:1 -ийг үзнэ үү). Бидэнд Библи бас Мормоны Ном байдаг. Судрын энэ хоёр ном бие биеэсээ алс холын зайгаар тусгаарлагдсан, хоёр өөр газар амьдарч байсан эртний хүмүүсийн бичсэн судрууд бөгөөд хоёул Их Эзэн Есүс Христийн бурханлаг мөн чанарыг гэрчилдэг билээ.”¹ Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994): “Их Эзэн Мормоны Номыг Өөрийнхөө тухай үндсэн гэрч болгон Өөрөө авчирсныг бид мартаx ёсгүй” гэжээ.²

Сайн мэдээний бүрэн байдал

Цаг хугацаа улиран одохын хэрээр Библиэс “тодорхой болоод эрхэм үнэт зүйлсийг . . . авагдан зайлуулагдсан”-ыг (1 Нифай 13:40) бид мэднэ. Мормоны Ном Христийн сургаалыг тодруулж, бүрэн сайн мэдээг дэлхийд дахин авчирсан юм (1 Нифай 13:38–41). Жишээ нь Мормоны Ном баптисм усанд бүрэн дүрж хийгдэх ёстойг болон (3 Нифай 11:26-г үзнэ үү) бага насны хүүхдүүдэд баптисм хүртээх шаардлагагүйг мэдэхэд бидэнд тусалдаг (Моронай 8:4–26-г үзнэ үү).

Сэргээгдсэн Сүмийн тулгуур чулуу

Иосеф Смит Мормоны Номыг “манай шашны тулгуур чулуу”³ хэмээн гэрчилсэн юм. Мормоны Ном анх 1830 оны гуравдугаар сарын 26-нд худалдаанд гарснаас хойш ердөө 11 хоногийн дараа 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн

Сүм зохион байгуулагдсан нь санамсаргүй тохиолдол биш юм. Гишүүдэд зориулсан гол тулгуур судар бэлэн болоогүй үед Сүмийг зохион байгуулаагүй юм.

Бидний амьдрал дахь нэгэн адислал

Иосеф Смит Мормоны Номын талаар: “бусад ямар ч номноос илүүтээр энэ номын зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болно” гэж заажээ.⁴ Таны амьдралыг бас эргэн тойрны тань хүмүүсийн амьдралыг өөрчлөх хүч энэ номонд бий. Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айрингийн гэрчилжээ: “Мормоны Ном танд Бурханыг гэрчлэгч байх зан чанар, хүч, зоригийг өгөх болно. Энэ номон дахь сургаал ба итгэл үнэмшилтэй жишээнүүд нь танд сүнслэгээр нөлөөлж, таныг удирдан, урам зориг хайрлах болно. . . . Мормоны Номыг залбирч судлах нь Бурхан Эцэг, Түүний Хайртай Хүү болон Түүний сайн мэдээнд итгэх итгэлийг төлөвшүүлэх болно. Энэ ном Бурханы эрт, эдүгээгийн бошиглогчдод итгэх итгэлийг тань төлөвшүүлэх болно. . . . Энэ ном өөр ямар ч номоос илүүтээр таныг Бурханд ойртуулж, амьдралыг тань улам сайхан болгоно.”⁵ ■

Эшлэл


1. Марк Э.Петерсен, “Evidence of Things Not Seen,” *Ensign*, 1978 оны 5-р сар, 63.
2. *The Teachings of Ezra Taft Benson* (1988), 200.
3. Иосеф Смит, Мормоны Номын Удиртгал.
4. Иосеф Смит, Мормоны Номын Удиртгал.
5. Хенри Б.Айринг, “Гэрч,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 69–70.



Синди Смит

УГАНДАД

СҮМ ЭРЧ ХҮЦЭЭ АВАН
ХӨГЖИЖ БАЙНА:
ЭНЭ ОРНЫ ИТГЭЛТЭЙ
ӨСВӨР ҮЕИЙНХЭН



Угандагийн өсвөр үеийнхэн Есүс Христийн сайн мэдээг хүлээн авч, үүний дагуу амьдарснаар итгэл найдвар нь өсөн хөгжиж байгаа нь хаа сайгүй харагдаж байна.

Зүүн Африкийн төв хэсэгт оршдог үзэсгэлэнт орон Уганда чихрийн нишингэ, гади́л жимсний мододтой үргэлжилсэн толгодоор бас Есүс Христийн сайн мэдээг хүлээн авч, үүгээр амьдрахад бэлэн байгаа өсвөр үеийнхнээр адислагдсан ажээ.

Угандад 2010 онд анхны гадас зохион байгуулагджээ. Сүм хурдан өсөн хөгжиж байгаа бөгөөд тойрог, салбар болгонд олон залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд байна.

Жишиг тогтоож, үлгэр дууриал үзүүлж байгаа нь

Нэг тойргийн залуу эмэгтэйчүүд ариун журмын талаар Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Элайн С.Далтоны “Бид бүгд ариун журмыг сэргээхийг дэлхий дахинд уриалан дуудах цаг болжээ” гэсэн захиасыг сонсоод сүнслэгээр нөлөөлөгдсөн ажээ.¹ Залуу эмэгтэйчүүд хотын хаяан дахь өндөр толгод дээр гарч, ариун журмыг үлгэрлэгчид байх амлалтын бэлгэдэл болгон алтан тугийг босгож, “Уулын оргил дээр” дууллыг дуулжээ (*Сүмийн дуулал ба хүүхдийн дуу*, х.30).

Эдгээр залуу эмэгтэйчүүд зөв шударга байдлын өөрсдийн жишгийг өндөрсгөсөн ажээ. Тэдний дуулгавартай байдал гэрчлэлийг нь бэхжүүлж, бусдад нөлөөлжээ. “Зөв шударга байдлын нөлөөнийхөө хүчийг хэзээ ч бүү дутуу үнэл” хэмээн Далтон эгч хэлсэн юм.² Эдгээр залуу эмэгтэйчүүдийн үлгэр дууриал тут намирах лугаа бүх хүмүүст ил тод харагдаж байна.

Сандра Угандагийн олон залуу эмэгтэйчүүдийн адил сүмд очихын тулд бараг хоёр км явган явж, тав дахь өдөр бүр цуглааны байрыг цэвэрлэн, хагас сайн өдөр семинарт явж байна. Тэр долоо хоногийн өдөр бүр өглөө таван цагаас өмнө босч, сурах бичгүүдээ уншиж, сургуульдаа яваад оройн 6 цагаас хойш гэртээ ирдэг ажээ. Тэр санхүүгийн бэрхшээлийн улмаас нэг жил сургууль завсардсан ч, тэрээр уг сорилтоо “Сайн мэдээ надад гуйвшгүй тууштай байхад тусалсан” хэмээн өөдрөгөөр хүлээн авсан гэдгээ ярилаа.

Сандра хэдийгээр гэрээсээ ганцаараа Сүмийн гишүүн боловч эцэг эх нь өнчин хүүхдийн асрах байрны газрыг цэвэрлэхэд туслах зэрэг Сүмд

Сандра



Хамгийн дээд талд:
Өсвөр үеийнхэн гадасны
галын дэргэдэх ярилцлагад
оролцож байгаа нь.

Дээд талд: Угандад
дүрвэж ирсэн Сюзан (дунд
нь) сайн мэдээнээс амар
амгаланг олж, одоо дүү
нараа болон өөр хүүхдүү-
дийг сүмд дагуулан ирж
байна.

Дараагийн хуудсанд:
Энэ тойргийн залуу эмэг-
тэйчүүд Хувийн хөгжил
дэвшил хөтөлбөр дээрээ
ажиллах дуртай.

Баруун талд: Деннис
сайн мэдээг номлохын
тулд мэргэжлийн хөл бөм-
бөгийг орхисон ажээ. Тэр
пристүүдийн чуулгынхаа
бусад залуу эрэгтэйчүү-
дийн хамт номлолд
үйлчлэхийн тулд зо-
лиослол хийж, олон
сорилт бэрхшээлийг
даван туулжээ.

хийдэг түүний үйлчлэлийг дэмждэг
ажээ. Шийдвэрлэгдээгүй асуудал
тулгарсан үед сайн мэдээ түүнд
итгэлээ улам бат бөх болгоход
нь тусалсныг гэрийнхэн нь харжээ.
Хүч чадлын энэхүү эх сурвалжийн
талаар тунгаан бодсон Сандра “Би
сүмд очсон үедээ Бурханы хуяг
дуулгыг өмссөн юм шиг санагддаг”
гэж хэлэв (Ефес 6:11–17-г үзнэ үү).

Шинэхэн хөрвөгч Сюзанд Сүм
их таалагддаг. Өмнөд Суданаас
гаралтай түүний гэр бүл зовлон
бэрхшээлээс зугтаж Угандад ирээд

номлогчидтой уулзжээ. Тэр сайн
мэдээнээс амар амгалан хийгээд
хамгаалалтыг олсон ажээ. Тэр ням
гарагт өөрийнхөө дүү нарыг бас
Сүмийн гишүүн биш 10 хүртэл өөр
хүүхдийг сүм дээр дагуулж ирдэг
гэнэ. Гэр бүлийнх нь нэг гишүүн
зуурдаар нас барсан учир тэр Өм-
нөд Суданд эргэж ирээд, Сүм нутагт
нь байгуулагдахыг хүлээж байгаа.
Сюзан, Сандра хоёрт аль алинд нь
сорилт бэрхшээл тулгарсан ч тэр
хоёр Бурханд итгэн, Есүс Христийн
сайн мэдээгээр амьдрахын үр жим-
сийг хүртсэн ажээ (Алма 32:6–8,
43-ыг үзнэ үү).

Номлолд үйлчлэхээр золиослол хийсэн нь

Угандад залуу эрэгтэйчүүд бүр
багаасаа эхлэн бусад салбарын-
хантай хамт хөл бөмбөг тоглодог
байна. Деннис бүр багаасаа спор-
тын авьяастай байсан бөгөөд ахлах
сургууль багтаа тоглуулахын тулд
түүнд тэтгэлэг олгодог байжээ. Ах-
лах сургуулиа төгссөнийх нь дараа
мэргэжлийн хөл бөмбөгийн нэг
баг багийнхаа бүрэлдэхүүнд
тоглуулахын тулд түүнд
цалин, орон сууц
санал болгосон гэнэ.
Ийнхүү мөрөөдөл
нь биелэгдэх үүд





хаалга нээгдсэн ч, энэ нь тэр жилийн сүүлчээр номлолд явах төлөвлөгөөнд нь саад болох байв.

Тэнгэрлэг Эцэг нь түүгээр хийлгэхийг хүсдэг зүйлийг хийх хүсэл үнэхээр хүчтэй байсан учир номлолд үйлчлэх цаг нь ирсэн үед тэрээр хөл бөмбөгийн багт үлдэхээр



уруу татагдаагүй ажээ. Олон хүмүүс түүний сонголтод гайхсан ч Деннис өөрийнхөө болон бусдын төлөө зөв шийдвэр гаргасандаа эргэлзэхгүй байлаа. “Миний хоёр эрэгтэй дүү, нэг эмэгтэй дүү дөнгөж саяхан баптисм хүртлээ. Эмэгтэй дүү минь сайн мэдээг хэзээ ч сонсохгүй байх гэж би боддог байсан. Бурхан манай гэр бүлд гайхамшигийг үйлдэхийг харсан нь ирээдүйдээ итгэх агуу итгэлийг надад төрүүлсэн” гэж тэр ярилаа.

Деннисийн тойрогт залуу эрэгтэйчүүд *Миний сайн мэдээг номло* удирдамжийг долоо хоног бүр судалдаг. Тэд яг нэг багийнхан шиг болж, бүрэн цагийн номлогчидтой нягт хамтран ажилладаг бөгөөд ням гарагийн цуглаанууд, бусад үйл ажиллагаануудад, түүний дотор тухайн долоо хоногт болох сагсан бөмбөгийн болон хөл бөмбөгийн тоглолтуудад найз нараа дагуулан

ирдэг ажээ. Санваартнууд найз нартаа болон бусад хүмүүст баптисм хүртээж, хичээл заахад нь номлогчидод тусалж байна. Залуу эрэгтэйчүүдийн энэ баг нэлээд хэдэн жил нийт тойргоо бэхжүүлснээс гадна тэдний дөрөв нь номлолд үйлчлэх дуудлага, түүний дотор Деннис Кенийн Найроби Номлолд үйлчлэх дуудлага хүлээн авчээ.

“Номлолын өргөдлөө явуулахаас бүр өмнө номлогчид” болох тухай Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднарын зөвлөгөөг тэд дагасан ажээ.”³ Тэд үүнийг чуулгаараа эсвээс багаараа хийсэн нь амжилт олоход түлхэц үзүүлжээ.

Дөрвөн номлогч дөрвүүл үйлчлэхийн тулд сорилт бэрхшээлийг даван туулсан байна. “Би өртөг зардлын улмаас номлолд явах бараг найдваргүй болоод байсан үедээ Матай 6:19–20-иос ‘Тазар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа . . . харин тэнгэрт эд баялгийг өөрсдөдөө хураа’ гэсэн үгсийг уншсан. Шантралгүй, тууштай байсны хүчинд би бүрэн цагийн номлолд үйлчлэх зорилгоо биелүүлж чадсан юм. Би номлолын үйлчлэлд дуртай. Бүхнээс түрүүнд тэнгэрийн хаант улсыг эрэлхийлэхээс илүү эрхэм зүйл гэж байхгүй” хэмээн Вилберфорс ярилаа.

Ирээдүйн найдвар

Бурханы хаант улсыг байгуулахад тусалж байгаа Угандагийн өсвөр үеийнхэн ирээдүйдээ маш их итгэлтэй байна. Зүүн Африкт Ариун сүм байхгүй ч, өсвөр үеийнхэн алс холын аль нэг Ариун сүмд гэрлэх цаг ирнэ хэмээн хүлээж байна. Гадасны нэг үйл ажиллагаа Ариун сүмд орох бэлтгэл дээр анхаарал төвлөрүүлсэн бөгөөд эцэст нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн гэрчлэлээ хуваалцаж: “Бурхан та нарт

хайртай. Та нар бол Уганда дахь Сүмийн ирээдүй” хэмээн хэллээ. Эдгээр зөв шударга өсвөр үеийнхэн бусдадаа аль хэдийнээс сайн нөлөө үзүүлсээр байгаа билээ.

Угандагийн залуу эрэгтэй, эмэгтэйчүүд үүрд мөнхийн адислалуудын төлөө дэлхийн зүйлүүдийг золиосолсоор байна. Тэд итгэлийн үрийг тарьж, арчлан тордож байна (Алма 32:33–37-г үзнэ үү). Мод жимсээр дүүрдэг шиг (Алма 32:42-ыг үзнэ үү), Угандагийн өсвөр үеийнхэн үржил шимтэй эх нутагтаа сайн мэдээний баяр баясгаланг хуваалцаж байна. ■

Синди Смит нөхөртэйгөө Угандад ажиллаж амьдарч байжээ. Харин одоо АНУ-ын Ютад амьдарч байна.

ЭШЛЭЛ

1. Элайн С.Далтон, “Ариун журамдаа эргэн ирцгээ,” *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 90.
2. Элайн С.Далтон, *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 90.
3. Давид А.Беднар, “Becoming a Missionary,” *Лиакхона*, 2005 оны 11-р сар, 45.





ЖИНХЭНЭ АНД НАЙЗ

ГЭЖ ХЭН БЭ?

Элайн С.Далтон

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

Бид бүгд мэдээлэл холбооны технологиор дамжуулан харилцдаг болсон өнөө үед найзын тодорхойлолт өөрчлөгдөөд байна. Өнөөдөр бид өөрсдийгөө олон “найзтай” гэж бодож болно. Бид үргэлж мэдээлэлтэй байх боломжтой бөгөөд олон танилынхаа түүний дотор одоогийн болон хуучин найз нарынхаа амьдралд юу болж байгааг мэдэх боломжтой байдаг. Түүгээр ч барахгүй биечлэн уулзаж учраагүй хүмүүсийг ч бид найз нараа гэж нэрлэдэг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд “найз” гэдэг үгийг ихэвчлэн *харилцаатай* байдаг хүмүүс гэхээс илүүгээр *электрон захиасаар*


холбогддог хүмүүсийг хэлэхэд ашигладаг. Та “найз нартаа” захиас явуулах боломжтой ч гэсэн энэ нь хүнтэй нүүр тулан харилцахтай адилгүй юм.

Бид ихэвчлэн найзтай *байхыг* л боддог, гэвч найзтай болохын зэрэгцээгээр өөрөө сайн найз *байхад* бид анхаарах ёстой.

Найз байх гэдэг нь юу гэсэн утгатай талаар олон тодорхойлолт байдаг. Найз байх гэдэг нь чухам юу гэсэн үг болох хийгээд бидний амьдрал дахь найз нарын нөлөөний тухай Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлсийн хэлсэн үгийг би хэзээ ч мартахгүй. Найзын тухай түүний

тодорхойлолт миний амьдралд урт удаан хугацаанд нөлөөлсөөр байгаа билээ. Тэрбээр ингэж хэлсэн юм: “Найз нар бол Есүс Христийн сайн мэдээгээр амьдрахыг илүү амар хялбар болгодог хүмүүс юм.”¹ Энэ утгаар, өөр хэн нэгэнд байдаг эрхэм чанаруудыг эрэлхийлж, түүнээс суралцах нь жинхэнэ нөхөрлөлийн мөн чанар юм. Энэ бол өөр хүнийг өөрөөсөө дээгүүрт тавина гэсэн үг. Энэ бол бүхий л үйлдлээрээ дээд зэргийн шударга үнэнч, ариун журамтай байна гэсэн үг. Жинхэнэ нөхөрлөлийн утга учрыг нээн харуулж чадах үг бол *чин шударга зан чанар* гэдэг үг юм.

Манай охин Эми 15-тай байхдаа ямархуу найз нартай байвал зохихоо шийдсэн юм. Нэг өглөө би түүний Мормоны Ном Алма 48 дээр нээлттэй байхыг харав. Тэр Ахмад Моронайг дүрсэлсэн дараах шүлгүүдийг будаж тэмдэглэсэн байлаа: “Моронай хүч чадалтай эр байв; тэр төгс ойлголттой хүн байв. . . . Тийм ээ, мөн тэрээр Христийн итгэлээрээ гуйвшгүй хүн байв” (11, 13-р шүлэг). Тэрээр уг шүлгийн хажууд “Би Моронай шиг эр хүнтэй болж, гэрлэхийг хүсдэг” гэж бичсэн байлаа. 16 нас хүрсэн үед нь би Эмиг болон харилцаатай байдаг залуу эрэгтэйчүүдийг нь ажиглахад тэр өөрөө дээрх зан чанаруудаар үлгэр дууриал үзүүлснээрээ тэдгээр залуу эрэгтэйчүүдэд Бурханы хөвгүүд, санваартнууд,



ирээдүйн эцэг ба удирдагчдын хувьд нэр төрөө эрхэмлэн амьдрахад нь тэдэнд тусалдаг байсныг харсан.

Жинхэнэ найз нар харилцаатай байдаг хүмүүстээ “илүү өндөр жишгүүдээр амьдарч, илүү сайн болоход нь” нөлөөлдөг². Та нар ялангуяа залуу эрэгтэйчүүд номлолд бэлтгэж, хүндэтгэлтэйгээр үйлчлэхэд бие биедээ тусалж болно. Та нар ёс суртахууны хувьд ариун байхад бие биедээ тусалж болно. Та нарын зөв нөлөө болон нөхөрлөл харилцаатай байдаг хүмүүсийн тань амьдралд төдийгүй, тэдний хойч үеийнхний амьдралд мөнхийн нөлөө үзүүлэх болно.

Аврагч шавь нараа Өөрийн найзууд гэдэг байв. Тэрбээр ийн хэлжээ:

“Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол миний тушаал.

Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй.

Хэрэв та нар Миний тушаасныг хийвэл, та нар Миний нөхөд мөн.

Би та нарыг боолууд хэмээн дахиж дуудахгүй. Учир нь эзнийхээ юу хийж байгааг боолууд мэддэггүй юм. Харин би та нарыг *анд нөхөд* хэмээн дуудав. Учир нь Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ” (Иохан 15:12–15; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Та Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч, үүнийг хуваалцсанаар бусад хүмүүсийн анхаарлыг өөртөө татаж, тэд өөртэй тань зөвхөн вэб сайтаар харилцдаг найз байхыг хүсэхгүй харин Аврагч Өөрийн үг хэл, үлгэр жишээгээр харуулсан шиг тийм эелдэг найз тань байхыг хүсэх болно. Та бусдын найз байхыг хичээж, гэрлээ тэдний өмнө

гэрэлтүүлбэл, таны нөлөө харилцаатай байдаг олон хүний амьдралыг адислах болно. Хэрэв та бошиглогчдын тодорхойлсноор эсвэл судруудын жишээгээр бусдад найз нөхөр нь байхыг хичээвэл та аз жаргалтай байж, дэлхийд сайн нөлөө үзүүлэн: “Энд бидний дунд байгаа тэрхүү харилцаа тэнд бидний дунд байх болно, гагцхүү энэ нь мөнхийн алдар суугаар хоёр дахин ихсэх болно” (С ба Г 130:2) хэмээн нөхөрлөлийн тухай сударт дурдсан агуу амлалтын биелэлтийг нэгэн цагт хүлээж авах болно. ■

ЭШЛЭЛ

1. Роберт Д.Хейлс, “This Is the Way; and There Is None Other Way,” *Бригам Янг Их сургууль дээр хэлсэн үгс 1981–82* (1982), 67.
2. Гордон Б.Хинкли, “The Quest for Excellence,” *Лиахона*, 1999 оны 9-р сар, 8.

НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ГОЛ САНААНУУД

“Өөрийн чинь эрхэмлэдэг үнэт зүйлсийг хуваалцдаг найз нөхдийг сонго. Ингэснээр та нар өндөр жишгүүдээр амьдрахад бие биенээ хүчирхэгжүүлэн, бие биедээ урам дэм хайрлах болно.

Сайн найз нөхөдтэй байхын тулд өөрөө сайн найз бай. . . .

Бусадтай найз нөхөд болохдоо өөрийн жишгүүдийг умартаж болохгүй.”

Залуучуудын бат бөх байдлын төлөө (товхимол, 2011), 16.

АВРАЛД урих МИНИЙ УРИЛГА

Эмерсон Хосе да Сильва

Би залуу байхдаа олон өөр сүмд явж үзээд тэд судруудыг өөр өөрөөр тайлбарлахыг хараад учраа олохгүй болсон билээ. Тэдний зарим нь сүсэг бишрэлдээ хүндэтгэлгүй ханддагийг мэдрээд би байнга явах сүмээ олох бодлоо орхисон юм.

Хэдэн жилийн дараа миний найз Клейтон Лима Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртсэн юм. Хэдийгээр бид хоёр сайн найзууд байсан ч тэр үүнийгээ надад хэлээгүй. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам найз маань өөрчлөгдөж байгааг би ажигласан. Би ням гарагийн өглөө хөл бөмбөг тоглох гэж тэднийхээр хоёр гурван удаа очсон ч тэр гэртээ байсангүй. Сүүлдээ Клейтон Их Эзэний өдөрт хүндэтгэлтэй хандах ёстой учраас



ням гарагт хөл бөмбөг тоглохгүй гэдгээ надад хэлсэн. Тэгэхэд нь би “энэ сүм чамайг солиотой болгох юм байна даа” гэж билээ.

Дараа нь Клейтон намайг сүмдээ урилаа. Би ерөөсөө аль ч шашинд сүсэг муутайхан ханддаг учраас нэг шалтаг олж хэлдэг байлаа. Клейтон надад заах номлогчдыг бүтэн 10 сарын турш дагуулж ирдэг байсан ч би үргэлж нэг шалтаг олох буюу завгүй байна гэж тэдэнд хэлдэг байв. Гэвч найз маань бууж өгсөнгүй.

Зургадугаар сарын нэг өдөр тэр намайг Сүм дээр болох бүжгийн үдэшлэгт урилаа. Тэгэхэд нь би “Тэнд чинь үнэгүй зууш, олон охид байх уу?” гэж тоглон асуухад, Клейтон инээд алдаад байлгүй яахав! гэлээ.

Бүжиг гэхээс илүүтээр үнэгүй хоол миний арааны шүлсийг асгаруулсан юм. Тэгээд очиж үзтэл

сүм надад таалагдлаа. Хүн бүхэн надтай эелдэгхнээр мэндэлж байв.

Хоолноос нь сайн

идээд, цуглаанд нь орж сонирхлоо. Ням гарагт би сүм дээр ирж, олон хүмүүстэй танилцаж, тэдний гэрчлэлийг сонслоо. Би Мормоны Номын тухай сонсоогүй байсан ч, “Мормоны Ном үнэн гэдгийг, энэ сүм бол Есүс Христийн Сүм гэдгийг, Иосеф Смит бол Бурханаар дуудагдсан бошиглогч гэдгийг би мэднэ” хэмээн Сүмийн олон гишүүн гэрчлэхийг сонсоод Сүнсний мэдрэв. Надад урьд нь хэзээ ч тийм сайхан мэдрэмж төрж байгаагүй. Би номлогчидтой уулзах хүсэлгүй хэвээр байсан ч, гэрчлэлийн цуглаан надад хүчтэй нөлөөлсөн юм.

Дараагийн долоо хоногт Клейтон дахиад намайг сүмдээ очихыг урив. Би өөр ажилтай байсан учраас очиж чадсангүй. Би очих эсэхээ мэдэхгүй байна гэж намайг хэлэхэд түүний нүүрэнд гуниг тодров.

Гэвч би ням гарагийн өглөө сэрээд сүмд явахыг хүсч байгаагаа мэдэрлээ. Өглөө эрт босох нь хэцүү байсан ч би 6:50-д босч Клейтоныг ирэхийг хүлээлээ. Тэр намайг хувцаслагчид хүлээж байхыг хараад гайхав. Тэр ням гарагт бишоп санваарын тухай заалаа. Би Сүнсний хүчтэй мэдэрч, номлогчийн хичээл авах ёстой гэж шийдлээ. Залуу Эрэгтэйчүүдийн хичээл дуусахад би баптисм хүртэх

болно гэдгээ мэдсэн.

Сүмийн цуглаан дуусахад би Клейтонд “Би баптисм хүртэхийг хүсч байна!” гэлээ.

Тэр эхлээд намайг тоглож байна гэж бодсон ч дараа нь “Номлогчдыг уривал, чи тэдэнтэй уулзах уу?” гэж асуухад нь би тэгье гэв.

Надад маш сайн ахлагч нар заасан. Сэргээлтийн тухай захиасыг сонссоны дараа би баптисм хүртэх ёстой гэсэн мэдрэмж улам хүчтэй төрөв. Гэвч Мормоны Ном үнэн эсэхийг өөрөө мэдэхийг хүслээ. Ахлагч нар миний Мормоны Номон дээр Моронай 10:3–5-ыг тэмдэглэж, энэ ном үнэн эсэхийг Бурханд хандан залбирч, асуухад намайг урив.

Маргааш орой нь би Мормоны Номоо уншаагүйгээ саналаа. Тэгээд уншиж эхэлтэл, сүнсний хүчтэй мэдрэв. Уншиж дуусахаасаа өмнө залбираад би Мормоны Ном үнэн гэдгийг мэдлээ. Залбиралд минь хариулсанд би Бурханд талархалтай байлаа. Ингээд 2006 оны долдугаар сард би баптисм хүртэв.

Хожим нь би Бразилын Квайбо номлолд харин манай найз Клейтон Бразилын Санта Мария Номлолд үйлчилсэн. Бид хамтдаа Клейтоний надад хийж өгсөн зүйлийг бусад хүмүүсийн төлөө хийсэн. Бид хүмүүсийг Христэд ирэхийг урьж тэдэнд сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад нь тусалсан. Энэ бол үнэхээр авралд хүрэх зам мөн.

Найз нөхөд, төрөл төрөгсдөө энэхүү сайн мэдээний тухай мэдэхэд урьцгаая. Учир нь Аврагч хүн бүрд хандан “Над уруу ир” (Матай 11:28) гэж хэлсэн билээ. Энэ бол Есүс Христийн сүм бөгөөд өнөө үе бол хүн бүрийг Түүнд ирэхийг урих цаг мөн. ■



ХӨРВӨСНӨӨ

МЭДЭХ АРВАН АРГА ЗАМ

Тайлер Ортон

Би санваартны нэг цуглаан дээр Аароны санваарын нэг зорилго бол “Есүс Христийн сайн мэдээнд хөрвөхөд болон үүний сургаалуудаар амьдрахад” бидэнд туслах явдал гэдгийг мэдлээ.¹ Харин “Есүс Христийн сайн мэдээнд хөрвөх” гэдэг нь юу гэсэн утгатайг би ойлгохгүй байлаа. Би үүнийг аав, ээж ах эгч нараасаа асууж, сайн мэдээнд хөрвөсөн эсэхээ мэдэх нэлээд олон арга зам байдаг тухай бүгдээрээ ярилцаж билээ.

Өөр арга зам байж болох юм. Гэвч бид 10 замыг бодож олсон билээ. Хөрвөлт нь насан туршийн үйл явц учраас бид эдгээр арга замуудын алинаар нь ч төгс хөрвөлтөд хүрэх боломжгүй. Харин эдгээр арга замууд бидэнд өсөлт дэвшилт гаргахад тусалж чадна.

1. Хэрэв та хөрвөсөн бол зөв зүйлсийг хийх ёстой гэдгийг зөвхөн мэддэг болсон байх төдийгүй харин хүсдэг болсон байна. Зөвхөн баригдаж, шийтгүүлэхээс айдаг учраас буруу зүйл хийхээс зайлсхийх нь хангалтгүй юм. Жинхэнэ ёсоор хөрвөсөн үед та зөв зүйлийг сонгохыг үнэхээр хүсдэг болсон байна.

2. Хүн жинхэнэ ёсоор хөрвөсний өөр нэг шинж тэмдэг бол буруу юм хийх хүсэлгүй болсон байдаг. Антай-Нифай-Лихайчууд бол үүний агуу үлгэр жишээ мөн. Тэд Есүс Христийн сайн мэдээнд хөрвөсөн үедээ “түүнд үйлчилж, түүний зарлигуудыг сахихаар Бурхантай гэрээнд орсон болой” (Мозая 21:31). Тэд хаан Бенжаминаар заалгасан нифайчуудын адил “хилэнцийг үйлдэх хүсэлгүй” (Мозая 5:2) болсон байлаа. Тэд Есүс

Христийн сайн мэдээнд жинхэнэ ёсоор хөрвөсөн бөгөөд Сатаны уруу таталт тэдний дээр хүчгүй болсон байв.

3. Хэрэв та хөрвөсөн бол бусад хүмүүс таны тухай юу гэж бодох бол гэдгээс илүүгээр Бурхан таны тухай юу гэж бодох бол гэдэгт санаа тань зовдог болно. Индонези дахь миний сурдаг сургуульд оюутнууд согтууруулах ундаа их уудаг. Зарим үед үдэшлэгт очихоор уруу таталттай тулгардаг. Бусад хүмүүсийн хийж байгааг хийхгүй бол чамайг шоолж мэднэ. Манай ахыг согтууруулах ундаа уудаг үдэшлэгт олон удаа урьсан ч тэр итгэдэг зүйлийнхээ төлөө хатуу зогссон. Энэ нь түүнд хэцүү байдаг байсан. Тэр олон

үдшийг гэртээ ганцаараа өнгөрүүлдэг байлаа. Түүнийг сургуулиа төгсөхөд оюутнууд салах ёс гүйцэтгэх үед нэлээд хэдэн хүн манай ахыг үе тэнгийнхнийхээ даралт шахалтанд автагддаггүй, жишгүүддээ чин үнэнч байдагт нь гайхан биширдэг байснаа, үүний улмаас тэд түүнийг ихэд хүндэлдэг байснаа ярьсан ажээ. Ахмаань үе тэнгийнхнийхээ дарамт шахалтыг даван туулсанаар сайн мэдээнд хөрвөснөө харуулсан юм.

4. Хэрэв та хөрвөсөн бол зөвхөн ням гарагуудад эсвэл тохиромжтой үед төдийгүй харин сайн мэдээгээр үргэлж амьдрахын тулд чадах бүхнээ хийдэг байх ёстой. Таны үйлдэл хэнтэй хамт байгаа эсвэл хэн таныг харж байж болохоос хамааран

өөрчлөгддөггүй байх ёстой. Үе тэнгийхэн тань зохисгүй онигоо ярих буюу зохисгүй кино үзэхийг хүсвэл та хүн хараагүй юм чинь яахав гээд тэдэнтэй нийлж болохгүй эсвэл тэдэнтэй хамт үзэх ёсгүй кинонд явж болохгүй, харин итгэдэг зүйлийнхээ төлөө хатуу зогсох хэрэгтэй.

5. Хэрэв та хөрвөсөн бол бусадтай энэрэнгүй, эелдэг харьцдаг болсон байна. Та бусдыг шүүдэггүй, шүүмжилдэггүй эсвэл хов жив ярьдаггүй болсон байна. Та бусдын санаа бодлыг сайн ойлгодог, тэдэнд үйлчлэх болон туслах арга замыг аяндаа хайдаг болсон байх ёстой. Таныг сургуулийн танхим руу явж байтал хэн нэг нь номоо унагачихвал та яах вэ? гэж



5.




АЗ ЖАРГАЛД ХҮРЭХ НАЙДВАРТАЙ ЗАМ

“Их Эзэн Өөрийн Сүмийн гишүүдийг Түүний сайн мэдээнд бүрэн хөрвөсөн байхыг хүсдэг. Энэ бол сүнсний аюулгүй

байдлыг энэ үед болон үүрд мөнхөд олох цорын ганц найдвартай арга зам мөн.”

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Ахлагч Дональд Л. Холлстром “Түүний Сүмээр дамжин Түүний сайн мэдээнд хөрвөгдсөн нь” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 15



6.



2.

Леменчүүд сайн мэдээгээр амьдрах гэрээндээ үнэнч байгаагаа харуулахын тулд зэр зэвсгээ булшилсан юм (Алма 24-ийг үзнэ үү).

7.



бодох ёсгүй харин түүнд шууд туслах ёстой.

6. Хэрэв та хөрвөсөн бол зал-бирах хүсэл тань нэмэгдэх бөгөөд залбирч байгаа үедээ үнэхээр Бурхантай харилцаж байгаага мэдэрэх болно. Санаа сэтгэл чинь ямар байгаагаас эсвэл амьдралд чинь юу болж байгаагаас үл хамааран залбирахад үргэлж цаг гаргадаг болсон байна. Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994), “Хэрэв бидэнд залбирмааргүй санагддаг бол залбирмаар санагддаг болтлоо залбирах хэрэгтэй” хэмээн бидэнд хандан захисан юм.²

7. Хэрэв та хөрвөсөн бол ням гарагийг тэсч ядан хүлээдэг болно. Учир нь ням гараг бол Хүндэтгэлийн өдөр. Ням гараг болоход та “Өө, хөөрхий, өнөөдөр чинь



найз нартайгаа уулзаж, кинонд явж болдоггүй өдөр шүү дээ” гэж бодохын оронд, “Өнөөдөр чинь сүнслэг зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлж, гэр бүлтэйгээ хамт байдаг өдөр. Яасан сайхан хэрэг вэ!” гэж боддог болсон байна.

8. Хэрэв та хөрвөсөн бол зарлигуудыг сахиж, буруу зан авираа зөвтгөх буюу зарлигуудыг сахижгүй байх шалтаг олохыг хичээхгүй болсон байна. Та үргэлж зөв зүйлийг хийдэг болж, зарлигуудыг сахиж нь зөв зам гэдгийг мэддэг болсон учраас тэдгээрийг хэнээр ч хэлүүлэлгүй сахьдаг болсон байна.

9. Хэрэв та хөрвөсөн бол аравны нэгээ төлөхийг тэсч ядан хүлээдэг болно. Та аравны нэгээ төлөх явдлыг онцгой боломж гэж үзэн 10 хувь нь өөрийн тань авсан

адислалууд болон ашиг орлоготой харьцуулбал тийм ч их биш гэдгийг ойлгодог болсон байна. Эдгээр адислалууд таны төлдөг мөнгөнөөс илүү их үнэ цэнэтэй юм.

10. Хэрэв та хөрвөсөн бол өөрийнхөө олсон үнэн хийгээд аз жаргалыг мэдэхэд нь бусдад туслахыг чин сэтгэлээсээ хүсдэг болсон байна. Сударт байдаг нэг сайн жишээ бол Лихайн зүүд юм. Тэр энэ зүүдэндээ амьдралын модны амтат жимсийг гэр бүлтэйгээ хуваалцах агуу хүсэлтэй байсан билээ. Тэр энэ жимснээс хүртсэн үед анх төрсөн бодол нь өөрөө ахиухныг авах биш харин гэрийнхэн нь бас уг жимснээс хүртэж, аз жаргалтай болохыг хүссэн явдал мөн (1 Нифай 8:12-ыг үзнэ үү).

Дүгнэж хэлэхэд илүү өндөр хууль болох Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч эхэлсэн үеэс тань таны хөрвөлт эхэлдэг. Та зөв шалтгаан, зөв учир үндэслэлээр, туйлын дуулгавартайгаар амьдардаг болсон байна. Та бүх талаараа сайн мэдээний дагуу амьдардаг болсон байна. Та сайн мэдээгээр амьдрах ёстой учраас биш харин үүнийг хүсдэг учраас үүгээр бүрэн дүүрэн амьдардаг болсон байх ёстой. Та аз жаргалтай, ач буянтай, Тэнгэрлэг Эцэг тань таныг ямар хүн болоосой гэж хүсдэг шиг тийм хүн болохыг хүсдэг болсон байна. Та Есүс Христтэй адилхан болохыг, Түүний үлгэр жишээг дагахыг хүсдэг болсон байх ёстой. Хэрэв та ийм хүн болсон бол та үнэхээр хөрвөсөн гэсэн үг. ■

Тайлер Ортон Индонезийн Ява арал дээр амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 8.1.3.
2. Эзра Тафт Бенсон “Pray Always” Лиакхона, 1990 оны 6-р сар, 4.

АЖЛАА СЭТГЭЛ ГАРГАН
САЙН ХИЙВЭЛ
**АШИГ ТУСЫГ
НЬ ХҮРТЭНЭ**

Үргэлж сэтгэл гарган хөдөлмөрлөвөл үр
дүнг нь үзээд бахархах болно

(Залуучуудын бат бөх байдлын төлөө [товхимол, 2011], х.40-41-ийг үзнэ үү.)



Дени эмээгийн бяцхан

НОМЛОГЧ

Эмилия Мария Гуймаррес Корреа

“Хүн Ариун Сүнсний хүчээр ярихад Ариун Сүнсний хүч үүнийг хүмүүний үрсийн зүрх сэтгэлд хүргэдэг” (2 Нифай 33:1).

Виктор ээж, эгч хоёртойгоо Дени эмээгийнхээ амьдардаг байлаа. Викторын эмээ өвчилж, хэдэн долоо хоногоор гэрээсээ гарч чадахгүй байлаа. Тэр өрөөндөө ганцаархнаа уйтгартай байдаг байлаа.

Виктор эмээдээ хань болж байхаар шийдэв. Тэгээд тэр өдөр бүр хичээлээсээ ирээд эмээгийнхээ өрөөнд орж *Лиахона* сэтгүүлээс хүүхдийн өгүүллүүдийг эмээдээ уншиж өгдөг болов.

Лиахона сэтгүүлийн өгүүллүүдийг тэр эмээдээ уншиж өгч дууссаны дараа Мормоны Ном, Библи хоёроос эмээдээ уншиж өгдөг болов. Дени эмээ Сүмийн гишүүн байгаагүй ч, Викторын уншиж өгсөн зүйл түүнд таалагддаг байлаа. Тэр сайн мэдээний тухай сонссондоо баяртай байлаа.

Эмээ нь олон асуулт асууна. Хэрэв Виктор өөрөө хариулж мэдэхгүй байвал Хүүхдийн Хэсгийн багшаасаа асуух юм уу, судруудаас хардаг байв. Эмээ

нь Викторын өөрийн бяцхан номлогч гэж нэрлэв.

Дени эмээ түүнээс олон зүйл сурч мэдсэн гэдгээ Викторт хэлжээ. Бие нь сайжрахаар түүнтэй хамт сүмд явна гэж эмээ нь амлажээ. Сурсан зүйл нь илүү сайн хүн болж, сайн мэдээний тухай улам их зүйлийг мэдэхийг хүсдэг болоход эмээд нь тусалсан ажээ.

Эмээ нь бие нь сайжирсан хойноо амлалтандаа хүрчээ. Тэр Викторын заасан зүйлийг улам сайн ойлгохын тулд түүнтэй хамт сүмд явдаг болжээ. Эмээ нь удалгүй баптисм хүртэж, гишүүнээр батлагджээ. Сайн мэдээ үнэн гэдгийг мэдэхэд нь Виктор түүнд тусалсан байна.

Виктор том болоод Массачусетсын Бостон номлолд бүрэн цагийн номлогчоор үйлчилжээ. Тэр явахаасаа өмнө Дени эмээтэйгээ хамт Ариун сүмд орсон гэнэ. ■

Эмилия Мария Гуймаррес Корреа Бразилын Федерал дүүрэгт амьдардаг.





**Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын**

Ахлагч М.Рассел Баллард

*Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын гишүүд бол Есүс
Христийн онцгой гэрчүүд юм.*

Сүм яагаад ийм урт нэртэй байдаг вэ?

Есүс Христ Өөрөө Сүмд энэ нэрийг өгсөн юм (Сургаал ба Гэрээ 115:4-ийг үзнэ үү).

Есүс Христийн Сүм гэдэг үгс энэ Сүм бол Түүний Сүм гэдгийг гэрчилдэг.

Хожмын Үеийн гэдэг нь энэ

Сүм дэлхий дээр амьдарч байхдаа Есүс Христийн байгуулсан Сүмтэй адилхан боловч хожмын өдрүүдэд сэргээгдсэн гэсэн утгатай юм.

Гэгээнтнүүд гэдэг нь бид Түүнийг дагаж, Түүний хүслийг биелүүлэхийг хичээн чармайдаг гэсэн утгатай юм.

Бид Мормоны Номонд итгэдэг учраас манай гишүүдийг *Мормончууд* гэдэг. Гэвч бид боломжтой л бол Сүмийн бүтэн нэрийг хэрэглэж байх ёстой. ■

"Нэрний чухал утга учир" Лиакхона, 2011 оны 11-р сар, 79–82-оос авав.



Дарси Женсен

1893 онд Солт Лейкийн Ариун сүм баригдаж дууссан нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд том баяр болов. Энэ Ариун сүмийг барихад 40 жил шаардагдсан юм. Ариун сүмийг барихад хүүхдүүд мөнгө хандивлаж байсан учир Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф хүүхдүүд оролцох адислалын таван тусгай цуглааныг зохион байгуулсан ажээ.

Өнөөдөр дэлхий даяар олон Ариун сүмтэй болсон бөгөөд хүүхдүүд Ариун сүм барьж дууссаны баярыг тэмдэглэхэд тусалсан хэвээр байна. Хүүхдүүд үүнд хэрхэн оролцдог тухай үзнэ үү. ■

Дарси Женсен АНУ-ын Калифорнид амьдардаг.

Солт Лейкийн Ариун сүмийг адислахад 12000 гаруй хүүхэд оролцжээ. Тэд Шугар Науз гадаснаас галт тэргээр ирсэн ажээ.



Галт тэрэгний энэ билетийг **Солт Лейкийн Ариун сүмийг** адислах тусгай цуглаануудад оролцох 16 хүртэлх насны хүүхдүүдэд олгодог байжээ. Төлөөлөгчид болон Тэргүүн Зөвлөлийн гишүүд Ариун сүм дотор хүүхдүүдэд хандан үг хэлдэг байжээ.



Заримдаа ариун сүмүүдийг шинэчлэн засварласны дараа дахин адисалдаг. **Аляскийн Анкораж Ариун сүмийн** адислалтыг тэмдэглэхэд хүүхдүүд дуу дуулж, соёлын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулсан билээ.



Аризоны Гилберт Ариун сүмийг баригдаж байх үеэр Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд тойргийнхоо хэн нэгэнд үйлчлэх зорилгыг долоо хоног бүр тавьж, хэрэгжүүлдэг байв.

Калифорнийн Сан Диего Ариун сүмийг баригдаж байх үед Мексикийн Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд Ариун сүмд зориулж алаг эрээн олбог хийсэн ажээ. Булангийн чулууг суурилуулах ёслолын үеэр Ерөнхий эрх мэдэлтнүүд уг олбогон дээр зогсож байжээ.



Ариун сүм байцдагт баярлацгаая!



Канадын Манитобагийн Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд Саскатчеваны Режина Ариун сүмийн хананд гараа хүргэж үзэхийн тулд гурван цаг машинаар явж ирэн, хожмын нэг өдөр Ариун сүмийн дотор орж үзнэ хэмээн шийджээ.

Украины Киевийн Ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаан дээр Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд зочдод зориулан “Би Ариун сүм харах дуртай” дууллыг дуулжээ.



Баруун Африкийн Хүүхдийн Хэсгийн 800 гаруй хүүхэд Ганын Аккра Ариун сүмийг адислах соёлын үйл ажиллагааны үеэр “Би Бурханы хүүхэд” дууг дуулжээ.



Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийг Нигерийн Аба Ариун сүмийг адислахаар ирэхэд нь Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд түүнд зориулан дуу дуулж өгчээ.



Ариун сүм бүрд адисалсан оныг нь сийлсэн булангийн чулуу байдаг. Ариун сүмийг адислахад Ерөнхий эрх мэдэлтнүүд булангийн чулууг зуурмагаар лацаддаг. 9 настай Айзик Б. Миссурийн Канзас хотын Ариун сүмийн булангийн чулууг лацахад тусалж байгаа нь.

Ариун сүмийн тухай асуулт, хариултууд

Бид яагаад Ариун сүмүүдийг адисалдаг вэ?

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Ариун Сүмүүд бол мөнхийн үнэнүүдийг мэдэж, ариун нандин ёслолуудад оролцдог ариун газар юм.

Ариун сүм дотроо ямархуу байдаг вэ?

Ариун сүм бол амар тайван, хүндэтгэлтэй, үзэсгэлэнт сайхан газар юм. Ариун сүмийн доторх юм бүхэн цэвэрхэн, эмх цэгцтэй байдаг. Бүх хүмүүс цагаан хувцас өмсөж, аяархан ярьдаг.

Ариун сүмүүдэд юу болдог вэ?

Эхнэр нь нөхөртэйгөө, хүүхдүүд эцэг эхтэйгээ лацдан холбуулж болно. Лацдан холболт нь гэр бүлүүдийг үүрд хамт байх

боломжтой болгодог. Ариун сүмд эрэгтэй, эмэгтэйчүүд хувийн хишиг хэмээн нэрлэгддэг сүнслэг бэлгийг хүлээн авдаг. Тэд бас Ариун сүмийн гэрээнүүд хийлгүйгээр нас барсан хүмүүсийн өмнөөс хувийн хишгийг нь хүлээн авч, лацдан холболт хийлгэж болно.

Ариун сүмд өөр юу болдог вэ?

Ариун сүмүүдэд лацдан холболт болон хувийн хишгээс гадна өөр ёслолууд хийгддэг. Амьд сэрүүн байхдаа Сүмд элсэх боломжгүй байсан хүмүүсийн өмнөөс бусад хүмүүс баптисм хийлгэж, гишүүнээр батлуулж болно. Хэрэв чи 12 нас хүрсэн бөгөөд зохистой бол сайн мэдээг сонсолгүйгээр нас барсан хүмүүсийн өмнөөс баптисм хүртэж, гишүүнээр батлуулах боломжтой.

Хэрэв манай гэр бүл Ариун сүмд ороогүй бол яах вэ?

Тэнгэрлэг Эцэг өөрийг чинь бас гэр бүлийг чинь мэддэг, хайрладаг. Тэр хүн бүрийг Ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахыг хүсдэг. Ариун сүмд орохоор зохистой амьдар. Нэгэн өдөр Ариун сүмд хувийн хишгээ авах, тэнд гэрлэх зорилгыг одооноос өөртөө тавь. Тэнгэрлэг Эцэг тань өөрт чинь болон гэр бүлд чинь туслах болно. ■



“Идэр насандаа яваа залуу найз нар минь, Ариун сүмийг зорилгоо болго. Ариун сүмийн хаалгаар орж, тэнд өгөгддөг ариун нандин, мөнхийн адислалуудыг хүртэхээс та нарт саад болох юуг ч бүү хий.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Ариун сүм—дэлхийн гэрэлт цамхаг,” *Лиахона*, 2011 оны 5-р сар, 93.

Гэр бүл үүрд хамт байх болно

(Хялбаршуулсан)

Үгийг Рут Мюур Гарднер
Аяыг Ванжа В. Воткинс

Хөгжилтэй ♩ = 80-96

1. На - дад өөр-ийн гэр бүл энд бий. Тэд на-майг их хайр - ла - даг.
2. И - дэр за - луу ба-га нас-наа-саа И - хэд би чар - майн бэлт-гэнэ.

Нас - аар - аа тэ - дэн - тэй хамт мөн - хөд амь - дар-маар бай-на би.
Ийн Бурх - ны а - риун сүмд мөн - хөд гэр - лэ - мээр бай-на би.

Дахилт

Тэн - гэр-лэг Эцэ - гийн маань тө-лөв-лөс - нөөр Бид үүрд хамт байх бол-но. Би

тэ-дэн-тэй-гээ үр-гэлж Хамт-даа бай-маар бай-на. Ийм-ээс на-дад юу хийх-ийг заа - сан. Их

Э - зэн юу хийх - ийг заа - сан.

Үг болон ая © 1980 IRI. Дуулал © 2012 IRI. Бүх эрх хамгаалагдсан.

Энэ дууг ашиг олох зорилгоор бус зөвхөн гэр орон болон сүмийн хэрэгцээнд зориулан хувилж болно.

Есүс Христ Өөрийн Сүмийг хожмын өдрүүдэд сэргээсэн



Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

Үнэт эрдэнэ олохоор явлаа гэж төсөөлөн бод. Тэрхүү үнэт эрдэнийг хаанаас, яаж олох вэ? Эрдэнэсийн хайрцаг байж болох уу? Дотор нь юу байх бол?

Үнэт эрдэнэсийн зарим хайрцагт эрдэнийн зүйлс, үнэт зооснууд байдаг. Харин Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бидэнд бүр илүү үнэтэй нэг нэг эрдэнэ байдаг энэ бол: Есүс Христийн сайн мэдээ юм.

Олон хүмүүс энэхүү үнэт эрдэнийн тухай мэддэггүй. Тиймээс бидний нэг үүрэг бол энэхүү үнэт эрдэнийг боломжийнхоо хэрээр аль болох олон хүмүүстэй хуваалцах явдал мөн.

Есүс болон Түүний Төлөөлөгчид нас барсны дараа сайн мэдээний зарим чухал сургаал болон ёслолууд, түүний дотор баптисм, санваарын эрх мэдэл, Ариун сүмүүд,

амьд бошиглогчид, ариун ёслол алга болсон буюу өөрчлөгдсөн юм.

Сайн мэдээний эдгээр бүх үнэт эрдэнэс Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн юм. Тэрээр үнэнийг мэдэхийн төлөө залбирсан үед Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Ариун ойн цоорхойд Иосеф Смит дээр хүрч ирсэн билээ.

Иосеф хожим нь алтан ялтсуудыг хүлээж аван, Мормоны Номыг орчуулсан юм. Мормоны Ном нь алдагдсан үнэнүүдийг тайлбарладаг учраас бид энэ номын агуулдаг сургаалуудыг үнэт эрдэнэстэй адил үзэж эрхэмлэн дээдэлдэг билээ. Сайн мэдээний энэ үнэнүүд бидэнд байгаа учраас бид олон адислал хүлээж авдаг.

Ямар гайхалтай үнэт эрдэнэс вэ! ■

СУДАР БА ДУУ

- Сургаал ба Гэрээ 35:17
- “Ариун ойн цоорхой” *Children’s Songbook*, 87 (эсвэл сайн мэдээний Сэргээлтийн тухай өөр дуу)

ЯРИЛЦАЦГААЯ

Есүс Христийн сайн мэдээний үнэт эрдэнэс гэр бүлийг чинь хэрхэн адисалсан тухай хуваалц.

САЙН МЭДЭЭНИЙ ҮНЭТ ЭРДЭНЭСИЙН ХАЙРЦАГ ХИЙ

Энэ үнэт эрдэнэсийн хайрцагийг хайчилж аваад нугалж хийнэ үү. Сайн мэдээ өөрт чинь өгсөн зарим үнэт эрдэнэсийг жагсаан бичсэн зооснуудыг хайчилж аван, хайрцагт хий. Сайн мэдээний адислалуудыг өөртөө сануулахын тулд хайрцаг доторх үнэт эрдэнэсийг байн байн харж бай.



Сүм хаана **ЗОХИОН** байгуулагдсан бэ?



Жан Пинбороу

Сүмийн сэтгүүлүүд

Сүмийн түүхэн дэх нэг чухал газрыг бидэнтэй хамт судлана уу!

Хэрэв Магги Лили хоёр Сүм хаана зохион байгуулагдсаныг мэдэхийг хүсвэл хол явах шаардлагагүй. Энэ нь ням гараг бүр тэдний сүмд явдаг газраас холгүй Нью-Йоркийн Фейетт дэх цуглааны байрны зэргэлдээх хаалга юм.

Сүм сүмийн барилга дотор биш, харин дүнзэн байшинд зохион



байгуулагдсан юм. Бошиглогч Иосеф Смит 1829 онд Витмерийнхэнтэй хамт түр хугацаагаар амьдрахаар энд хүрч ирсэн. Тэр үед байсан дүнзэн байшин энд байхгүй харин тэр газар дээр жижигхэн дүнзэн байшин дууриалган барьсан байгаа.


Магги, Лили хоёрын цуглаанд ирдэг сүмийн байранд Витмерийн гэр болон тэнд болсон үйл явдлуудтай холбоотой зүйлсийг дэлгэн тавьсан зочдын төв байдаг. ■

1. Иосеф Смит энд Мормоны Номыг орчуулж дуусгажээ.





2. Гурван хүн энэ байшингаас холгүй газар тэнгэр элч Моронай болон алтан ялтсуудыг харсан ажээ. Тэд ялтсуудыг харж, гэрчилсэн учраас Гурван гэрч хэмээн нэрлэгдсэн билээ. Та нар тэдний гэрчлэлийг Мормоны Номын эхний хуудаснаас үзэж болно.



3. 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд 60 орчим хүмүүс нэгэн онцгой цуглаанд ирсэн ажээ. Иосеф Смит Сүмийг албан ёсоор зохион байгуулж, ариун ёслолыг адислан түгээжээ. Энэ бол анхны ариун ёслолын цуглаан байв!

ТЭР ҮЕИЙН БОЛОН ОДООГИЙН БАПТИСМ

11-тэй Магги, 9-тэй Лили хоёр Сүмийн анхны гишүүд баптисм хүртсэн газрын ойролцоох баптисмын санд баптисм хүртжээ.

Хоёр охин хоёул баптисм хүртсэндээ сэтгэл нь их догдолсон гэнэ. Лили баптисм хүртэхдээ бишоптойгоо ярилцлага хийжээ. “Бишоп надаас бошиглогчийн тухай гэрчлэлтэй юү? Аравны нэгээ төлдөг үү? гэж асуусан” гэж Лили хэллээ.

Хоёр охин хоёул баптисмынхаа өдрийн талаар сайхан дурсамжтай байдаг ажээ. “Би баптисмын уснаас гарч ирэхдээ ямар ч зүйлийг хийж чадах юм шиг санагдсан” гэж Магги хэллээ.

Хоёр охин хоёул баптисмын талаарх сэтгэгдлээ тэмдэглэлдээ бичсэн ажээ.



4. Цуглаан дуусмагц Иосеф Смитийн эцэг эх хоёр болон бусад хэдэн хүн баптисм хүртэв.

Макс, Майя хоёр сайн зүйл хийсэн нь

Крис Деавер Техас, АНУ

Макс баатар эр болж харагдахад
бэлэн болж, богино ханцуйтай
улаан цамцаа, баатрын малгайгаа
өмсөөд, бяцхан эмэгтэй
дүүгийнхээ өрөө рүү очлоо.



“Майя, нааш ир. Хоёулаа өнөөдөр сайн зүйл хийе!” гэж Макс хэллээ.



Макс, Майя хоёр зочны өрөөнд орлоо. Тэнд сагс дүүрэн хувцас байхыг тэр хоёр харлаа.

“Та хоёр надад туслахгүй юу” гэж ээж нь асуув.

“Тэгье ээ. Бид хоёр өнөөдөр сайн зүйлийг хийхээр шийдсэн” гэж Макс хэлэв.



Макс, Майя хоёр бүх хувцсыг эвхэж, өрөөнүүдэд оруулахад ээждээ туслав.

Тэгтэл Макс шалан дээр хог байхыг олж харав. “Энэ хогийг авчихъя. Тэгээд явж сайн зүйл хийцгээе” гэж Макс хэллээ.



Макс, Майя хоёр гэр дотроо гүйдэн, нүдэнд харагдсан бүх хогийг түүж хаялаа.

Ээж нь гал тогооны өрөөний шал шүүрдэж байхыг тэр хоёр харав. “Бид хоёр ээждээ тусалж болно ш дээ” гэж Макс хэллээ.

Макс шал шүүрдэхэд Майя хогийн тосгуурыг барьж өглөө.



“За одоо явж сайн зүйл хийцгээе” гэж Макс хэлэв.

Ээж нь цэвэрхэн болсон гэрээ тойруулан хараад Макс, Майя хоёрыг чанга тэврэн “Та хоёр аль хэдийн сайн зүйл хийчлээ шүү дээ!” гэжээ. ■



ЕСҮС УСАН ДЭЭР АЛХСАН НЬ

“Нууран дээр алхаж яваа Түүнийг хараад шавь нар нь сандарч, энэ чинь хий үзэгдэл байна гээд айснаасаа болж хашгиралдав.

Харин тэр даруй Есүс тэдэнд, Зоригтой бай. Би байна. Бүү ай гэжээ” (Матай 14:26–27).

СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org-аас үзнэ үү.

Дэлхий даяарх удирдагчдын сургалтыг хөтлөн явуулах шинэ арга



**Ахлагч Л.Том
Перри, Ахлагч
Доналд
Л.Холстром
болон Бишоп
Дийн М.Дэйвийс
нар санваарын
түлхүүрүүдийг
ашиглахын ач
холбогдлын
талаар харил-
цан ярилцлагыг
явуулах болно.**

Ирэх саруудад Дэлхий даяарх удирдагчдын сургалтыг хөтлөн явуулах шинэ аргатай дэлхийн бүхий л сүмийн гишүүд танилцах болно.

Өмнөх сургалтуудаас ялгаатай нь энэ жилийн Дэлхий даяарх удирдагчдын сургалт нь тойрог, гадасны удирдагчдад зориулсан ганц удаагийн нэвтрүүлэг болохгүй. Харин энэ нь DVD-гээр есөн богино хэсэгт хуваагдаж, LDS.org—дээр тавигдах ба ирэх жилийн туршид болон цаашид удирдагчид, гишүүд, гэр бүлүүдийн ярилцлагыг дэмжих болно.

Уг сургалт нь “Санваараар дамжуулан гэр бүл болон Сүмийг хүчирхэгжүүлэх нь” сэдэвт төвлөрч байгаа. Сургалтанд Тэргүүн Зөвлөлийн гишүүд, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон бусад Ерөнхий эрх мэдэлтнүүд, ерөнхий албан тушаалтнууд дараах сэдвүүдээр сүнслэг зөвлөгөө өгөх болно:

- Гэр бүлүүд санваарын хүчээр дамжуулан хэрхэн хүч чадал, амар амгаланг олж болох тухай.
- Гэр бүл бүрт санваарын адислалуудыг хүртэхэд нь хэрхэн туслах тухай.
- Санваарын түлхүүр атгагч тэдгээр хүмүүс гэр орон болон гэр бүлүүдийг хэрхэн хүчирхэгжүүлдэг тухай.
- Христийнхтэй хэрхэн тохинуулах тухай.
- Хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хэрхэн хүмүүжүүлэх тухай.

Сүмийн бүх нэгж DVD-ний хуулбарыг хүлээж авах ба тойрог, гадасны зөвлөлүүд үүнийг бүхэлд нь үзэх шаардлагатай. Улмаар тэд тойрог, гадасны гишүүдийг уг заавраас ашиг тус авахад нь хэрхэн туслах талаар хоорондоо зөвлөлдөх хэрэгтэй.

Гишүүд цуглаан болон ангиудад DVD-ний аль нэг хэсгийг үзэж ярилцаж болно. Гэр бүлүүд сурах аргаа сайжруулахын тулд www.lds.org дээрх нэмэлт эх сурвалжуудтай хамт DVD-г судлах хэрэгтэй.

Бүх нөхцөл байдалд уг сургалтын хамгийн хүчирхэг хэсэг нь DVD-г үзэж, ярилцлага өрнүүлж эхлэх үед ирэх болно. Удирдагчид, гишүүд, гэр бүлүүд сонсож, мэдэрсэн зүйлээ тунгаан бодож, хуваалцаж, гэрчлэх үед Ариун Сүнс тэдэнд нөлөөлж, сурсан заавруудаа хэрхэн өөрсдийн нөхцөл байдал, амьдралд хэрэгжүүлэхийг заах болно. Эдгээрийг хийснээр Дэлхий даяарх удирдагчдын энэ сургалт дэлхий дээрх гэр бүлүүд болон Сүмийг хүчирхэгжүүлэхэд туслах болно. ■

Мэри Фийлдинг Смитийн байшингийн гадаа This Is the Place Heritage Park буюу Энэ бол Өвийн Газар гэдэг цэцэрлэгт хүрээлэнд Ахлагч М.Расселл Баллард, Линда К.Бөртөн, Ахлагч Роналд А.Расбанд, Элэйн С.Далтон, Рөүзмэри М.Виксом, Бишоп Гари И.Стивенсон нар гэр бүл бүрт санваар байх адислалын талаар ярилцах болно.



ИЛҮҮ ОЛОН НОМЛОГЧ НАРЫН ДУУДЛАГАД ХАРИУЛАХ НЬ:

Гэр орон болон Сүмд номлогчийн зан байдлыг бий болгох нь

Хээдер Витл Ригли

Сүмийн мэдээ ба үйл явдлууд

Аргентиний Буэнос Айрес Конгресо гадасны Паркэ Чакабуко тойргийн бишоп Виктор Ногалесын ширээний ард тойргийнх нь 37 залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн зургийг өлгөсөн мэдээллийн самбар байдаг бөгөөд тэднээс номлолд явах бүр бишоп зурган дээр нь тэмдэглэгээ хийдэг гэнэ.

“Залуучууд маань миний албан өрөөнд орж ирээд, зураг болон тэмдэглэгээнүүдийг хараад ихэд баярладаг. Энэ нь тэднийг номлолдоо бэлтгэхийг урамшуулдаг” хэмээн тэр хэлсэн юм.

Буэнос Айресийн уг тойрог номлолын ажлын сүнсийг үлгэр жишээгээрээ харуулдаг юм. 2012 оны эхний зургаан сар гэхэд 19 өсвөр үеийнхэн найман өөр улсад бүрэн цагийн номлолд үйлчлэхээр явсан байна. Тэдний 14 нь хөрвөгчид байсан юм. Номлолд үйлчлэх боломжтой залуусын 80-аас дээш хувь нь номлолд үйлчлэх үүрэг амлаат хүлээжээ.

Сүүлийн жилүүдэд Сүмийн удирдагчид номлолд илүү олон залуусыг үйлчлүүлэх хэдэн хүсэлт гаргасан байна.

Сүм *Миний сайн мэдээг номло:* *Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж*-г хэвлэж гаргасны дараахан буюу 2005 оны 4-р сарын ерөнхий чуулганы үеэр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч

М.Расселл Баллард гэр бүлүүд болон удирдагчдад номлолын сүнсийг бий болгож, илүү олон залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хэн гэдгээ ойлгоход нь тусалж, сургаалыг зааснаар номлолд нэр хүндтэйгээр үйлчлэхэд нь бэлтгэхийг зөвлөжээ (“One More,” *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 69-г үз).

2012 оны 10-р сарын ерөнхий чуулганаар Ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн номлолын насыг залуужуулах хэрэгтэй гэсэн мэдэгдэл нь Их Эзэн Өөрийн ажлаа яаруулж байгаагийн нэг сануулга болсон билээ.

Өнөөдөр маш олон гэр бүлүүд болон Сүмийн удирдагчид эдгээр захиасуудыг нухацтайгаар хүлээн авч, өөрсдийн амьдарч буй газар бүртээ номлолын үйлчлэлийн агуу уламжлалыг бий болгож байна.

Өсвөр үеийнхэнд хэн гэдгээ ойлгоход туслах нь

“Та хэрхэн ийм олон өсвөр үеийнхнийг номлолд үйлчлэх хүсэлтэй байхаар бэлтгэж чадсан юм бэ?” хэмээх асуултанд Бишоп Ногалес “Би анх бишопоор дуудагдахдаа хамгийн эхлээд тойргийнхоо залууст анхаарал хандуулсан. Мөн бусад тойргийн удирдагчдад бид тэдний амьдралын нэг хэсэг болох ёстой гэдгийг ойлгуулсан” гэжээ.

Жишээлбэл, Чакабукогийн бүх номлогч нар номлолд гарахаасаа өмнө тойрогтоо дуудлагатай байсан. Ихэнхдээ шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдийг багшаар үйлчлэхийг урьдаг байсан ба энэ нь тэдэнд сайн мэдээг заахад бэлтгэгдэхэд тусалсан юм.

Бишоп Ногалес мөн өсвөр үеийнхнийг номлолд сүнслэгээр бэлтгэхээр орон нутгийнхаа бүрэн цагийн номлогч нартай хамт ажиллах зохицуулалт хийжээ.

Орон нутгийн Сүмийн удирдагчид болон гишүүд өөрсдийгөө тойргийнхоо өсвөр үеийнхнийг дэмжихэд зориулснаар номлолын сүнс агуу ихээр өсч буйг харсан байна.

Номлогчид төвлөрсөн гэр бүл

АНУ-ын Юта мужийн Дрэйпер хотын Гард болон Элойс нар номлогчид төвлөрсөн гэр бүл гэдэг нь ямар утгатай болохыг мэддэг ажээ. Тэдний 17 ач, зээ нь номлолд үйлчилсэн бөгөөд тэд өөрсдөө зургаан номлолд үйлчилжээ.

Номлолын үйлчлэлийн сүнсийг гэр бүлдээ бий болгох нь хүүхдүүдийг бүр бага балчир байхад нь эхэлдэг зүйл гэж Андрус ах хэлжээ.

Андрус эгч “Номлолд үйлчлэх талаар ярихгүй өнгөрч болохгүй бөгөөд та өөрийн хүүхдүүд, ач зээ нартайгаа ярилцахдаа тэднийг номлолд үйлчлэнэ гэдэгт итгэж, үүнийг хүсч байгаагаа илэрхийл. Та тэдэнтэй ярилцахдаа *хэрвээ* чамайг номлолд явбал гэхийн оронд чамайг номлолд явах *үед* гэж ярь” хэмээжээ.

Өсвөр үеийнхэнд номлолын үйлчлэлийн үлгэр жишээгээр дамжуулан хэн гэдгийг нь ойлгуулах нь мөн адил чухал билээ. Андрус ах эгч



Бишоп Виктор Ногалес номлолд үйлчилж буй тэдний зургийг оролцуулсан тойргийнхоо бүх өсвөр үеийнхний зурагтай мэдээллийн самбарын өмнө суудаг байна.

хоёр тэдний бага хүүг номлолд явах үед буюу 1980 онд анхныхаа дуудлагыг хүлээн авчээ.

Нэг ач хүү нь тэднээс номлолд бэлтгэхэд нь тусалсан бэлгийг хүлээж авсныхаа дараа захиа бичжээ. Андрес эгч “тэр бидний бэлгэнд баярласнаа илэрхийлсэн бөгөөд ‘бүр илүү чухал нь та нарын үзүүлсэн үлгэр жишээнд баярлаж байна’ хэмээн хэлсэн” гэжээ.

Сургаалыг заах нь

Ахлагч Баллард “Манай өсвөр үеийнхэн эцэг эх, Сүмийн удирдагч, багш нартаа Есүс Христийн сайн мэдээг мэддэг мөн ойлгодог гэдгээ харуулахыг хүсдэг. Ариун Сүнс тэдний зүрх сэтгэлд үнэнийг гэрчилж, тэдний бодгольд Христийн гэрлийг асаах болно. Ийн та *дахиад* нэг бүрэн бэлтгэгдсэн номлогчтой болох болно” хэмээн хэлжээ.

Буэнос Айресаас 9,600 орчим километрийн зайд орших АНУ-ын Айдахо мужийн Бойсигийн ойролцоох хөдөө тосгоны Хоршүү Бенд салбарын удирдагчид болон гэр бүлүүд нь өсвөр үеийнхэндээ сайн мэдээг заахад хичээл зүтгэл гаргаснаар номлолын номлолын үйлчлэлийн тоо нь эрс өсчээ.

75 гишүүнтэй жижигхэн салбараас есөн залуу номлолд үйлчилж байна.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Расселл М.Нелсон үйлчлэх шалтгаан болон үйлчлэхийн ач холбогдлыг онцолжээ. “Бүх номлогч бусдын амьдралыг өөд нь татах нэг л хүсэлтэй үйлчилдэг. Номлолд үйлчлэх шийдвэр нь номлогчийн сүнслэг хувь заяанд болон түүний эхнэр, нөхөр, үр удамд нь нөлөөлөх болно. Үйлчлэх хүсэл нь тухайн хүний

хөрвөлт, зөв зохистой байдал, бэлтгэлээс ирэх ёстой үр дүн юм” (“Номлогч нараас асуу! Тэд танд тусалж чадна!” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 18).

Эмметт Айдахо гадасны ерөнхийлөгч Мартин Волкор үүнтэй санал нийлжээ. “Номлолд үйлчлэх нь залуу хүмүүсийн ирээдүй, хойч үед нь нөлөөлөх болно. Гадасны хувьд бид залуусыг номлолын үйлчлэлд бэлтгэхэд чадах бүхнээ хийдэг” гэж тэр хэлжээ.

Өсвөр үеийнхэнд сургаалыг заах нь уг бэлтгэлийн нэг хэсэг юм. Хоршүү Бенд салбарын номлогчийн бэлтгэл ангийн өсвөр үеийнхэнд номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байсан хүнээр долоо хоног бүр хичээл заалгадаг гэнэ. Мөн номлолын бэлтгэл ажилд гадасны өсвөр үеийнхэнд зориулсан сар тутмын номлогчийн бэлтгэлийн уулзалт болон Аароны Санваартнуудын жил бүрийн аялал багтдаг байна.

Андрес ах эгч хоёрын зургаан хүүхдийнх нь нэг болох Ларен Адам 2007-оос 2009 онд нөхөр Жимийн хамт Дани улсын Копенгаген номлолд үйлчилжээ. Тэрээр гэр орондоо хүүхдүүддээ сайн мэдээг заахын ач холбогдлын талаар гэрчилжээ.

“Хүүхдүүддээ номлолын ажлын гэрчлэлтэй болоход нь туслахын тулд та нарын хийж чадах хамгийн агуу зүйлүүдийн нэг бол гэр бүлийн үдшээ хийж, гэр бүлээрээ судар судлах явдал юм. Хэрэв та тэдэнд сайн мэдээний мэдлэг болон сайн мэдээг судлах хүчирхэг суурийг тавьж өгвөл тэд илүү сайн бэлтгэгдэж, сайн мэдээний талаар илүү ихийг мэдэх болно.” ■

Сүмийн-Үйлчлэлийн залуу номлогч нар үйлчлэлээс баяр баясгаланг олж байна

Каролин Картер

Сүмийн мэдээ ба үйл явдлууд

Ахлагч Эрнесто Сарабиа номлолдоо хар өнгөтэй нэрийн тэмдгээ өдөр бүр зүүдэг байсан. Түүний номлолын үүрэг даалгавар бусдынхаас өвөрмөц байсан бөгөөд тэрээр Мексикийн Хермосиёо номлолын албанд Сүмийн-Үйлчлэлийн залуу номлогчоор үйлчилсэн юм.

“Зарим залуу эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд маань бүрэн цагийн номлолын стресс, сорилт бэрхшээлтэй тулгарах нь ухаалаг хэрэг биш байж магадгүй. Гэсэн ч энэ нь тэд

номлолын үйлчлэлийн адислалыг хүртэж чадахгүй гэсэн үг биш юм”
 (“One More,” *Liahona*, May 2005, 69) хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард хэлжээ.
Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Расселл М.Нелсон “номлол нь Бурханд болон хүн төрөлхтөнд үйлчлэх сайн дурын үйлдэл”

(“Ask the Missionaries! They Can Help You!” *Лиахона*, 2012 оны 11-р сарын 18) бөгөөд энэхүү үйлчлэлийг үзүүлэх олон арга зам байдаг гэжээ.

Хүндэтгэх шалтгааны улмаас бүрэн цагийн номлолд үйлчлээгүй, эсвэл номлолоосоо эрт буух ёстой болсон залуусын хувьд, Сүмийн-Үйлчлэлийн залуу номлогч хөтөлбөр нь номлолын утга учиртай туршлагыг өгөх болно.

Үйлчлэлд тавигдах шаардлагууд

Сүмийн-Үйлчлэлийн залуу номлогч нь эрүүл мэнд, оюун санаа, сүнслэг байдал, сэтгэл санааны хувьд энэхүү сайтар анхаарч томилогдсон дуудлагынхаа үүрэг хариуцлагыг гүйцэтгэх чадвартай байх ёстой.

Сүмийн-Үйлчлэлийн залуу номлогч нь 6-аас 24 сарын хугацаанд эсвэл долоо хоногт хэдэн өдрөөр буюу бүр бүрэн цагаар үйлчилж болдог. Гэрээсээ болон нийгэм хамт олны дунд үйлчлэх боломжтой байдаг. Сүмийн-Үйлчлэлийн залуу номлогчийн үүрэг даалгавар нь гэр бүлийн түүхийн хайлт, мэдээллийн технологи, номлолын албаны туслах, бишопын агуулах болон өөр бусад даалгавруудыг гүйцэтгэдэг.

Гэр бүл болон санваартнуудын дэмжлэг

Эцэг эхчүүд, санваартны удирдагчид болон Сүмийн гишүүд Сүмийн-Үйлчлэлийн залуу номлогчоор үйлчлэх боломжтой залуусыг номлолд бэлтгэхэд нь тусалж чадна.

Элиза Жой Янг эгчийн гэр бүл нь түүнд хүчирхэг тусалцаа үзүүлж байсан ба түүнийг Австралийн Сидней дэх Сүмийн албанд хүргэж өгч, авдаг байжээ.

Хонг Конгийн Хангамжийн Төвд ажилладаг Ахлагч Майкл Хиллам “Манай өглөөний семинарын багш нар болон Залуу Эрэгтэйчүүдийн удирдагчид намайг бэлтгэхэд их тусалсан” гэжээ.


Золиослол адислал авчирдаг

Янг эгч өөрийнхөө хагас цагийн ажлаа Сүмийн үйлчлэлийн номлолд үйлчлэхийн тулд золиосолжээ. Тэрээр “Би Тэнгэрлэг Эцэгтээ үйлчилж байгаа гэдгээ мэдсэнээр Түүнд илүү ойртдог” гэж хэлжээ.

Сүнслэг адислалуудаас гадна Сүмийн үйлчлэлийн номлолд үйлчлэх нь залуу номлогч нарт үнэ цэнэтэй мэргэжлийн болон олон нийттэй харилцах боломжуудыг олгодог. “Номлол маань ямар нэг онцгой тусламж авалгүйгээр бие дааж ажил эрхлэх боломжтой гэдгийг надад харуулсан юм” хэмээн Янг эгч хэлжээ. (Тэр өмнө нь зөвхөн хэн нэгний тусламжтайгаар ажилладаг байжээ.)

Хэдийгээр үйлчлэхийг хүсч буй залуу насанд хүрэгчдийн зарим нь үйлчлэх боломжгүй байж болох ч бүх зохистой залуу насанд хүрэгчдийг үйлчлэх боломжоор хангахын тулд агуу хичээл зүтгэлийг гаргадаг юм. Энэ замаар үйлчлэхийг хүсч буй залуу эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд өөрсдөд нь тохиромжтой боломжуудыг олж өгөхийг бишоп эсвэл салбарынхаа ерөнхийлөгчтэй ярилцаж болно.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг авахын тулд “Young church-service missionaries” гэж news.lds.org-оо хайж болно. ■



Залуу эмэгтэйчүүд болон Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхий удирдагчид Азийн бүсээр зочлов

Азийн бүсийн хэвлэл мэдээллийн мэргэжилтэн Бренда Франдсен
Дэвид О.Хийпс, Паул Стевенс, Линда Рае Понд Смит нараас тусламж авав

2012 оны 11-р сард есөн өдрийн турш Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Мэри Н.Күк болон Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Линда С.Рийвс нар Азийн бүс даяарх залуу болон ахмад бүх эгч нарт заавар зөвлөгөө өгч, сүнслэгээр урамшуулжээ.

Уг айлчлал нь *Ирээд, Намайг дага* хэмээх өсвөр үеийнхний сургалтын материалыг зарлах үеэр явагдсан байна. Уг сургалтын материалыг 2013 оны 1-р сараас эхлэн Залуу эрэгтэйчүүд, Залуу эмэгтэйчүүд болон өсвөр үеийнхний ням гарагийн ангид үзэх болно. Энэ шинэ сургалтын материал нь багш нарт Аврагчтай илүү адил заах мөн ангийн гишүүдтэйгээ илүү бат бөх харилцааг бий болгоход туслахад зориулсан юм.

Күк эгч болон Рийвс эгч нарын айлчлалын дараа Азийн олон өсвөр үеийнхэн болон тэдний

Мэри Н.Күк болон Линда С.Рийвс нар Тайланд байхдаа бүсийн эрх мэдэлтнүүд болон Тайваны санваартны удирдагчид, гишүүдтэй уулзжээ.

эцэг эхчүүд амьдралаа цэвэршүүлж, өөрчлөн нийгэмдээ үлгэр жишээ болох хүсэлтэй болсон байна.

Рийвс эгч Хонг Конгд байхдаа өсвөр үеийнхэнд “Хэрэв та нар амьдралдаа цэвэр ариун байх юм бол хэний ч өмнө итгэлтэй зогсож чадна” гэж амласан байна.

Түүний үгнээс урам зориг авсан 12 настай Танг Как Кей цуглааны дараа “Би Мормоны Номыг өдөр бүр унших ёстой гэдгээ мэднэ. Наманчилж, зөв шударга амьдарч сурахыг *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол надад заасан бөгөөд ингэснээр Христийн гэрэл хийгээд жинхэнэ аз жаргал намайг дүүргэх болно” гэжээ.

Күк эгч Энэтхэгт байхдаа Энэтхэгийн Чен-най дүүргийн шинэ цуглааны байран дахь гишүүд болон шинээр байгуулагдсан Хидерабад гадасны гишүүдтэй уулзжээ. Тэрээр залуучуудыг ирээдүйдээ бэлтгэлтэй байхыг зөвлөжээ. Тэрээр “Өөрсдийгөө боловсролоор цэнэглэ. Өөрсдийгөө хаант улсыг байгуулахад туслах чадваруудаар цэнэглэ. Гэр бүлдээ мөн тэднийг адислахын төлөө хийж чадах зүйлст анхаарлаа хандуул. Мөн сүнслэгээр бэлтгэхэд анхаар. Ингэснээр та тэдгээр сүнслэг өдөөлтүүдийг авах зохистой байж, хаашаа явж, юу хийхээ мэдэх болно” гэжээ.

Рийвс эгч Индонезид байхдаа Индонезийн шинээр байгуулагдсан Суракарта гадасны анхны чуулганд оролцжээ. Тэрээр “Бид тэдний даруу, хайраар дүүрэн сүнсийг мэдэрсэн. Ямар гайхалтай итгэлтэй гишүүд вэ!” гэж хэлжээ.

Мөн Рийвс эгч Малайзд айлчилж, Нийгмийн Халамжийн бүлгийн хэсэг эгч нартай ярилцжээ. Тэд Малайз дахь Нийгмийн Халамжийн бүлгийн байгууллагын хувьд авч үзэх онц чухал асуудлууд болон Сүм хэрхэн удирдамж, илэрхийлэлт өгч болох талаар хэлэлцжээ.

Рийвс эгч Тайланд байхдаа орон нутгийн гишүүдийн хүч чадал, үнэнч байдлыг онцолжээ. Тэрээр “Бид эндхийн гишүүд итгэлтэйгээр амьдарч, ариун сүмд тогтмол ордгийг мэдээд маш их баяртай байна. Тэд найз нөхөд, хөршүүддээ хайраар дүүрэн үлгэр жишээ болж байна” гэжээ. ■



ЯНГ ЧЕЙ ВЕНИЙ ГЭРЭЛ ЗУРАГ



Дэлхий даяарх өсвөр үеийнхэн хэрхэн ариун газруудад зогсож буйгаа харуулж байна.

Өсвөр үеийнхний гэрэл зургийг авах хүсэлт

Энэ жилийн Мючелийн сэдэв бол “Ариун газруудад зогсогтон та нар, мөн бүү шилжин нүүлгэгд” (С ба Г 87:8) юм. Залуу эрэгтэй, эмэгтэйчүүд ээ, *Лиахона* ариун газруудад зогсож буй та нарын гэрэл зургийг хайж байна. Гэрэл зургуудад гэр бүлтэйгээ хамт байгаа, үйлчлэл болон номлолын ажил хийж, уран бүтээл хийж, сайн мэдээг суралцаж, байгаль дэлхийг шинжиж байгаа болон өөр бусад зургууд орж болно. Энд зургаа хэрхэн явуулах талаар бичлээ:

- Ариун газар зогсож буй гэрэл зургаа хэн нэгнээр авахуул.
- Тэгээд өндөр нарийвчлалтай зургаа liahona@ldschurch.org вэб сайт руу явуулна уу.
- Энэ нь яагаад таны хувьд ариун газар болохыг тайлбарласан захиасыг хавсаргана уу.
- Э-мэйлдээ овог нэр, төрсөн огноо, тойрог болон гадасны нэр (эсвэл салбар болон дүүргийн нэр), эцэг эхийнхээ э-мэйл хаягийг бичээрэй.

Дэлхий даяарх өсвөр үеийнхний гэрэл зургийг дараагийн сэтгүүлд нийтлэх болно.

Төлөөлөгч Мароккод айлчлав

2012 оны 12-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри

Р.Холланд Өмнөд Африкийн Сьерра Леонед Сүмийн 3000 дахь гадсыг байгуулсныхаа дараа Мароккогийн Рабатын алслагдсан жижиг салбарт айлчилжээ.

Ахлагч Холланд Ням гарагийн оройн онцгой цугларалтын үеэр Сүмийн удирдагчид дэлхий даяарх гишүүдийг хэр алслагдсан болон хэр цөөхөн гишүүдтэй газар байгаагаас үл хамааран хайрладаг гэдгийг онцолжээ.

“Та нарыг мартаагүй ээ. Та нар бол Их Эзэний энэ эцсийн агуу эрин үе дэх Израилын цугларалтыг тогтоож мөн түргэсгэх гайхамшигт ажлын нэг хэсэг юм.”

Тегусигалпа Гондурас Ариун Сүмийг онцгойлон адислав

2013 оны 3-р сарын 17-ны ням гарат соёлын арга хэмжээ болон гурван долоо хоногийн нээлттэй хаалганы өдөрлөгийн дараа Тегусигалпа Гондурас Ариун Сүмийг гурван хуралдаанаар онцгойлон адисалжээ. Уг онцгойлон адислалтыг Гондурас болон Никарагуа дахь Сүмийн бүх нэгжүүдэд нэвтрүүлсэн байна.

Гватемала хотын Гватемала Ариун Сүм рүү хэдэн цаг аялдаг байсан Гондурасын гишүүд анхны ариун сүмээ онцгойлон адислагдахыг хараад баяртай байлаа. Ариун Сүмийг анх 2006 оны 6-р сарын 9-нд Тэргүүн Зөвлөл зарласан бөгөөд 2009 оны 9-р сарын 12-нд Ариун Сүмийн одоогийн байгаа газрыг хөндөх ёслол болжээ.

Ерөнхийлөгч Монсон Германд айлчлав

2012 оны сүүлээр Ерөнхийлөгч Томас С.Монсон Германд айлчлан Гамбург, Берлин, Мюнхен, Франкфурт дахь Сүмийн гишүүдтэй уулзаж, тэднийг Есүс Христийг дагахыг уриалжээ.

Тэрээр Франкфурт дахь гишүүдэд “Тэр бусдыг өршөөснөөр өршөөлийг заасан. Тэр нигүүлсэнгүй байдлыг нигүүлсэнгүй байснаар заасан. Мөн Тэр Өөрийгөө өгснөөр бүхнээ зориулах үнэнч байдлыг заасан юм” гэжээ.

Ариун Сүнс надад заадаг

Манай гэр бүл Сүмд нэгдсэнээс хойш би *Лиахона*г уншсанаар ирдэг хүч чадлыг мэдэрсэн. Эдгээр хүчирхэг үгсээр дамжуулан би номлолд үйлчлэх урам зоригтой болсон. Уг сэтгүүлд маш олон сэдвүүдийн талаар ярилцдаг боловч хамгийн чухал нь Ариун Сүнс надад үүнийг унших бүрт заадаг явдал юм. Бид заасан зарчмуудыг суралцаж, уншиж, амьдралдаа хэрэгжүүлснээр бүр “дайсны газар нутагт” (see Boyd K. Packer, “How to Survive in Enemy Territory,” *Liahona*, Oct. 2012, 24) хүртэл эрх чөлөөтэй байж чадна. Аврагч амьд, дэлхий дээр санваар бий. Бурхан тэнгэрт байгаа.

Ньютон Т.Синьянг, Уганда

Залруулгууд

2012 оны 10-р сарын *Лиахона* 76, 77р хуудсан дээрх “Энэтхэгт анхны гадас байгуулагдлаа” сэдвийн зургуудыг Глейдс Вигг эгч авсан юм. Бид зурагчинг буруу зарласан бөгөөд уг алдааг гаргасандаа хүлцэл өчиж байна.

2012 оны 12-р сарын *Лиахона* 36-р хуудсанд байгаа “Ариун өөрчлөлт” сэдэвт гарсан Вижилийн гэр бүл 2011 оны 6-р сард биш харин 2010 оны 7-р сард баптисм хүртсэн юм. Мөн Андрэа Вижил 2012 оны найман сард биш харин долоон сард төрсөн юм.

Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалд: *Лоренза Снөү*, 2 дахь хуудасны зурган дээр нэр нь тавигдаагүй. Энэ бол Ерөнхийлөгч Снөүгийн хүү, Оливер Годдард Снөү юм. Мөн 28-р хуудасны гарчган дээр Бага Бригам Янг болон Францис М.Лиман нарын нэрийг сольж тавих хэрэгтэй.

УСАН ОРГИЛУУРААС УУХ НЬ

Аарон Л.Вест

Сүмийн хэвлэлийн албаны редактор

Бид Ариун сүмийн үзэсгэлэнт сайхан байдлын тухай ихэвчлэн шовх оройт ганжир, цонхнууд, ханын зурагнуудын тухай ярьдаг. Бид баптисмын сан, хишгийн өрөө, лацдан холболтын болон селестиел өрөөнүүдийн тухай хүндэтгэлтэйгээр ярьдаг.

Гэвч бошиглогч Ариун сүмийг Их Эзэнд адислахдаа хүн бүхний нүдэнд тусдаг үзэсгэлэнт хэсгүүдийг биш харин барилгыг бүхэлд нь адисалдаг. Ерөнхийлөгч Томас С.Монсон Миссурийн Канзас Хотын Ариун сүмийг адислахдаа: “Бид энэ Ариун сүмийн баригдсан газрыг адисалж байна. Бид энэхүү үзэсгэлэнт барилгын хэсэг бүрийг, үл харагдах сууринаас эхлэн Моронайн сүрлэг дүрс зогсож байгаа оройн хэсгийг хүртэл адисалж байна” гэж хэлжээ.¹ Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит Ютагийн Огдены Ариун сүмийг адислахдаа: “үүний суурийг, ханануудыг, шал, тааз, цамхаг болон барилгын бүх хийц хэсгүүдийг адисалж, техникийн бүх хийц хэсгүүд, гэрэлтүүлгийн болон салхивчийн системийн эд ангиуд, цахилгаан шат болон барилгын бусад бүх зүйлийг хамгаалагдахын төлөө залбирсан ажээ.”²

Ариун сүм бүрийн бүх зүйлийг адислахаар бошиглогчдодоо сүнсэлгээр нөлөөлдөгт нь би Их Эзэнд талархалтай байдаг. Хаалганы нугас, гэрлийн бэхэлгээ зэрэг нь лацдан холболтын өрөөн дэх тахилын ширээнээс ач холбогдлоороо бага ч гэсэн



*Есүс Христ
бол амьд усны
оргилуур мөн.*

эдгээр өчүүхэн жижигхэн зүйлс Ариун сүмийн тэнгэрлэг зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Ариун сүмийн эдгээр жижиг хэсгүүдийн нэг нь сэтгэлд хоногшсон нэг зүйлийг сурахад надад тусалсан юм. Нэг өдөр би Солт Лейкийн Ариун сүмд нас барагсдын өмнөөс хийсэн ёслолд оролцсоны дараа гэр рүүгээ явах гэж байв. Ус уух цоргыг хараад ус уухаар цорго руу бөхийтөл:

Та Ариун сүм дотор энэ уснаас ууж байна. Гэвч та энд байдаг амьд уснаас үнэхээр уудаг уу? гэсэн үгс гэнэт санаанд орж ирлээ.


Энэ нь ноцтой зэмлэл биш ч гэсэн зөөлхөн сануулга, зүрх сэтгэлд шингэсэн асуулт байлаа.

Энэ асуултад би үгүй гэж хариулсан. Ариун сүмийн амьд уснаас би хангалттай хэмжээгээр уугаагүй байлаа. Хэдэн минутын өмнө нас барагсдын төлөө ёслолууд хийлгэж байхдаа би сайн мэдээтэй холбоогүй зүйлсийн талаар бодож байсан шүү дээ. Миний тусламж хэрэгтэй байсан хүмүүст туслахын тулд би сайн ажил хийсэн ч, өөртөө хэрэгтэй байгаа бүх тусламжийг хүлээн авах боломжоор өөрийгөө хангаагүй байлаа.

Одоо би Ариун сүмд орох бүрдээ усны цоргыг хараад зогсож ус уудаг болсон. Амьд усны оргилуураас би хэр зэрэг хангалттай ууж байгаа билээ? гэж өөрөөсөө асуудаг. Энэ асуултад би: Төдийлөн хангалттай биш хэмээн хариулсан хэвээр байгаа ч би илүү их цангасаар байна. ■

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон “Kansas City Missouri Temple: ‘Beacon of Divine Light’—an Offering of Hands and Hearts,” *Church News*, 2012 оны 5-р сарын 12, ldschurchnews.com.
2. Жозеф Фиелдинг Смит “Ogden Temple Dedictory Prayer” *Ensign*, 1972 оны 3-р сар, 12.



АЛБАН ТУНХАГ

ВИЛФОРД ВУДРАФФ

Вилфорд Вудрафф 1840-өөд оны үед Их Британид номлолд үйлчилжээ. Түүний үйлчлэлийн үр дүнд 1,000 гаруй хүн **баптисм хүртсэн байна**. Вилфорд Вудрафф хожим нь Ютагийн **Сейнт Жоржийн Ариун сүмийн** ерөнхийлөгчөөр үйлчилж байв. Тэр Сүмийн Ерөнхийлөгчийн хувьд **Ютаг** биеэ даасан муж болгохын төлөө зүтгэсэн юм. Тэрээр илчлэлт хүлээн авч, олон эхнэр авах ёсыг зогсоохыг зааварласан **Албан Тунхаг 1-ийг** гаргажээ.



Хүжигчид Есүс Христийн амьдралын тухай видеонууд бүтээж biblevideos.lds.org-м тавьсан байна; Аврагчийн амьдралын сүүлчийн долоо хоногийн нэлээд хэдэн үйл явдлын тухай 26-р хуудсан дахь өгүүлэлд өгүүлжээ. Ахлагч Рассел М.Нелсоны “Есүс Христийн үүрэг зорилго ба үйлчлэл” (хуудас 18) өгүүлэлд амьдралдаа бидний даган дууриах ёстой, Аврагчийн үйлчлэлийн дөрвөн зүйлийн тухай заажээ.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ